ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР

НИСЭХИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАНГАЛТ-ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧИГ

Баримт бичгийн код:	Зам, тээврийн сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын хамтарсан тушаал А/17, А/125
Батлагдсан огноо:	2026-01-22

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД, БАЙГАЛЬ ОРЧИН,
УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2026 оны 01 сарын 22 өдөр Дугаар А/17, А/125 Улаанбаатар хот

Техникийн баримт бичиг
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт, Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.“Нисэхийн цаг уурын үйлчилгээний хангалт" техникийн баримт бичгийг хавсралтаар баталсугай.

2.“Нисэхийн цаг уурын үйлчилгээний хангалт" техникийн баримт бичгийг мөрдөж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газар (Э.Баттулга), "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК (Б.Отгонсүх), агаарын тээврийн байгууллагуудад, техникийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр)-т тус тус даалгасугай.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

БАЙГАЛЬ ОРЧИН,
УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД

Б.БАТБААТАР

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ
(TABLE OF NOTING CHANGES)

Хувилбар *(Индекс)*	Батлагдсан огноо *(Тушаалын дугаар)*	Нэмэлт өөрчлөлт орсон заалтын дугаар	Дэлгэрэнгүй тайлбар
1	2	3	4
Хэвлэл 1	1992.11.20		Анхны хэвлэл
Хэвлэл 1 Өөрчлөлт 1	Иргэний агаарын тээврийн удирдах газар, Ус цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 1997 он 36/300	Нислэгийн тогтмолжилт алдагдахад хүргэсэн ба нислэгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлсэн нислэгийн цаг агаарын урьдчилсан мэдээ дүгнэх заавар	
Хэвлэл 1 Өөрчлөлт 2	1998 он	Агаарын хөлгийн нисэх багаас цаг уурын ажиглалт хийх ба түүнийг дамжуулах журам, Нислэгийн цаг агаарын урьдчилсан мэдээ дүгнэх заавар	
Хэвлэл 1 Өөрчлөлт 3	2002 он	SIGMET, AIRMET мэдээлэл зохиох журам	
Хэвлэл 1 Өөрчлөлт 4	Монгол улсын дэд бүтцийн сайд, Байгаль орчны сайдын 2003.01.22 12/14	Нисэх буудлын уур амьсгалын тодорхойлолт бичих аргачлал	
Хэвлэл 1 Өөрчлөлт 5	2006 он	Суулт, хөөрөлтийн урьдчилсан мэдээ зохиох журам, RMK бүлгийг хэрэглэх журам, Цаг агаарын байдлын ам зөвлөгөө өгөх журам	
Хэвлэл 1 Өөрчлөлт 6	2008 он	Нисэхийн цаг уурын үйлчилгээнд тавигдах шаардлагууд	
Хэвлэл 2	ИНЕГ-ын дарга, ЦУОШГ-ын даргын 2010.05.21 А/177/57		Чикагогийн Конвенцын 3-р хавсралтын Нэмэлт 75-аар өөрчлөгдөв
Хэвлэл 2 Өөрчлөлт 1	ИНЕГ-ын дарга, ЦУОШГ-ын даргын 2011.07.06 А/261/92	Тодорхойлолт ба товчлол, Цаг уурын ажиглалт мэдээ, Урьдчилсан мэдээ, Нислэгт зориулсан цаг агаарын урьдчилсан мэдээг дүгнэх, Нисэх баг болон агаарын тээвэрлэгчдэд зориулсан цаг уурын үйлчилгээ	
Хэвлэл 2 Өөрчлөлт 2	ИНЕГ, ЦУОШГ-ын даргын дугаартай 2013.11.19 А/659/217	Чикагогийн Конвенцын 3-р хавсралтын Нэмэлт 76-аар өөрчлөгдөв	
Хэвлэл 3	ИНЕГ-ын дарга, ЦУОШГ-ын даргын 2016.11.24 А/876/136		Чикагогийн Конвенцын 3-р хавсралтын Нэмэлт 77-оор өөрчлөгдөв
Хэвлэл 3 Өөрчлөлт 1	ИНЕГ-ын дарга, ЦУОШГ-ын даргын 2018.12.17 А/837/267	Чикагогийн конвенцын 3-р хавсралтын Нэмэлт 78-аар өөрчлөгдөв	
Хэвлэл 4	ИНЕГ-ын дарга, ЦУОШГ-ын даргын 2023.09.15 А/267/164	-	Чикагогийн конвенцын 3-р хавсралтын Нэмэлт 79, 80-аар өөрчлөгдөв
Хэвлэл 5	Зам, тээврийн сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын тушаал 2026.01.22 А/17, А/125	-	Чикагогийн Конвенцын 3-р хавсралтын Нэмэлт 81, 82-оор өөрчлөгдөв.

ТҮГЭЭЛТИЙН ХУУДАС

Хувилбар */Индекс/*	Батлагдсан огноо */Тушаалын дугаар/*	Түгээх нэгж, байгууллагын нэр	Баримт бичгийг түгээх хэлбэр
Зам, тээврийн сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	2026.01.22 А/17, А/125	ЦУОШГ	Эх хувь */Цахим, хэвлэмэл/*
		НЦУТ	
		Орон нутгийн УЦУОШТ	
		ИНЕГ	
		ИНҮТ	
		Нисэх буудлууд	
		Агаарын тээвэрлэгч компаниуд	
		НТОЗШША	
		Харилцагч байгууллагууд	

"НИСЭХИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАНГАЛТ" ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧИГ

А.Хамрах хүрээ

Олон улсын иргэний нисэхийн байгууллага (цаашид "ICAO" гэх) нь 1944 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Чикаго хотноо байгуулагдсан бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллага юм. Уг байгууллагаас иргэний нисэхэд хамаарах Стандарт болон зөвлөмжийг агуулсан баримт бичгүүдийг гаргадаг бөгөөд тэдгээрийг "Чикагогийн Конвенцын Хавсралтууд" хэмээдэг. Монгол Улс энэхүү Конвенцод 1989 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр нэгдэн орсны хувьд иргэний нисэхийн үйл ажиллагаанд Чикагогийн Конвенцын (цаашид "Конвенц" гэх) хавсралтуудыг мөрдлөг болгон ажилладаг.

Иргэний нисэхийн болон нисэхийн цаг уурын салбарт баримтлах энэхүү техникийн баримт бичгийг Конвенцын Хавсралт 3 "Олон улсын агаарын навигацийн цаг уурын үйлчилгээ" болон 2025 онд ICAO-аас шинээр баталсан баримт бичиг Doc 10157 "Procedures for Air Navigation Services — Meteorology/Агаарын навигацийн үйлчилгээний журам – Цаг уур" (цаашид "PANS-MET (Doc 10157)")-д үндэслэж шинэчлэн боловсруулсан.

Энэхүү баримт бичигт тусгасан стандарт, зөвлөмжийг PANS-MET (Doc 10157)-ийн хамт ашиглана.

Энэхүү баримт бичигт нисэхийн цаг уурын мэдээний хангалт, цаг уурын алба болон системүүд, аэродромын цаг уурын ажиглалтын мэдээлэл, агаарын хөлгөөс хийсэн ажиглалт, аэродромын болон чиглэлийн урьдчилсан мэдээ, зөвлөмж сэрэмжлүүлэг, нисэхийн уур амьсгалын мэдээлэл, агаарын тээвэрлэгч болон нисэх багийн гишүүдэд үзүүлэх үйлчилгээ, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, эрэн хайх авран туслах үйлчилгээ болон нислэгийн мэдээллийн үйлчилгээнд зориулсан цаг уурын мэдээлэл, цаг уурын мэдээлэл солилцох зэрэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, нислэгт зориулсан цаг агаарын мэдээний техникийн шаардлагыг багтаасан болно. Нисэхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн хэсэг нь агаарын навигацийн цаг уурын үйлчилгээ бөгөөд энэ нь нислэгийн төлөвлөлт, үйл ажиллагаатай шууд хамааралтай юм.

Б. Нэр томьёо ба тодорхойлолт

Энэхүү баримт бичигт хэрэглэгдсэн нэр томьёог Бүлэг 1-ийн ерөнхий зүйлд тусгасан тодорхойлолтуудын дагуу ашиглана.

ЗАНГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ЕӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХҮҮЛБАР ҮНЭН
Архивч
(албан тушаалын нэр)
Чанчал
үсэг)(гарын үсгийн тайлал)
26 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛ
ЗАМ, ТЭЭВРИЙ
ЭЖ ХУЧ
Саид Тэмүү
Дарын 26 А/17

ГАРЧИГ

Бүлэг 1. Тодорхойлолт (Definitions) 1

Бүлэг 2. Ерөнхий зүйл (General provisions) 10
2.1 Цаг уурын үйлчилгээний хангалт болон зорилго, зорилт, тодорхойлолт (Objective, determination and provision of meteorological services) 10
2.2 Цаг уурын мэдээллийн тайлбар, чанарын менежментийн тогтолцоо, ашиглалт болон хангалт (Supply, use, quality management system and interpretation of meteorological information) 11
2.3 Агаарын тээвэрлэгчдээс шаардах мэдээлэл (Notifications required from operators) 12

Бүлэг 3. Цаг уурын алба болон дэлхийн системүүд, дэмжих төвүүд (Global systems, supporting centers and meteorological offices) 14
3.1 Дэлхийн бүсийн урьдчилсан мэдээний төв (World area forecast centre) ... 14
3.2 Аэродромын цаг уурын алба (Aerodrome meteorological offices) 14
3.3 Цаг уурын үйлчилгээний алба (Meteorological watch offices) 15
3.4 Галт уулын үнснээс сэрэмжлүүлэх төв (Volcanic ash advisory centres, VAAC) 16
3.5 Тропикийн циклоноос сэрэмжлүүлэх төв (Tropical cyclone advisory centres, TCAC) 16
3.6 Сансрын цаг агаарын төв (Space weather centres, SWXC) 17

Бүлэг 4. Аэродромын цаг уурын ажиглалтын мэдээлэл (Aerodrome meteorological observational information) 18
4.1 Нисэхийн цаг уурын өртөө ба ажиглалт (Aeronautical meteorological stations and observations) 18
4.2 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага хооронд байгуулсан гэрээ (Agreement between meteorological service provider and appropriate air traffic services authority) 19
4.3 Байнгын ажиглалт болон мэдээ (Routine observations and reports) 20
4.4 Тусгай ажиглалт болон мэдээ (Special observations and reports) 20
4.5 Цаг уурын мэдээний үзүүлэлт (Characteristics of meteorological reports) .. 21
4.6 Цаг уурын элементийг ажиглах болон мэдээлэх (Observing and reporting meteorological elements) 23
4.7 Автомат ажиглалтын системээс гаргаж буй цаг уурын мэдээлэл (Reporting meteorological information from automatic observing systems) ... 27
4.8 Галт уулын идэвхжилийг ажиглах болон мэдээлэх (Observing and reporting volcanic activity) 27
4.9 Цаг уурын мэдээллийн түгээлт (Dissemination of meteorological reports) .. 27

Бүлэг 5. Агаарын хөлгөөс хийсэн цаг уурын ажиглалтын мэдээ (Aircraft meteorological observational information) 29
5.1 Улсын үүрэг (Obligations of States) 29
5.2 Агаарын хөлгөөс хийсэн ажиглалтын төрөл (Types of aircraft observations) 29
5.3 Агаарын хөлгөөс хийсэн байнгын ажиглалт (Routine aircraft observations) 29
5.4 Агаарын хөлгөөс хийх байнгын ажиглалтаас чөлөөлөх (Routine aircraft observations- exemptions) 29

5.5 Агаарын хөлгөөс хийсэн тусгай ажиглалт (Special aircraft observations) ... 29
5.6 Агаарын хөлгөөс хийсэн бусад байнгын бус ажиглалт (Other non-routine aircraft observations and reports) ... 30
5.7 Нислэгийн үед агаарын хөлгөөс хийсэн ажиглалтыг мэдээлэх (Reporting of aircraft observations) ... 30
5.8 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжээс агаарын хөлгийн мэдээг дамжуулах (Relay of air-reports by air traffic services units) ... 30
5.9 Агаарын хөлгөөс хийсэн ажиглалтын мэдээг түгээх (Dissemination of air-reports) ... 31

Бүлэг 6.Аэродромын болон чиглэлийн цаг агаарын урьдчилсан мэдээ (Aerodrome and en-route meteorological forecast information) ... 32
6.1 Урьдчилсан мэдээний ашиглалт (Use of forecasts) ... 32
6.2 Аэродромын цаг агаарын урьдчилсан мэдээ (Aerodrome meteorological forecast information) ... 32
6.3 Чиглэлийн цаг агаарын урьдчилсан мэдээ (En-route meteorological forecast information) ... 35

Бүлэг 7.Зөвлөмж, сэрэмжлүүлэг, мэдэгдэл агуулсан цаг уурын мэдээлэл (Meteorological information containing advisories, warnings and notices) ... 37
7.1 Галт уулын үнсний зөвлөмжийн мэдээлэл болон улсын галт уулын ажиглалтын төвүүдээс ирүүлсэн мэдээлэл (Volcanic ash advisory information and information from State volcano observatories) ... 37
7.2 Тропикийн циклоны зөвлөмжийн мэдээлэл (Tropical cyclone advisory information) ... 37
7.3 Сансрын цаг агаарын зөвлөмжийн мэдээлэл (Space weather advisory information) ... 37
7.4 SIGMET мэдээлэл (SIGMET information) ... 37
7.5 AIRMET мэдээлэл (AIRMET information) ... 38
7.6 Аэродромын сэрэмжлүүлэг (Aerodrome warnings) ... 39
7.7 Салхины шилжлэгийн сэрэмжлүүлэг (Wind shear warnings) ... 40

Бүлэг 8.Нисэхийн уур амьсгалын мэдээлэл (Aeronautical climatological information) ... 42
8.1 Ерөнхий зүйл (General provisions) ... 42
8.2 Аэродромын уур амьсгалын хүснэгт (Aerodrome climatological tables) ... 42
8.3 Аэродромын уур амьсгалын хураангуй (Aerodrome climatological summaries) ... 42
8.4 Цаг уурын ажиглалтын мэдээний хуулбар (Copies of meteorological observational data) ... 43
8.5 Нисэхийн уур амьсгалын мэдээлэл солилцох (Exchange of aeronautical climatological information) ... 43

Бүлэг 9.Агаарын тээвэрлэгч болон нисэх багийн гишүүдэд үзүүлэх цаг уурын үйлчилгээ (Meteorological services for operations and flight crew members) ... 44
9.1 Ерөнхий зүйл (General provisions) ... 44
9.2 Зөвлөмж, зөвлөгөө болон дэлгэцийн мэдээллийн үйлчилгээ (Briefing, consultation and display) ... 45
9.3 Нислэгийн баримт бичиг (Flight documentation) ... 46

9.4 Зөвлөмж, зөвлөгөө, нислэгийн төлөвлөлт, нислэгийн баримт бичигт зориулсан нислэгийн өмнөх автомат мэдээллийн систем (Automated pre-flight information systems or briefing, consultation, flight planning and flight documentation)..... 47
9.5 Нислэг үйлдэж буй агаарын хөлөгт зориулсан цаг уурын мэдээлэл (Meteorological information for aircraft in flight) 48

Бүлэг 10.Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, эрэн хайх, авран туслах үйлчилгээ болон нислэгийн мэдээллийн үйлчилгээнд зориулсан цаг уурын мэдээлэл (Meteorological information for air traffic services, search and rescue services and aeronautical information services) 49
10.1 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжид зориулсан мэдээлэл (Information for air traffic services units)..... 49
10.2 Эрэн хайх, авран туслах үйлчилгээний нэгжид зориулсан мэдээлэл (Information for search and rescue services units) 50
10.3 Нисэхийн мэдээллийн үйлчилгээний нэгжид зориулсан мэдээлэл (Information for aeronautical information services units)..... 50

Бүлэг 11.Цаг уурын мэдээллийг солилцох харилцаа холбооны ашиглалт (Use of communications to exchange meteorological information)..... 52
11.1 Харилцаа холбоонд тавигдах шаардлага (Requirements for communications) 52
11.2 Нисэхийн суурин холбоо болон нийтийн интернэтийн ашиглалт (Use of aeronautical fixed service communications and the public Internet) .. 53
11.3 Нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээний төхөөрөмжийн ашиглалт (Use of aeronautical mobile service communications) 54
11.4 D-VOLMET радио нэвтрүүлгийн холболтын үйлчилгээг ашиглах (Use of aeronautical data link service D – VOLMET) 54
11.5 Нисэхийн радио нэвтрүүлгийн үйлчилгээний ашиглалт – VOLMET радио нэвтрүүлэг (Use of aeronautical broadcasting service - VOLMET broadcasts)..... 54

Хавсралтууд
Хавсралт 1. Нислэгийн баримт бичиг - загвар зураг болон маягт (Flight documentation - model charts and forms) 55
Хавсралт 2. Цаг уурын алба болон төвүүдэд дэмжлэг үзүүлэх дэлхийн системийн техникийн үзүүлэлт (Technical specifications related to global systems, supporting centers and meteorological offices) 73
Хавсралт 3. Цаг уурын ажиглалт болон мэдээтэй холбоотой техникийн үзүүлэлт (Technical specifications related to meteorological observations and reports) 77
Хавсралт 4. Агаарын хөлгийн ажиглалт болон мэдээтэй холбоотой техникийн үзүүлэлт (Technical specifications related to aircraft observations and reports) 108
Хавсралт 5. Урьдчилсан мэдээтэй холбоотой техникийн үзүүлэлт (Technical specifications related to forecasts) 116
Хавсралт 6. Sigmet ба Airmet мэдээлэл, аэродромын сэрэмжлүүлэг, салхины шилжлэгийн сэрэмжлүүлэгтэй холбоотой техникийн үзүүлэлт (Technical specifications related to sigmet and airmet information, aerodrome warnings and wind shear warnings) 133

Хавсралт 7. Нисэхийн уур амьсгалын мэдээлэлтэй холбоотой техникийн үзүүлэлт (Technical specifications related to aeronautical climatological information) 153
Хавсралт 8. Нисэх багийн гишүүн болон агаарын тээвэрлэгчид зориулсан үйлчилгээтэй холбоотой техникийн үзүүлэлт (Technical specifications related to service for operators and flight crew members) 161
Хавсралт 9. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, эрэн хайх, авран туслах үйлчилгээ болон нисэхийн мэдээллийн үйлчилгээнд зориулсан мэдээлэлтэй холбоотой техникийн үзүүлэлт (Technical specifications related to information for air traffic services, search and rescue services and aeronautical information services) 170
Хавсралт 10.Холбооны тоног төхөөрөмжид тавигдах шаардлага болон тэдгээрийн ашиглалттай холбоотой техникийн үзүүлэлт (Technical specifications related to requirements for and use of communications) 174

Нэмэлтүүд

Нэмэлт A. Хэмжилт, эсхүл ажиглалтын хүлцэж болох хязгаарлал (Operationally desirable accuracy of measurement or observation) 177
Нэмэлт B. Урьдчилсан мэдээний хүлцэж болох хязгаарлал (Operationally desirable accuracy of forecasts).....
Нэмэлт C. Аэродромын мэдээнд хэрэглэх сонгогдсон шалгуур (Selected criteria applicable to aerodrome reports)..... 181
Нэмэлт D. Багажийн заалтыг ХБЗ-ын дагуух АБХ болон АБХ руу хөрвүүлэх (Conversion of instrumented readings into runway visual range and visibility) 183

Бүлэг 1.Тодорхойлолт

Агаарын навигацийн цаг уурын үйлчилгээний стандарт болон зөвлөмжид доорх томьёоллуудыг ашигласан тохиолдолд дараах утгыг илэрхийлнэ.

Авран туслах зохицуулалтын төв / Rescue co-ordination centre
ЭХАТ бүсийн хүрээнд ЭХАТ үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж, тухайн үйл ажиллагааны гүйцэтгэлийн зохицуулах үүрэгтэй нэгж.

Агаарын хөлгийн мэдээ / Air-report
Нислэгт байгаа агаарын хөлгөөс байршил, үйл ажиллагаа, эсхүл цаг уурын мэдээний шаардлагад нийцүүлэн бэлдэж дамжуулдаг мэдээ.

Агаарын хөлгөөс ажиглалт хийх / Aircraft observation
Нислэгт байгаа агаарын хөлгөөс хийсэн нэг, эсхүл хэд хэдэн цаг уурын элементийн үнэлгээ.

Агаарын хөлөг / Aircraft
Агаар газрын гадаргуутай харилцан үйлчилснээс өөр, агаарын урсгалын харилцан үйлчлэлээр агаар мандалд хөөрөн нисэх чадвартай төхөөрөмж.

Ажиглалт (цаг уурын) / Observation (meteorological)
Цаг уурын нэг, эсхүл хэд хэдэн элементийг ажиглах үйл ажиллагаа.

Аэродром / Aerodrome
Агаарын хөлгийн хөөрөлт, буулт болон гадаргуугийн хөдөлгөөнд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн ашиглахад зориулсан, эсхүл зохион бүтээсэн, газар, эсхүл усан дээр тогтоосон, түүний барилга, байгууламж болон төхөөрөмжийг багтаасан талбай.

Аэродромын удирдлагын цамхаг / Aerodrome control tower
Аэродромын хөдөлгөөнд НХУ-ын үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулсан нэгж

Аэродромын уур амьсгалын тодорхойлолт / Aerodrome climatological summary
Статистик өгөгдөлд үндэслэн гаргасан аэродромын цаг уурын тодорхойлогдсон элементүүдийн товч хураангуй.

Аэродромын уур амьсгалын хүснэгт / Aerodrome climatological table
Аэродромын нэг, эсхүл хэд хэдэн цаг уурын элементийн ажиглагдсан үзэгдлийн статистик өгөгдлийг багтаасан хүснэгт.

Аэродромын хяналтын цэг / Aerodrome reference point
Аэродромын газар зүйн байршлыг тодорхойлдог цэг.

Аэродромын цаг уурын алба / Aerodrome meteorological office
Олон улсын нислэгт үйлчилдэг аэродромд цаг уурын үйлчилгээ үзүүлэхээр томилогдсон нэгж.

Аяллын түвшин / Cruising level
Нислэгийн дийлэнх хэсэгт хадгалдаг нислэгийн түвшин

МОНГОЛ УЛСЫН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАРЛАСАН
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дүгээр сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Дугаар 26 А/17

Босго / Threshold
Буулт үйлдэхэд ашигладаг ХБЗ-ын хэсгийн эхлэл.

Бүсийн агаарын навигацийн гэрээ / Regional air navigation agreement
Бүсийн агаарын навигацийн уулзалтын зөвлөмжийг үндэслэн ICAO консулын баталсан гэрээ.

Бүсийн удирдлагын төв / Area control centre (ACC)
Өөрийн хариуцах удирдлагын бүсэд, хяналттай нислэгт НХУ-ын үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулсан нэгж.

Бэлтгэл аэродром / Alternate aerodrome
Буулт үйлдэхээр төлөвлөсөн аэродромд буух, эсхүл түүнийг чиглэн нисэх боломжгүй, эсхүл эргэлзээтэй болсон үед агаарын хөлөг чиглэн нисэж болох, шаардлагатай үйлчилгээ болон байгууламжтай, агаарын хөлгийн үзүүлэлтийн шаардлагыг хангаж чадах ба тухайн цаг хугацаанд ажилтай байгаа аэродром.

Газардах зоон / Touchdown zone
Буултын үед нисэх онгоц ХБЗ-нд анх шүргэхэд зориулсан, босгын дараах ХБЗ-ын хэсэг.

Галт уулын ажиглалтын төв / State volcano observatory
Тухайн Улсын идэвхтэй, эсхүл идэвхжиж болох галт уулд мониторинг хийж, холбогдох бүсийн удирдлагын төв/ нислэгийн мэдээллийн төв, цаг уурын ажиглалтын алба болон галт уулын үнснээс сэрэмжлүүлэх төвийг галт уулын идэвхжилтэй холбоотой мэдээгээр хангах зорилгоор бүсийн агаарын навигацийн гэрээгээр байгуулсан галт уулын ажиглалтын төв.

Галт уулын үнснээс сэрэмжлүүлэх төв / Volcanic ash advisory centre (VAAC)
Цаг уурын хяналтын алба, бүсийн удирдлагын төв, нислэгийн мэдээллийн төв, Дэлхийн бүс нутгийн урьдчилсан мэдээний төв болон олон улсын ОРМЕТ өгөгдлийн санг галт уулын дэлбэрэлтээс шалтгаалж агаарт тархсан галт уулын үнсний босоо, хэвтээ чиглэлийн шилжилт хөдөлгөөний бодит болон сэрэмжлүүлэх мэдээллээр хангах үүрэгтэй, бүсийн агаарын навигацийн гэрээгээр томилогдсон цаг уурын төв.

Гэрээ (ADS-C) / Automatic dependent surveillance – contract (ADS-C)
Ямар нөхцөлийн дагуу ADS-C мэдээлэл эхлүүлэх болон аль өгөгдөл тухайн мэдээлэлд агуулагдсан байхыг заасан, data-link-ээр газрын систем болон агаарын хөлөг хооронд ADS-C гэрээний нөхцөлийг солилцох арга.

Тайлбар. "ADS-C" гэж ADS event contract, ADS demand contract, ADS periodic contract, эсхүл emergency mode-г илэрхийлдэг, нийтлэг хэрэглэдэг товчлол

Давамгайлах хараа / Prevailing visibility
Тэнгэрийн хаяаны тойргийн хагасаас багагүй хүрээнд, эсхүл аэродромын гадаргуугийн хагасаас багагүй хүрээнд, "хараа"-ны тодорхойлолтын дагуу тогтоосон хамгийн сайн харааны хэмжээ. Эдгээр хүрээ нь үргэлжилсэн, эсхүл хэсэгчилсэн байж болно.

Тайлбар. Энэ нь хуний ажиглалтаар ба, эсхүл хэрэгслээр тодорхойлсон утга байж болно. хэрэгсэл ашигласан тохиолдолд давамгайлах харааг илүү оновчтой тодорхойлно гэж үзнэ.

ХУУЛБАР ҮНЭН
Архивч
Гарын үсгийн тайлбар
26 01 дугаар сарын 29
ЭХ ХУВЬ
26 А/17

Дэлхийн бүс нутгийн урьдчилсан мэдээний систем / World area forecast system (WAFS)
Дэлхийн бүсийн урьдчилсан мэдээний төвөөс нислэгийн замын нисэхийн цаг уурын урьдчилсан мэдээг нэгдсэн стандартчилсан форматаар хангадаг дэлхийг хамарсан систем.

Дэлхийн бүс нутгийн урьдчилсан мэдээний төв / World area forecast centre (WAFC)
Дэлхийн хэмжээнд цаг агаарын онцгой үзэгдлийн урьдчилсан мэдээ болон дээд агаар мандлын урьдчилсан мэдээг тоон хэлбэрээр бэлтгэн, гаргаж интернэтэд суурилсан нисэхийн тогтсон үйлчилгээ авдаг Улсуудад шууд дамжуулах зориулалттай цаг уурын төв.

Зааварчилгаа / Briefing
Бодит, эсхүл урьдчилан таамагласан цаг уурын нөхцөлийн талаарх аман тайлбар.

Зөвлөгөөн / Consultation
Нислэгийн үйл ажиллагаатай холбоотой цаг уурын бодит, эсхүл урьдчилан таамагласан нөхцөлийн талаар цаг уурч, эсхүл бусад мэргэшсэн этгээдтэй хийдэг хэлэлцүүлэг. Хэлэлцүүлэг нь асуултын хариултыг багтаана.

Илтгэх цэг / Reporting point
Агаарын хөлөг байрлалаа харьцуулан илтгэж болох онцгойлон заасан газар зүйн байршил.

Нислэгийн баримт бичгийн бүрдэл / Flight documentation
Нислэгт зориулсан цаг уурын мэдээллийг агуулсан хүснэгт, эсхүл маягтыг багтаасан гараар бичсэн, эсхүл хэвлэмэл баримт бичиг.

Нислэгийн замын бэлтгэл аэродром / En-route alternate- нислэгийн замд даялах шаардлага гарсан тохиолдолд агаарын хөлөг буулт үйлдэх боломжтой бэлтгэл аэродром.

Нислэгийн мэдээллийн бүс / Flight information region (FIR)
Нислэгийн мэдээллийн үйлчилгээ болон аюулын дохио мэдээлэх үйлчилгээ үзүүлэх зорилгоор тогтоосон хэмжээтэй агаарын зай.

Нислэгийн мэдээллийн төв / Flight information centre (FIC)
Нислэгийн мэдээллийн үйлчилгээ болон аюулын дохио мэдээлэх үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулсан нэгж.

Нислэгийн түвшин / Flight level
1013.2 hPa-аар тогтоосон даралтын эхлэлийн цэгээс эхэлдэг ба бусад даралтын гадаргуугаас тусгайлан тогтоосон даралтын үечлэлээр зайчлагддаг атмосферийн тогтмол даралтын гадаргуу.

Тайлбар 1. Стандарт Атмосферийн дагуу тохируулга хийгдсэн дараах даралтын төрлийн альтиметр:

а) QNH. альтиметрийн тохируулгад шилжүүлсэн тохиолдолд, өндрийн түвшнийг заадаг;

ХУУЛБАРУУЛЭН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУЛЬ
26 А/17

b) QFE алтиметрийн тохируулгад шилжүүлсэн тохиолдолд, QFE эхлэлийн цэгээс дээших өндрийг заадаг;

c) 1013.2 hPa даралтад шилжүүлсэн тохиолдолд, нислэгийн түвшнийг заахад ашигладаг;

Тайлбар 2. Тайлбар 1-д хэрэглэсэн "өндөр" болон "өндрийн түвшин" нь геометрийн бус, алтиметрийн өндөр болон өндрийн түвшнийг заадаг.

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгж / Air traffic services unit
НХҮ-ний нэгж, нислэгийн мэдээллийн төв, эсхүл НХҮ-ний мэдээлэх төв зэрэг олон утгатай ерөнхий ойлголт.

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний эрх бүхий байгууллага / Appropriate ATS authority
Тухайн агаарын зайд НХҮ үзүүлэх үүрэг бүхий Улсын томилсон эрх бүхий байгууллага.

Нислэгийн үйл ажиллагааны төлөвлөгөө / Operational flight plan
Тухайн нислэгийг аюулгүй гүйцэтгэх зорилгоор нислэгийн замд болон аэродромд дагаж мөрдөх шаардлагатай, тухайн нисэх онгоцны үзүүлэлт, бусад үйл ажиллагааны хязгаарлалт болон таамаглаж байгаа бодит нөхцөлийн төсөөлөлд суурилан гаргасан, гэрчилгээ эзэмшигчийн төлөвлөгөө.

Нислэгийн үйл ажиллагааны удирдлага / Operational control
Агаарын хөлгийн аюулгүй байдал болон нислэгийг тогтмол, үр ашигтай гүйцэтгэх ашиг сонирхлын үүднээс нислэг эхлүүлэх, үргэлжлүүлэх, чиглэл өөрчлөх, эсхүл цуцлах эрх үүргийг хэрэгжүүлэх.

Нисэн очих бэлтгэл аэродром / Destination alternate - буулт үйлдэхээр төлөвлөсөн аэродромд буулт үйлдэх боломжгүй, эсхүл эргэлзээтэй болсон үед агаарын хөлөг буулт үйлдэх боломжтой бэлтгэл аэродром.

Тайлбар. Тухайн нислэг нисэн гарсан аэродром нь тухайн нислэгт замын, эсхүл нисэн хүрэх бэлтгэл аэродром байж болно.

Нисэх багийн гишүүн / Flight crew member
Нислэгийн үүрэгт хугацаанд агаарын хөлөгт гэрчилгээжсэн багийн гишүүний үүрэг гүйцэтгэхээр томилогдсон этгээд.

Нисэхийн суурин холбооны үйлчилгээ / Aeronautical fixed service (AFS)
Нислэгийн аюулгүй байдал болон агаарын навигацийн үйлчилгээг тогтмол, үр ашигтай, эдийн засгийн хэмнэлттэй байлгах тэргүүн зорилгоор хангадаг тусгайлан тогтоосон тогтмол цэг хоорондын цахилгааны холбооны үйлчилгээ.

Нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээ / Aeronautical mobile service (RR S1.32)
Нисэхийн холбооны станц болон агаарын хөлгийн станцын хооронд, эсхүл агаарын хөлгийн станцуудын хоорондох хөдөлгөөнт холбооны үйлчилгээ, үүнд агаарын хөлгийн аврах станц багтаж болно. Энэ үйлчилгээнд аюулын болон ослын онооссон давтамжаар ослын байршил заадаг радио дохиологч станц багтаж болно.

Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага / Meteorological service provider

ТӨРИЙН ӨМЧИЙН ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ЗӨВЛӨЛТИЙН ГАЗАР
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архив
(гарын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 29
МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 А/17

Агаарын навигацийн цаг уурын үйлчилгээ үзүүлэхээр томилогдсон хамаарал бүхий хуулийн этгээд

Тайлбар. Нисэхийн цаг уурын үйлчилгээг Ус цаг уур, хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үзүүлнэ.

Нисэхийн цаг уурын өртөө / Aeronautical meteorological station
Олон улсын агаарын навигацид зориулан цаг уурын ажиглалт хийх болон мэдээ дамжуулахаар томилогдсон өртөө.

Нисэхийн цахилгаан холбооны станц / Aeronautical telecommunication station
Нисэхийн цахилгаан холбооны үйлчилгээний станц.

Ойртолтын удирдлагын нэгж / Approach control unit
Нэг, эсхүл хэд хэдэн аэродромоос нисэн гарах, эсхүл нисэн ирэх хяналттай нислэгт НХУ-ын үйлчилгээ үзүүлэх нэгж.

Олон улсын агаарын замын галт уулын ажиглалт / International airways volcano watch(IAVW)
Атмосферт дэгдсэн галт уулын үнсний мониторинг хийж, агаарын хөлөгт анхааруулга өгдөг олон улсын зохицуулалт.

Тайлбар. Олон улсын агаарын замын галт уулнаас сэрэмжлүүлэх үйл ажиллагаа нь гишүүн Улсаас тодорхойлсон ажиглалтын эх сурвалж болон сүлжээнээс дамжуулж байгаа мэдээллийг ашигладаг нисэхийн болон нисэхийн бус үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурладаг. Энэ хяналт нь ICAO болон бусад олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаагаар зохицуулагддаг.

Өндөр / Height
Тусгайлан тогтоосон эхлэлийн цэгээс хэмжсэн бөгөөд тухайн байгууламжийн босоо хэмжээг багтаасан, түвшин, цэг, эсхүл цэг гэж үзсэн байгууламжийн босоо зай.

Өндрийн түвшин / Altitude
MSL-ээс хэмжсэн, түвшний цэг, эсхүл цэг гэж үзсэн байгууламжийн босоо зай.

Прогноз зураг / Prognostic chart
Өгөгдсөн цаг, эсхүл хугацаанд болон өгөгдсөн гадаргуу, эсхүл агаарын зайн хэсэгт зориулан газрын зураг дээр зураглал хэлбэрээр дүрслэн үзүүлсэн цаг уурын элементийн урьдчилсан мэдээ.

Сансрын цаг агаарын мэдээллийн үйлчилгээ / Space weather information service
Сансрын цаг агаарын төвүүдээс харилцаа холбоо, навигаци, хяналтын системд нөлөөлж болзошгүй болон нисэх онгоцны зорчигчдод радиацын эрсдэл үүсгэж болох сансрын цаг агаарын үзэгдлийн талаар мэдээлэл өгдөг, дэлхийн хэмжээнд зохицуулсан үйлчилгээ.

Сансрын цаг агаарын төв / Space weather centre (SWXC)
Өндөр давтамжийн радио холбоо, хиймэл дагуулын холбоо, GNSS-д суурилсан навигаци болон ажиглалтын системд нөлөөлж болох ба, эсхүл агаарын хөлгийн бүхээгт байгаа хүмүүст радиацын төөнөлтийн эрсдэл учруулж болох сансрын цаг

ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(гарын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 29
МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 А/17

агаарын аюултай үзэгдэлд мониторинг хийж, зөвлөмжийн мэдээгээр хангах зорилгоор байгуулсан төв.

Тайлбар. Сансрын цаг агаарын төвийг дэлхий, эсхүл бүсийн хэмжээнд томилдог.

Секторын минимум өндрийн түвшин / Minimum sector altitude
Тодорхой цэг, аэродромын хяналтын цэг (ARP), эсхүл хелипортын хяналтын цэгт (HRP) төвтэй 46 км (25 NM) радиустай тойргийн сектор дотор тухайн талбайд байгаа бүх байгууламжийн дээгүүр минимум 300 м-ийн (1000 ft) чөлөөтэй байх зайг хангахад ашиглаж болох хамгийн бага өндрийн түвшин.

Солбицлын цэгийн тоон хэлбэртэй өгөгдөл / Grid point data in digital form
Газрын зураг дээр тогтмол зайчилсан цэгийг багцлах зорилгоор автомат ажиллагаанд ашиглахад тохиромжтой хэлбэрээр кодлон цаг уурын компьютероос бусад компьютер руу дамжуулахад зориулан компьютероор боловсруулсан цаг уурын өгөгдөл.

Тайлбар. Ихэнх тохиолдолд дээрх мэдээллийг дунд, эсхүл өндөр хурдны цахилгаан холбооны сувгаар дамжуулдаг.

Тропик циклон / Tropical cyclone
Конвекц болон тодорхой циклоны гадаргуугийн салхины эргүүлгээр тропик, эсхүл субтропик далай дээр үүсдэг фронтын бус синоптик масштабтай циклоны ерөнхий нэр томьёо.

Тропик циклоноос сэрэмжлүүлэх төв / Tropical cyclone advisory centre (TCAC)
Цаг уурын ажиглалтын алба, Дэлхийн бүс нутгийн урьдчилсан мэдээний төв болон олон улсын ОРМЕТ өгөгдлийн санг тропик циклоны байрлал, чиглэлийн урьдчилсан мэдээ болон хөдөлгөөний хурд, төвийн даралт болон максимум гадаргуугийн салхины талаар сэрэмжлүүлэх мэдээллээр хангах зорилгоор бүсийн агаарын навигацийн гэрээгээр томилогдсон цаг уурын төв.

Түвшин / Level
Нислэгт байгаа агаарын хөлгийн босоо байршилтай холбоотой өндөр, өндрийн түвшин, эсхүл нислэгийн түвшнийг илэрхийлдэг ерөнхий нэр томьёо.

Удирдлагын бүс / Control area (CTA)
Газраас дээш тогтоосон хязгаараас дээш үргэлжлэх хяналттай агаарын зай.

Үйл ажиллагаанд нөлөөлөхүйц үүл / Cloud of operational significance
Суурийн өндөр нь 1,500 м-ээс (5,000 ft) доор, эсхүл хамгийн их секторын минимум өндрийн-түвшнээс доор байгаа үүлний аль өндрийг, эсхүл бороony бөөн үүл, эсхүл цамхаг хэлбэрийн бөөн үүл.

Үйл ажиллагаа эрхлэгч / Operator
Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлдэг, эсхүл эрхлэхийг зорьж байгаа хувь хүн, эсхүл хуулийн этгээд.

Хараа / Visiblity
Нисэхийн үйл ажиллагааны зорилгоор ашигладаг дараах зайны аль ихийг:
а) Газар дээр байрлуулсан тохиромжтой хэмжээтэй хар биетийг тод гэгээтэй дэвсгэрээс ялгаж харах болон таньж тогтоож чадах хамгийн хол зай;

ХУУЛБАР ҮНЭН
Архивч
26 01 дугаар сарын 29
МОНГОЛ УЛСЫН
ЭХ ХУВЬ
26 А/17

b) 1,000 кандел гэрлийн ойролцоо байгаа гэрлийг харанхуй дэвсгэрээс ялгаж харах болон таньж тогтоож чадах хамгийн хол зай.

Тайлбар 1. Дээрх 2 зай нь агаарын тунгалагшлын коэффициент (extinction coefficient) болон сүүлийн b) нь дэвсгэрийн гэрэлтүүлгийн өөрчлөлтөөс хамааруулан өөр утгатай байдаг. Эхний а) нь цаг уурын оптик зайгаар (MOR) илэрхийлэгддэг.

Тайлбар 2. Энэ тодорхойлолтыг орон нутгийн бодит болон тусгай мэдээний харааны ажиглалт, METAR болон SPECI-д өгсөн давамгайлах болон минимум харааны ажиглалт болон газрын харааны ажиглалтад хэрэглэдэг.

ХБЗ-ын ил харааны зай / Runway visual range (RVR)
ХБЗ-ын гадаргуугийн тэмдэглэгээ, эсхүл ХБЗ-г тэмдэглэсэн, эсхүл түүний гол шугамыг харуулсан гэрлийг ХБЗ-ын төвийн шугам дээр байгаа агаарын хөлгийн нисгэгчийн харж чадах зай.

Хөлгийн дарга / Pilot-in-command
a) Нислэгийг удирдан, аюулгүй гүйцэтгэх үүрэг хүлээсэн, агаарын тээвэрлэгч, эсхүл ерөнхий зориулалтын нисэхийн хувьд агаарын хөлөг эзэмшигчийн томилсон нисгэгч
b) Нислэгийн хугацаанд тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаа болон аюулгүй байдлыг хариуцсан нисгэгч.

Хөөрөлтийн бэлтгэл аэродром / Take-off alternate - нисэн гарсан аэродромыг ашиглах боломжгүй тохиолдолд хөөрөлтийн дараа агаарын хөлөг буулт үйлдэх шаардлага гарсан үед буулт үйлдэх боломжтой бэлтгэл аэродром;

Хөөрч, буух зурвас (ХБЗ) / Runway
Агаарын хөлгийн буулт, хөөрөлтөд зориулан бэлдсэн, газрын аэродром дээр тогтоосон тэгш өнцөгт талбай.

Хүний хүчин зүйлийн зарчим / Human Factors principles
Хүний чадавхыг зөв тодорхойлсноор хүн болон бусад системийн бүрдэл хэсгийн хоорондын аюулгүй харилцааг бий болгодог, нисэхийн бүтээгдэхүүний зохион бүтээлт, гэрчилгээжүүлэлт, сургалт, үйл ажиллагаа болон техник үйлчилгээнд тавьдаг зарчим.

Цаг уурын ажиглалтын алба / Meteorological watch office (MWO)
Заасан хариуцлагын бүсэд агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлж болох тухайн замын дагуух цаг агаарын үзэгдэл, эсхүл урьдчилан таамаглаж болох үзэгдэл болон атмосферийн бусад аюултай үзэгдлийн талаар мэдээ хангах зорилгоор байгуулсан алба.

Цаг уурын алба / Meteorological office
Олон улсын агаарын навигацид цаг уурын үйлчилгээ үзүүлэхээр томилогдсон нэгж

Цаг уурын бюллетен / Meteorological bulletin
Гарчгийг нь урьдчилан хэвлэсэн цаг уурын мэдээлэл агуулсан бичвэр.

Цаг уурын мэдээ / Meteorological report
Тогтоосон хугацаа болон байрлалтай холбоотой ажиглагдсан цаг уурын нөхцөлийн мэдэгдэл.

Цаг уурын мэдээлэл / Meteorological information

ХӨЛӨГ ХӨӨРӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ХУВИЛ
(албан тушаалын нэр)
(гарын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 29
МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВИЛ
26 А/14

Цаг уурын бодит болон урьдчилан таамагласан нөхцөлтэй холбоотой цаг уурын мэдээлэл, дүн шинжилгээ, урьдчилсан мэдээ болон бусад мэдэгдэл.

Цаг уурын урьдчилсан мэдээ / Forecast
Тодорхой цагт, эсхүл цаг хугацааны хооронд, тодорхой бүс, эсхүл агаарын зайн хэсгийн урьдчилан таамагласан цаг уурын нөхцөлийн талаарх мэдэгдэл.

Цаг уурын хиймэл дагуул / Meteorological satellite
Цаг уурын ажиглалт хийж, тэдгээр мэдээллийг дэлхий рүү дамжуулдаг хиймэл дагуул.

Цаг уурын эрх бүхий байгууллага / Meteorological authority
Хэлэлцэн тохиролцогч улсын нэрийн өмнөөс олон улсын агаарын навигацид цаг уурын үйлчилгээ үзүүлдэг, эсхүл түүнийг зохицуулдаг эрх бүхий байгууллага.

> *Тайлбар. Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагыг Иргэний нисэхийн ерөнхий газраас Иргэний нисэхийн дүрэм-174-ийн дагуу гэрчилгээжүүлж, үйлчилгээнд хяналт тавина.*

Чанар баталгаажуулалт / Quality assurance
Чанарын шаардлагыг бүрэн хангана гэсэн итгэл бий болгоход чиглэсэн чанарын удирдлагын хэсэг (ISO 9001:2015).

Чанарын менежмент / Quality management
Чанарыг зорилго болгон байгууллагыг чиглүүлэх болон удирдах зохицуулалттай үйл ажиллагаа (ISO 9001:2015).

Чанарын хяналт / Quality control
Чанарын шаардлагыг бүрэн хангахад чиглэсэн, чанарын менежментийн тогтолцоо (ISO 9001:2015).

Эрэн хайх, авран туслах үйлчилгээний нэгж / Search and rescue services unit
Тухайн нөхцөлөөс хамааран авран туслах зохицуулалтын төв, авран туслах дэд төв, эсхүл түгшүүрийн мэдээллийн нэгж гэх мэт утгатай ерөнхий нэр томьёо.

AIRMET мэдээ / AIRMET information
Нислэгийн нам өндрийн түвшинд агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй ба тухайн FIR, эсхүл дэд бүсийн нислэгийн нам өндрийн түвшинд урьдчилсан мэдээнд багтаагүй нислэгийн замд ажиглагдсан, эсхүл үүсэж болно гэж таамагласан цаг уурын аюултай үзэгдлийн талаар цаг уурын ажиглалтын төвөөс гаргадаг мэдээ.

GAMET бүсийн урьдчилсан мэдээ / GAMET area forecast
Холбогдох цаг уурын эрх бүхий байгууллагын томилсон цаг уурын төвөөс бэлтгэн гаргадаг ба цаг уурын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцсоноор зэргэлдээх FIR-ийн цаг уурын төвтэй солилцдог, FIR, эсхүл түүний дэд бүсийн нам түвшний нислэгт зориулан товчилсон ойлгомжтой хэлбэрээр гаргадаг бүсийн урьдчилсан мэдээ.

ICAO-ийн цаг уурын мэдээлэл солилцох загвар / ICAO meteorological information exchange model (IWXXM)
Нисэхийн цаг уурын мэдээг тайлбарласан өгөгдлийн загвар.

ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
(н үсэг)(гарын үсгийн тайлал)
26. оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЭЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУУЛЬ
26 А/17

SIGMET мэдээлэл / SIGMET information
Агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй, тухайн нислэгийн замын дагуу ажиглагдсан, эсхүл үүсэж болно гэж таамагласан цаг агаарын аюултай үзэгдлийн талаар цаг уурын албанаас гаргадаг мэдээлэл

VOLMET / VOLMET
Нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт зориулсан цаг уурын мэдээлэл.

VOLMET нэвтрүүлэг / VOLMET broadcast
METAR, SPECI, TAF болон SIGMET мэдээг тодорхой хугацааны давталттай, тасралтгүй яриагаар цацдаг радио нэвтрүүлгээр хангах.

VOLMET өгөгдлийн холбоо / Data link VOLMET
Аэродромын цаг уурын бодит мэдээ (METAR), аэродромын цаг уурын тусгай мэдээ (SPECI), Аэродромын урьдчилсан мэдээ (TAF), SIGMET болон боломжтой тохиолдолд AIRMET мэдээллийг өгөгдлийн холбоогоор (data-link) хангах

ЧИН, УУР АМЬСГАЛЫН
ЗҮЙЧЛӨЛТИЙН ЯАМ
...ртгэлийн дугаар ..607...
...УЛЬЗАР УНЭН
Архивч
...ын нэр)
Чанцал
...н үсгийн тайлал)
26 01 ...гаар сарын 29

МОНГОЛ УЛ...
ЗАМ, ТЭЭВРИЙН Х...
ЭХ ХУВЬ
26 А/17 Хуудас 9

Бүлэг 2. Ерөнхий зүйл

2.1 Цаг уурын үйлчилгээний хангалт болон зорилго, зорилт, тодорхойлолт (Objective, determination and provision of meteorological services)

2.1.1 Агаарын навигацийн цаг уурын үйлчилгээний зорилго нь агаарын навигацийн аюулгүй байдал, байнгын тогтвортой, үр ашигтай байдлыг хангахад хувь нэмэр оруулахад оршино.

2.1.2 Энэхүү зорилго нь агаарын навигацийг хөгжүүлэх болон чиглүүлэхэд агаарын тээвэрлэгчид, нисэх багийн гишүүд, НХҮ-ний нэгжүүд, нисэх буудлын удирдлага болон бусад хэрэглэгчдийг тус тусын чиг үүргээ хэрэгжүүлэхэд цаг уурын шаардлагатай мэдээллээр хангахад оршино.

2.1.3 Улс нь агаарын навигацийн шаардлагад нийцсэн цаг уурын үйлчилгээг үзүүлэх бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт цаг уурын үйлчилгээг Конвенцын Хавсралт 3, ICAO-ийн баримт бичиг Doc 10157 (PANS-MET)-ийн дагуу үзүүлнэ.

2.1.4 Улс нь өөрийн нэрийн өмнөөс олон улсын агаарын навигацийн цаг уурын үйлчилгээгээр хангах ажлыг зохицуулах цаг уурын эрх бүхий байгууллага гэж нэрлэгдэх хуулийн этгээдийг томилно. Томилогдсон цаг уурын эрх бүхий байгууллагын дэлгэрэнгүй мэдээллийг Конвенцын Хавсралт 15-ын 5 дугаар бүлгийн дагуу тухайн улсын нисэхийн мэдээллийн эмхэтгэлд (AIP)-т тусгасан байна.

Тайлбар. Агаарын навигацийн мэдээллийн эмхэтгэлийн агуулга болон түүний танилцуулгатай холбоотой нарийвчилсан техникийн үзүүлэлтүүдийг Procedures for Air Navigation Services - Aeronautical Information Management (PANS-AIM (Doc 10066))-ийн, Appendix 2 -т тусгасан болно.

2.1.5 Улс нь өөрийн нэрийн өмнөөс олон улсын агаарын навигацид зориулсан цаг уурын үйлчилгээг үзүүлэх байгууллагыг томилно. Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Конвенцын Хавсралт 15-ын 5 дугаар бүлгийн дагуу тухайн улсын нисэхийн мэдээллийн эмхэтгэлд (AIP)-т тусгасан байна.

2.1.6 Цаг уурын эрх бүхий байгууллага нь Агаарын навигацийн үйлчилгээ үзүүлж буй цаг уурын ажилтны мэргэшил, ур чадвар, боловсрол, сургалтын чанар нь Дэлхийн цаг уурын байгууллага (WMO)-ын шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулна. Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын ажилтанд тавигдах шаардлага, ажилтнуудын сургалт, ур чадварыг үнэлэх, хадгалах, дээшлүүлэх, мэргэшлийн үнэмлэх олгох журамтай байна.

Тайлбар. Нисэхийн цаг уурын чиглэлээр ажиллах цаг уурын ажилтны мэргэшил, ур чадвар, боловсрол, сургалтын шаардлагуудыг (Technical Regulations (WMO-No. 49), Volume I - General Meteorological Standards and Recommended Practices, Part V - Qualifications and Competencies of Personnel Involved in the Provision of Meteorological (Weather and Climate) and Hydrological Services, Part VI - Education and Training of Meteorological Personnel, and Appendix A- Basic Instruction Packages)-д тусгасан болно.

ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архив2
(Албан тушаалын нэр)
Ганцэц
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
26 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛ
ЗАМ, ТЭЭВРИЙ
ЭХ ХУЛ
Сайд Төрийн
26 А/17

2.2 Цаг уурын мэдээллийн тайлбар, чанарын менежментийн тогтолцоо, ашиглалт болон хангалт (Supply, use, quality management system and interpretation of meteorological information)

2.2.1 Агаарын навигацид цаг уурын мэдээллийг бэлтгэн нийлүүлэх, ашиглах, эдгээр үйлчилгээг үзүүлэхэд нөлөөлж буй асуудлын талаар хоорондоо нягт уялдаа холбоотой хамтран ажиллана.

2.2.2 Хэрэглэгчдэд үйлчлэх цаг уурын мэдээллийн чанарын менежментийн тогтолцоог хангахын тулд шаардлагатай журам, үйл ажиллагаа, нөөц бололцооноос бүрдсэн чанарын тогтолцоог нисэхийн цаг уурын үйлчилгээ үзүүлэгч байгууллага тогтоож хэрэгжүүлнэ.

2.2.3 **Зөвлөмж** - *2.2.2-т заасны дагуу нэвтрүүлсэн чанарын тогтолцоо нь Олон улсын стандартын байгууллагын (ISO) 9000 цуврал чанарын батлагдсан стандартад нийцсэн байх ба зөвшөөрөгдсөн байгууллагаар баталгаажсан байна.*

Тайлбар. ISO 9000 цуврал чанарын баталгаажуулалтын стандартууд нь чанарын баталгаажуулалтын хөтөлбөрийг боловсруулах үндсэн суурийг бүрдүүлдэг. Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх нарийвчилсан мэдээллийг улс бүр гаргах ёстой бөгөөд ихэнх тохиолдолд тухайн улсын онцлогт тохирсон байдаг. Чанарын менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх зааврыг Guide to the Implementation of Quality Management Systems for National Meteorological and Hydrological Services and Other Relevant Service Providers (WMO-No. 1100)-д заасан болно.

2.2.4 **Зөвлөмж** - *Чанарын тогтолцооны хэмжилт, ажиглалт, урьдчилсан мэдээний нарийвчлал, түгээж буй цаг уурын мэдээлэл нь газарзүйн болон орон зайн хамрах хүрээ, формат, агуулга, хугацаа, давтамж, хүчинтэй байх хугацааны хувьд заасан шаардлагад нийцэж байгааг баталгаажуулна. Хэрэглэгчдэд түгээх цаг уурын мэдээлэл нь чанарын тогтолцооны тогтоосон шаардлагыг хангаагүй, алдааг автоматаар залруулах үйл ажиллагаа шаардлага хангаагүй бол, мөн мэдээллийн эх сурвалжийг баталгаажуулаагүй тохиолдолд хэрэглэгчдэд түгээхгүй.*

Тайлбар. Нисэхийн хэрэглэгчдэд өгөх цаг уурын мэдээллийн газарзүйн болон орон зайн хамрах хүрээ, формат, агуулга, гаргах хугацаа, давтамж, хүчинтэй байх хугацаанд тавигдах шаардлагыг Конвенцын Хавсралт 3-ийн Chapter 3, 4, 6, 7, 8, 9,10, PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 2, 4, 5, 6, 7, 8, 9 болон бүс нутгийн агаарын навигацийн төлөвлөгөөнд тусгасан болно. Хэмжилт, ажиглалт болон урьдчилсан мэдээний нарийвчлалыг PANS-MET (Doc 10157)-ийн Attachment A, B-д тусгасан болно.

2.2.5 **Зөвлөмж** - *Үйл ажиллагааны зорилгоор цаг уурын мэдээллийг харилцан солилцоход ашиглагдах чанарын систем нь мэдээ, мэдээллийг хуваарийн дагуу дамжуулж байгаа эсэхийг шалган баталгаажуулах, холбогдох дүрэм, журамд нийцэж буй эсэхийг шалгадаг байх шаардлагатай. Чанарын систем нь дамжуулсан мэдээ, мэдээллийг хугацааны хувьд хоцроосон эсэхийг илрүүлэх чадвартай байна.*

Тайлбар. Конвенцын Хавсралт 3-ын Chapter 11-д тусгасан цаг уурын шуурхай мэдээлэл солилцоход тавигдах шаардлагыг хангасан байна.

2.2.6 Чанарын тогтолцооны аудитаар үл тохирлын нотлох баримтыг илрүүлнэ. Хэрэв тогтолцооны зөрчил илэрсэн бол шалтгааныг олж тогтоох,

ХЯНАЛЫН ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ҮЙЛЧЛЭЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 07
ХУУЛБАР ҮНЭН
Арх462
(Албан тушаалын нэр)
Чанар
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
26 оны 01 дугаар сарын 29

ЭХ ХУЛ
26 А/17

арилгах арга хэмжээ авна. Аудитын бүх ажиглалт нь нотолгоотой, зохих ёсоор баримтжуулсан байна.

2.2.7 Цаг хугацаа, орон зайн дунд орших цаг уурын элементүүдийг тодорхойлсон өгөгдөл мэдээллийг ашиглах тохиолдолд ажиглалтын үед хэрэглэгдсэн техникийн хязгаарлалт, зарим элементийг тодорхойлох явцад үүссэн хязгаарлагдмал нөхцөл байдлаас шалтгаалсан аливаа утгыг мэдээлэл хүлээн авагч тал тухайн үеийн бодит нөхцөл байдалд хамгийн ойролцоо утгаар нийцүүлж ойлгоно.

Тайлбар. Хэмжилт, ажиглалтын үйл ажиллагааны нарийвчлалын зааврыг PANS-MET (Doc 10157) Attachment A)-д заасан болно.

2.2.8 Цаг хугацаа, орон зайн дунд орших цаг уурын элементүүдийн урьдчилсан мэдээ, мэдээллийг ашиглах тохиолдолд ажиглалтын үед хэрэглэгдсэн техникийн хязгаарлалт, зарим элементийг тодорхойлох явцад үүссэн хязгаарлагдмал нөхцөл байдлаас шалтгаалах урьдчилсан мэдээний аливаа утгыг мэдээлэл хүлээн авагч тал тухайн үеийн бодит нөхцөл байдалд хамгийн ойролцоо утгаар нийцүүлэн ойлгоно. Урьдчилсан мэдээнд аливаа элемент үүсэх, өөрчлөгдөх цагийг зааж өгсөн бол энэ хугацааг хамгийн боломжит хугацаа гэж ойлгоно.

Тайлбар. Урьдчилсан мэдээний нарийвчлалын зааврыг PANS-MET (Doc 10157)-ийн Attachment B-д тусгасан болно.

2.2.9 Энэ зүйлийн 2.1.2-т заасан хэрэглэгчдийг хангах цаг уурын мэдээлэл нь хүний хүчин зүйлийн зарчимд нийцсэн байх бөгөөд түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой зааварчилгаа нь ICAO-ийн баримт бичиг Doc 9683 (Human Factors Training Manual)-т тусгасан болно.

2.2.10 **Зөвлөмж** – *Тухайн улс нь 2.1.2-т заасан хэрэглэгчдийг цаг уурын мэдээллээр хангана.*

Тайлбар 1. Систем даяарх мэдээллийн менежмент (SWIM)-ийн хүрээнд мэдээллийн үйлчилгээний тухай ойлголт нь машинаас машин хоорондын харилцан үйлчлэлийг авч үздэг.

Тайлбар 2. Мэдээллийн үйлчилгээний журмыг Procedures for Air Navigation Services Information Management PANS-AIM (Doc 10199)-д тусгасан.

Тайлбар 3. Мэдээллийн үйлчилгээний тухай гарын авлагыг Manual on System-wide Information Management Implementation (Doc 10203)-д тусгасан болно.

2.3 Агаарын тээвэрлэгчдээс шаардах мэдээлэл (Notifications required from operators)

2.3.1 Цаг уурын үйлчилгээ авах болон одоо ашиглагдаж буй цаг уурын үйлчилгээг өөрчлөх шаардлагатай гэж үзвэл агаарын тээвэрлэгч нь тухайн нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагад урьдчилан мэдэгдэх ба урьдчилан мэдэгдэх хамгийн бага хугацааг талууд харилцан тохиролцсоны дагуу тогтооно.

2.3.2 Үйлчилгээ авах шаардлагатай агаарын тээвэрлэгч нь нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагад дараах тохиолдолд мэдэгдэнэ:

ГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Архив
(албан тушаалын нэр)
(гарын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 29
МОНГОЛ УЛ
ЗАМ, ТЭЭВРИЙН
ЭХ ХУВ
Сайд
26 А/17

a) шинэ чиглэл, эсхүл шинэ төрлийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байгаа;
b) хуваарьт нислэгийн үйл ажиллагаанд өөрчлөлт орох;
c) цаг уурын үйлчилгээнд нөлөөлөх бусад өөрчлөлтийг хийхээр төлөвлөж байгаа тохиолдолд.

Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагаас холбогдох зохицуулалтыг төлөвлөхөд шаардлагатай зохих бүх мэдээллийг агуулсан байна.

2.3.3 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагаас шаардсан тохиолдолд агаарын тээвэрлэгч, эсхүл нисэх багийн гишүүн нь хэрэглэгч байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр дараах мэдээллийг өгнө. Үүнд:
a) нислэгийн төлөвлөгөө;
b) хуваарьт бус нислэг төлөвлөгдсөн бол;
c) хойшлогдсон, урагшилсан, эсхүл цуцлагдсан нислэг.

2.3.4 **Зөвлөмж** – *Хуваарьт нислэгээс бусад тохиолдолд нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагад өгөх мэдээлэл нь агаарын тээвэрлэгчид нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага хооронд байгуулсан гэрээний дагуу дараах шаардлагатай зарим, эсхүл бүх мэдээллийг багтаана. Үүнд:*
a) нисэн гарах аэродром болон тооцоот цаг;
b) нисэн очих аэродром болон тооцоот цаг;
c) нисэх чиглэл болон аль нэгэн дундын аэродромд нисэн очих, нисэн гарах тооцоот цаг;
d) нислэгийн төлөвлөгөөний үйл ажиллагааг дуусгахад шаардлагатай бүсийн агаарын навигацийн төлөвлөгөөний жагсаалтад орсон бэлтгэл аэродромууд;
e) аяллын түвшин;
f) агаарын хөлгийн төрөл; ил харааны нислэгийн дүрмээр, эсхүл тоноглолтой агаарын хөлгийн;
g) нисэх багийн гишүүдийн хүссэн цаг уурын мэдээллийн төрөл/нислэгийн баримт бичгийн аль нэг, зөвлөмж, эсхүл зөвлөгөө);
h) зөвлөмж, зөвлөгөө болон нислэгийн баримт бичгийг авах цаг хугацаа.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
Чанцаа
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
26 01 дүгээр сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн
Дансын 26 А/17

Бүлэг 3. Цаг уурын алба болон дэлхийн системүүд, дэмжих төвүүд

3.1 Дэлхийн бүсийн урьдчилсан мэдээний төв (World area forecast centre)

Тайлбар 1. Дэлхийн бүсийн урьдчилан мэдээлэх системийн (WAFS) зорилго нь цаг уурын эрх бүхий байгууллага болон бусад хэрэглэгчдийг дэлхийн бүсэд дижитал хэлбэрийн нислэгийн замын цаг агаарын урьдчилсан мэдээгээр хангахад оршино. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхдээ дэлхийн бүсийн бүрэн, нэгдсэн, бодит байдалд тулгуурласан, нэгэн төрлийн системтэй, үр ашигтай, хувьсан өөрчлөгдөж буй технологийн давуу талыг ашиглана.

Тайлбар 2. Дэлхийн системүүд, дэмжих төвүүдийн стандартыг PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 3-ын Appendix 5-д тусгасан болно.

3.1.1 Монгол Улс нь Дэлхийн бүсийн урьдчилан мэдээлэх төв (WAFC) биш хэдий ч цаг уурын үйлчилгээг үзүүлэгч WAFC-ийн үүргийг мэдэж WAFC-тай харилцаж тэдний бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглана. Вашингтон, Лондоны төвөөс боловсруулан гаргасан зураг мэдээллийг хүлээн авч урьдчилсан мэдээ гаргахад ашиглаж, нисэх баг, агаарын тээвэрлэгчдэд дамжуулна. Эдгээр төвүүд нь дараах мэдээллүүдийг боловсруулан гаргадаг. Үүнд:

a) дэлхий нийтийн урьдчилсан мэдээг нэгдсэн байдлаар бэлтгэх:
   1. өндрийн салхи;
   2. өндрийн агаарын температур, чийгшил;
   3. нислэгийн түвшний геопотенциал өндөр;
   4. нислэгийн түвшин, тропопаузын температур;
   5. хамгийн их салхитай нислэгийн түвшин болон чиглэл, хурд;
   6. борооны бөөн үүл;
   7. мөстөлт;
   8. сэгсрэлт;

b) цаг агаарын онцгой үзэгдэл (SIGWX)-ийн урьдчилсан мэдээг бэлтгэх;

c) энэ зүйлийн a), эсхүл b)-д заасан урьдчилсан мэдээг тоон өгөгдөл хэлбэрээр нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон бусад хэрэглэгчдэд цаг уурын эрх бүхий байгууллагын зохицуулснаар гаргаж өгнө;

d) SIGWX урьдчилсан мэдээнд тусгахын тулд цацраг идэвхт бодис агаар мандалд тархсан мэдээллийг дэлхийн цаг уурын байгууллагын (WMO) холбогдох бүсийн цаг уурын тусгай төв (RSMC) хүлээн авч, орчны цацрагийн ослын үед хариу арга хэмжээ авах, агаарын тээврийг бүтээгдэхүүнээр хангах;

e) Галт уулын үнснээс сэрэмжлүүлэх төвүүдээс (VAACs) галт уулын идэвхжилтийн талаарх мэдээллийг хүлээн авч, тухайн мэдээллийг (SIGWX) урьдчилсан мэдээнд тусгах.

3.1.2 WAFC-ийн үйл ажиллагаа тасалдсан тохиолдолд түүний үүргийг бусад WAFC гүйцэтгэнэ.

3.2 Аэродромын цаг уурын алба (Aerodrome meteorological offices)

3.2.1 Агаарын навигацийн хэрэгцээг хангахад шаардлагатай цаг уурын үйлчилгээг үзүүлэх нэг, эсхүл хэд хэдэн нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагыг томилно.

ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
Чимэд
үсэг)(гарын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 23

ЭХ ХУВЬ
26 А/17

3.2.2 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь аэродром дахь нислэгийн үйл ажиллагааны хэрэгцээг хангахын тулд шаардлагатай тохиолдолд дараах чиг үүргийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь гүйцэтгэнэ. Үүнд:

a) хариуцаж буй FIR болон нислэгийн хөдөлгөөний удирдлагатай бүсэд нислэгийн үйл ажиллагаанд нөлөөлөх цаг агаарын нөхцөл байдлын урьдчилсан мэдээг тогтмол гаргах;
b) тухайн газрын цаг агаарын нөхцөлийн урьдчилсан мэдээг бэлтгэх, эсхүл гаргах;
c) тухайн аэродромын урьдчилсан мэдээг бэлтгэхэд цаг агаарын нөхцөлийг тогтмол судлах
d) нисэх багийн гишүүд, эсхүл нисэхийн хэрэглэгчдийг зөвлөмж, зөвлөгөө болон нислэгийн баримт бичгээр хангах;
e) нисэхийн хэрэглэгчдийг цаг уурын бусад мэдээллээр хангах;
f) цаг уурын мэдээллийг боломжит дэлгэцээр үзүүлэх;
g) цаг уурын мэдээллийг бусад цаг уурын байгууллагатай солилцох;
h) цаг уур, НХҮБ болон НМҮБ-ууд хооронд байгуулсан гэрээний дагуу НХҮ болон НМҮ-ний нэгжүүдэд галт уулын дэлбэрэлтийн өмнөх идэвхжил, галт уулын дэлбэрэлт, эсхүл галт уулын үнсэн үүлний талаарх мэдээллийг хүлээн авч, хангана.

3.2.3 Шаардлагатай тохиолдолд суултын урьдчилсан мэдээг өгнө.

3.2.4 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагагүй аэродромын хувьд:

a) тухайн улс нь шаардлагатай тохиолдолд цаг уурын мэдээллээр хангах нэг, эсхүл хэд хэдэн цаг уурын байгууллагыг томилно.
b) холбогдох аэродромд мэдээллийг ямар хэлбэрээр өгөхийг эрх бүхий байгууллага тогтооно.

Тайлбар 1. Нислэгийн цаг агаарын урьдчилсан мэдээний хангалтыг аймгуудын Ус, цаг уур, орчны шинжилгээний албад өөр хоорондоо орлон ажиллах журмыг мөрдөнө.

3.3 Цаг уурын үйлчилгээний алба (Meteorological watch offices)

3.3.1 Нислэгийн мэдээллийн бүс (FIR), эсхүл удирдлагын бүс (CTA) дотор агаарын хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн улс нь гэрээний дагуу цаг уурын байгууллагыг томилох, эсхүл өөр улстай байгуулахаар зохицуулна.

Тайлбар. Цаг уурын ажиглалтын албаны үйлчилгээний заалтууд бүхий улс орнуудын хоорондын хамтын ажиллагаа болон төлөөллийг агуулсан хоёр талт, эсхүл олон талт гэрээний зааврыг Manual of Aeronautical Meteorological Practice (Doc 8896)-д тусгасан болно.

3.3.2 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь:

a) хариуцсан бүсдээ нислэгийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй цаг агаарын нөхцөлүүдийг байнга хянаж байх;
b) хариуцсан бүсдээ SIGMET болон бусад мэдээллийг бэлтгэх;
c) НХҮ-ний нэгжүүдийг SIGMET болон шаардлагатай бол цаг уурын бусад мэдээллээр хангах;
d) SIGMET мэдээг түгээх;
e) 7.5.1.1-д заасан мэдээллийг гэрээнд заасан тохиолдолд:
    1) хариуцаж буй бүсийн AIRMET мэдээг бэлтгэх;
    2) НХҮ-ний нэгжүүдийг AIRMET мэдээгээр хангах;
    3) AIRMET мэдээг түгээх;
f) галт уулын идэвхжил, галт уулын дэлбэрэлт, галт уулын үнсэн үүл, тропикийн циклоны тухай SIGMET мэдээнд хараахан тусгагдаагүй галт

ОРОН НУТАГ, УУРЫН АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ... Архив Чанцал ... 26 01 дугаар сарын 29
МОНГОЛ УЛСЫН ... ЭХ ХУВЬ ... 26 А/17

уулын идэвхжилийн талаар хүлээж авсан мэдээллийг нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон НХҮ-ний албад хооронд байгуулсан гэрээнд зааснаар холбогдох ACC's, FIC's-д нийлүүлэх үүрэгтэй;

g) нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон НХҮ-ний алба хооронд харилцан тохиролцсоны дагуу өөрийн хяналтын бүс, эсхүл хөрш зэргэлдээх бүсийн агаар мандалд цацраг идэвхт бодис тархсан талаар хүлээн авсан мэдээллийг холбогдох ACC/FIC-д болон агаарын тээвэрлэгчид мэдээлнэ. Эдгээр мэдээлэлд цацраг идэвхт бодисын байршил, цацагдсан өдөр, цаг мөн цацраг идэвхт бодисын чиглэлийг тус тус тусгасан байна.

Тайлбар. Хүрээлэн буй орчинд тархсан цацрагийн аюулын үед хариу арга хэмжээ авах зорилгоор тархцын загвар бүтээгдэхүүнүүдийн заалтууд дахь бүсийн тусгай цаг уурын төвүүдээс (RSMCs) хангаж байгаа мэдээлэл нь цацраг идэвхт бодис агаар мандалд тархсан улс, эсхүл Олон улсын атомын энергийн агентлагийг (IAEA) төлөөлсөн эрх бүхий байгууллагын шаардлагад тулгуурласан байна.

3.3.3 **Зөвлөмж** – *Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын хяналт тавих талбайн хил хязгаар нь нислэгийн мэдээллийн бүс (FIR), эсхүл удирдлагын бүсийн (CTA) хил хязгаартай, эсхүл тэдгээрийн хослолтой давхцах ёстой.*

3.3.4 **Зөвлөмж** – *Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь SIGMET-ийг түүний ойр орчмын хөрш зэргэлдээ цаг уурын албадтай хамтран зохицуулах ба ялангуяа нислэгийн замд ажиглагдсан цаг агаарын онцгой үзэгдэл хүрээгээ тэлэх, эсхүл цаг уурын ажиглалтын албаны тогтоосон хилээс давах төлөвтэй бол тэдгээртэй уялдуулан SIGMET мэдээгээр хангах.*

Тайлбар. SIGMET мэдээллийг дамжуулах талаар тухайн улсын цаг уурын ажиглалтын албадтай хоёр талт, эсхүл олон талт зохицуулалтын зааврыг Manual of Aeronautical Meteorological Practice (Doc 8896)-д тусгасан болно.

3.4 Галт уулын үнснээс сэрэмжлүүлэх төв (Volcanic ash advisory centres, VAAC)

3.4.1 Монгол Улс нь галт уулын үнснээс сэрэмжлүүлэх төв биш хэдий ч цаг уурын үйлчилгээг үзүүлэгч VAAC-ийн үүргийг мэдэж VAAC-тай харилцаж тэдний бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглана. Токиогийн галт уулын үнснээс сэрэмжлүүлэх төв (Washington, Anchorage, Montreal, London, Tokyo, Toulouse, Wellington, Buenos Aires, Darwin)-өөс гаргасан галт уулын үнсний тухай мэдээлэл, галт уулын дэлбэрэлтийн мэдээллийг хүлээн авч нисэх баг, агаарын тээвэрлэгчид, НХҮБ-д дамжуулна.

3.5 Тропикийн циклоноос сэрэмжлүүлэх төв (Tropical cyclone advisory centres, TCAC)

3.5.1 Монгол Улс нь Тропикийн циклоноос сэрэмжлүүлэх төв биш хэдий ч цаг уурын үйлчилгээг үзүүлэгч нь TCAC-ийн үүргийг мэдэж, TCAC-тай харилцаж тэдний бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглана. Токиогийн тропикийн циклоноос сэрэмжлүүлэх төв (Darwin, Honolulu, Miami, Nadi, New Delhi, Réunion, Tokyo)-өөс гаргасан мэдээллийг хүлээн авч нисэх баг, агаарын тээвэрлэгчид, НХҮБ-д дамжуулна.

3.6 Сансрын цаг агаарын төв (Space weather centres, SWXC)

3.6.1 Монгол Улс нь Сансрын цаг агаарын төв биш хэдий ч цаг уурын үйлчилгээг үзүүлэгч нь SWXC-ийн үүргийг мэдэж SWXC-тай харилцаж тэдний бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглана. Сансрын цаг агаарын төвөөс гаргасан мэдээллийг хүлээн авч нисэх баг, агаарын тээвэрлэгчид НХҮБ-д дамжуулна.

ЗАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архив 2
(Албан тушаалын нэр)
Чанар
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
26 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн
Дансын 26 А/17

Бүлэг 4. Аэродромын цаг уурын ажиглалтын мэдээлэл

4.1 Нисэхийн цаг уурын өртөө ба ажиглалт (Aeronautical meteorological stations and observations)

4.1.1 Аэродромын нисэхийн цаг уурын өртөөг байгуулна. Нисэхийн цаг уурын өртөө нь бие даасан, эсхүл урьдчилан мэдээлэх албатай хамт байрладаг байж болно.

Тайлбар. Агаарын навигацийн цаг уурын үйлчилгээг Конвенцын Хавсралт 3-ын шаардлагад нийцүүлж аэродромын гадна суурилуулсан мэдрэгчийг нисэхийн цаг уурын өртөөний ажиглалтад ашиглаж болно.

4.1.2 **Зөвлөмж** – *Нисдэг тэрэгний үйл ажиллагаа эрхлэгч байгууллага нь гэрээнд тусгаснаар, эсхүл ICAO-ын баримт бичиг Doc 9261-ийн 8.2-т заасны дагуу нислэг үйлдэхээр төлөвлөж буй байрлалд цаг уурын тоног төхөөрөмжүүдийг байршуулж, үйл ажиллагаандаа ашиглах ажлыг зохион байгуулна.*

4.1.3 Аэродром дээрх нисэхийн цаг уурын өртөө нь PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 2-ын дагуу тогтмол хугацаанд байнгын ажиглалт хийнэ. Аэродром дээрх газар орчмын салхи, АБХ, ХБЗ-ын дагуух АБХ, цаг агаарын үзэгдэл, үүл, эсхүл агаарын температурт онцгой өөрчлөлт гарвал тусгай ажиглалтуудыг нэмэлтээр хийнэ.

4.1.4 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь ажиглалтын чанар, багаж хэрэгсэл, тэдгээрийн үзүүлэлтүүдийн үнэн зөв ажиллагаа болон багажийн суурилуулалтад мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан эсэхийг шалгахын тулд байнгын давтамжтайгаар нисэхийн цаг уурын өртөөнүүдэд шалгалт хийх ажлыг зохион байгуулна.

Тайлбар. Нисэхийн цаг уурын өртөөг шалгах заавар, баталгаажуулалтын давтамжийг Manual on Automatic Meteorological Observing Systems at Aerodromes (Doc 9837)-д тусгасны дагуу хийнэ.

4.1.5 CAT II ба III ангиллын аэродром байхгүй тул энэ заалт хамааралгүй.

Тайлбар 1. Нарийвчлалтай ойртолт болон суултын ангиллуудыг Конвенцын Хавсралт 6, Part I-т тусгасан болно.

Тайлбар 2. Хүний хүчин зүйлийн зарчмуудын хэрэгжүүлэх зааврыг Human Factors Training Manual (Doc 9683)-д тусгасан болно.

4.1.6 **Зөвлөмж** – *ХБЗ-тай аэродром дээрх CAT I ангиллаар тоноглогдсон ойртолт болон суултын үйл ажиллагаанд газар орчмын салхи, АБХ, ХБЗ-ын дагуух АБХ, үүлний суурийн өндөр, агаарын температур, шүүдэр цэгийн температур болон агаарын даралтыг шаардлагатай бол хэмжих, үнэлэх, эсхүл хянах зориулалттай автомат багажийг ойртолт болон суулт, хөөрөлтийн үйл ажиллагааг хангах зорилгоор суурилуулна. Эдгээр төхөөрөмжүүд нь хадгалах, боловсруулах болон түгээхээс гадна суулт, хөөрөлтийн үйл ажиллагаанд нөлөөлөх цаг уурын параметрүүдийг дэлгэцээр үзүүлэх зориулалттай байна.*

САЙГАЛЬ ОРЧИН ХУРАМЖЛАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ

4.1.7 **Зөвлөмж** – *Цаг уурын мэдээллийг түгээх/дэлгэцээр үзүүлэхэд ашиглаж байгаа хагас автомат системтэй байгаа тохиолдолд автоматаар ажиглах боломжгүй цаг уурын элементүүдийг гараар оруулах боломжтой байх ёстой.*

4.1.8 Цаг уурын элементүүдийн орон зай, цаг хугацааны хувьсал өөрчлөлт, ажиглалтын технологи, зарим элементүүдийг автоматаар тодорхойлох боломжгүй байдлын улмаас мэдээнд өгч буй элементүүдийн утгыг ажиглалтын хугацаан дахь бодит нөхцөлд хамгийн их ойртсон утга гэж үзнэ.

4.1.9 **Зөвлөмж** – *Аэродромын цаг уурын тоног төхөөрөмжүүд нь хэмжилт хийх шаардлагатай бүсийг төлөөлөхүйц байршилд байрлана.*

Тайлбар. Аэродромын үйл ажиллагааны талбайд тоног төхөөрөмжийг байрлуулах, агаарын хөлөгт учрах гэмтлийн эрсдэлийг хамгийн бага болгох зорилготой техникийн шаардлагуудыг Конвенцын Хавсралт 14, Volume I, Chapter 9-д тусгасан.

4.1.10 **Зөвлөмж** – *Нисэхийн цаг уурын станц дахь багаж хэрэгслүүдийг Дэлхийн цаг уурын байгууллага (WMO)-оос батлсан практик, журам, техникийн шаардлагын дагуу ажиллуулж, засвар үйлчилгээ хийнэ.*

Тайлбар. ДЦУБ-ын журам, техникийн шаардлагуудыг Guide to Instruments and Methods of Observation (WMO-No. 8), Volume I — Measurement of Meteorological Variables, Volume II— Observing Systems; and Volume III— Quality Assurance and Management of Observing Systems-д тусгасан.

4.1.11 **Зөвлөмж** – *Аэродром дээрх цаг уурын ажиглагчид нь ажиглалт хийх шаардлагатай бүсийг төлөөлөх боломжтой байршилд байрлана.*

4.1.12 **Зөвлөмж** – *Хагас автомат ажиглалтын системийн нэг хэсэг болсон автомат тоног төхөөрөмжийн өгөгдлийн дэлгэц нь тухайн орон нутгийн нислэг хөдөлгөөний үйлчилгээний нэгж, цаг уурын үйлчилгээний нэгжид үзүүлж буй мэдээллийн хэсэг байх бөгөөд нэг эх үүсвэртэй байна. Эдгээр дэлгэцүүд дээр цаг уурын элемент бүрийн хамаарах байршлыг тохиромжтойгоор тэмдэглэнэ.*

4.2 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага хооронд байгуулсан гэрээ (Agreement between meteorological service provider and appropriate air traffic services authority)

4.2.1 **Зөвлөмж** – *Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон НХҮБ хооронд байгуулсан гэрээнд дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:*

a) НХҮ-ний нэгжүүдэд хүргэх нэгдмэл автомат системтэй холбогдсон дэлгэцийн мэдээллийн хангалт;

b) дэлгэц болон багаж, тоног төхөөрөмжүүдийн шалгалт тохиргоо, засвар үйлчилгээ;

c) НХҮ-ний ажилтны дэлгэц болон багаж, тоног төхөөрөмжүүдийг ашиглалт;

d) цаг агаарын нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд НХҮ-ний ажилтнууд нүдэн баримжааны ажиглалт хийх (тухайлбал: өндөр авалт болон ойртолтын бүсэд нислэгт нөлөөлөх цаг уурын үзэгдлийг ажиглах гэх мэт);

e) хөөрч буй, эсхүл суулт хийж буй агаарын хөлгөөс ажигласан цаг уурын мэдээ (тухайлбал: салхины шилжлэг);
f) цаг уурын радарын мэдээлэл (хэрэв боломжтой бол);

Тайлбар. HXY болон Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын хоорондын зохицуулалтыг Manual on Coordination between Air Traffic Services, Aeronautical Information Services and Aeronautical Meteorological Services (Doc 9377)-д тусгасан болно.

4.3 Байнгын ажиглалт болон мэдээ (Routine observations and reports)

Тайлбар. Байнгын ажиглалтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 2.1.1-д тусгасны дагуу хийнэ.

4.3.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь PANS-MET (Doc 10157)-ийн Section 2.1.1-ийн дагуу аэродром дээрх байнгын ажиглалтыг өдөр бүр тасралтгүй 24 цагийн турш ажиглана. Байнгын ажиглалтыг нэг цагийн зайтай, эсхүл 30 минутын зайтай хийж болно. Нисэхийн цаг уурын бусад өртөөнүүдэд HXY-ний нэгж, агаарын хөлгийн үйл ажиллагааны шаардлагыг харгалзан нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагаас тогтоосон ажиглалтуудыг хийнэ. Олон улсын нисэх буудалд 24 цагаар, орон нутгийн нисэх буудлуудад нислэг эхлэхээс дуусах хугацаанд цаг агаарын байнгын ажиглалтыг хийнэ.

4.3.2 Байнгын бодит ажиглалтын мэдээг дараах байдлаар гаргана. Үүнд:
a) зөвхөн аэродромын орчимд дамжуулахад зориулсан тухайн газрын байнгын мэдээ - (агаарын хөлгийн нисэн ирэх болон нисэн гарахад зориулсан);

Тайлбар. Орон нутгийн байнгын ажиглалтын техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 2, 2.1.1.1-д тусгасан.

b) аэродромоос гадагш дамжуулахад зориулсан METAR (нислэгийн төлөвлөлт болон VOLMET радио нэвтрүүлэгт зориулсан);

Тайлбар 1. METAR-н түгээлт, дамжуулалтын техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 2, 2.1.1.2, 2.1.1.3-д тусгасан.

Тайлбар 2. ATIS-д ашигласан цаг уурын мэдээллийг (voice ATIS) Конвенцын Хавсралт 11-ийн 4.3.6.1 g) заалтын дагуу тухайн газрын мэдээнээс гаргана.

4.3.3 4.3.1-д заасны дагуу 24 цагийн ажиллаагүй аэродромд METAR мэдээг аэродромын үйл ажиллагаа эхлэхээс өмнө гаргана.

4.4 Тусгай ажиглалт болон мэдээ (Special observations and reports)

Тайлбар. Энэ хэсэгтээ холбоотой журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 2.1.1, 2.1.2-т тусгасан болно.

4.4.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь PANS-MET (Doc 10157)-ийн Section 2.1.1, 2.1.2-ын дагуу НХҮБ, агаарын тээвэрлэгчид , нисэх буудал болон бусад хэрэглэгчидтэй зөвшилцсөний үндсэн дээр тусгай ажиглалтын мэдээний шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг гаргана.

4.4.2 Тусгай ажиглалтын мэдээг дараах байдлаар гаргана. Үүнд:

ТАЛГАЛЬ ОРЧИН УХАА АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
бүртгэлийн дугаар 607
ХҮЛЭЭЛГЭЭ ТЭНЭН
Архивч
түшаалын нэр)
Ганзаг
гарын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 29
МОНГОЛ УЛС
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн
даргын 26 А/17

a) зөвхөн аэродром орчимд дамжуулахад зориулсан тухайн газрын тусгай ажиглалтын мэдээ (агаарын хөлгийн нисэн ирэх, нисэн гарахад зориулсан);

Тайлбар. Орон нутгийн тусгай ажиглалтыг PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 2, 2.1.1.1-д тусгасны дагуу хийнэ.

b) METAR мэдээг 30 минутын зайтай гаргадаггүй бол аэродромоос гадагш дамжуулахад зориулсан SPECI мэдээ (нислэгийн төлөвлөлт, VOLMET радио нэвтрүүлэгт зориулсан).

Тайлбар 1. SPECI-ийг PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 2, 2.1.1.2, 2.1.1.3-д тусгасны дагуу түгээж, дамжуулна.

Тайлбар 2. ATIS-д ашигласан цаг уурын мэдээллийг (voice ATIS) Конвенцын Хавсралт 11-ийн 4.3.6.1 g) заалтын дагуу тухайн газрын мэдээнээс гаргана.

4.4.3 Энэ зүйлийн 4.3.1-д заасны дагуу 24 цагийн ажиллаагүй аэродромд METAR гаргасны дараа нөхцөл бүрдсэн үед SPECI-г гаргана.

4.5 Цаг уурын мэдээний үзүүлэлт (Characteristics of meteorological reports)

Тайлбар. Энэ хэсэгтэй холбоотой журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 2.1.1-т тусгасан болно.

4.5.1 Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI мэдээг дараах дарааллын дагуу гаргана.

a) газар орчмын салхины чиглэл, хурд;
b) АБХ;
c) ХБЗ-ын дагуух АБХ (нөхцөл бүрдсэн үед)
d) цаг агаарын үзэгдэл;
e) үүлний хэмжээ, хэлбэр (зөвхөн борооны бөөн болон, цамхаг хэлбэрийн бөөн үүл), үүлний суурийн өндөр, эсхүл хэмжсэн бол босоо чиглэлийн АБХ;
f) агаарын болон шүүдэр цэгийн температур;
g) QNH, шаардлагатай бол QFE (QFE-ийг зөвхөн тухайн газрын байнгын болон тусгай ажиглалтын мэдээнд оруулна).

4.5.2 **Зөвлөмж** – *Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI мэдээний 4.5.1-ийн a)-ээс g) хүртэлх элементүүд дээр нэмэлт мэдээлэл оруулж мэдээлнэ.*

4.5.3 Агаарын тээвэрлэгчидтэй зөвшилцсөний дагуу METAR, SPECI-ийн нэмэлт мэдээллийг оруулна.

4.5.4 Цаг уурын байгууламж, тоног төхөөрөмж (Meteorological Facilities and Equipment)

4.5.4.1 Энэ бүлэг нь цаг уурын байгууламж, тоног төхөөрөмжтэй холбоотой стандартыг тогтооно.

4.5.4.2 Цаг уурын байгууламж, тоног төхөөрөмж нь:

a) хэвийн ажиллагааг баталгаажуулахын тулд тогтмол шалгагдсан байх

ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
607
Архивч
Чанцэ
26 01
МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Дарын 26 А/17

b) тогтмол үзлэг шалгалт, хэмжилт тохируулга (routine calibration), тогтсон хугацаат эд ангийн солилт (regular parts replacement) болон системийн гэмтлийг цаг тухайд нь засварлах (timely resolution of system failures) нарийвчлал, найдвартай ажиллагаа, ажиллах чадварыг хангаж байх;
c) систем, дэд систем, тоног төхөөрөмжийн гэмтэл, доголдлын үр дагаврын талаарх баримт бичигтэй байх.

4.5.4.3 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь тоног төхөөрөмж бүрийн засвар үйлчилгээг дараах байдлаар зохион байгуулах ёстой:

a) тоног төхөөрөмж бүрийн засвар үйлчилгээний журам
b) байгууламж бүрийн сэлбэг хангалтын төлөвлөгөө

4.5.4.4 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь цаг уурын алба, байгууламж бүрийг тохиромжтой цахилгаан хангамж болон үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах шаардлагатай хэрэгслээр хангагдсан байхыг баталгаажуулна.

4.5.4.5 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь цаг уурын хэмжилт хийх байгууламж бүрийг орон нутгийн цаг агаарын нөхцөл байдлыг үнэн зөв тусган харуулахуйц техникийн хувьд засвар үйлчилгээ хийх тохиромжтой байршилд суурилуулна.

4.5.4.6 Цаг уурын эрх бүхий байгууллага нь ажиглалтын өндөр чанар, багаж хэрэгсэл, тэдгээрийн үзүүлэлтүүдийн үнэн зөв ажиллагаа болон багажийн суурилуулалтад мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан эсэхийг шалгахын тулд байнгын давтамжтайгаар нисэхийн цаг уурын өртөөнүүдэд шалгалт хийх ажлыг зохион байгуулна.

Тайлбар. Нисэхийн цаг уурын өртөөг шалгах заавар, баталгаажуулалтын давтамжийг Manual on Automatic Meteorological Observing Systems at Aerodromes (Doc 9837)-д тусгасны дагуу хийнэ.

4.5.4.7 ХБЗ-тай аэродром дээрх CAT I ангиллаар тоноглогдсон ойртолт болон суултын үйл ажиллагаанд газар орчмын салхи, АБХ, ХБЗ-ын дагуух АБХ, үүлний суурийн өндөр, агаарын температур, шүүдэр цэгийн температур болон агаарын даралтыг шаардлагатай бол хэмжих, үнэлэх, эсхүл хянах зориулалттай автомат багажийг ойртолт болон суулт, хөөрөлтийн үйл ажиллагааг хангах зорилгоор суурилуулна. Эдгээр төхөөрөмжүүд нь хадгалах, боловсруулах болон түгээхээс гадна суулт, хөөрөлтийн үйл ажиллагаанд нөлөөлөх цаг уурын параметрүүдийг дэлгэцээр үзүүлэх зориулалттай байна.

4.5.5 Цаг уурын ажиглалтын автомат систем (Automated Weather Observing System (AWOS))

Тайлбар 1. Цаг уурын ажиглалтын автомат системийг (Automated Weather Observing System) Конвенцын Хавсралт 3-ын Appendix 3, ICAO-ын баримт бичиг Doc 8896, 9328, 9837 болон 9157-ын Part 6-р хэсгийн дагуу суурилуулна.

Тайлбар 2. Энэ хэсэгтээ холбоотой журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 2.2-т тусгасан болно.

ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ЗАЙГАЛЬ ОРЧИН ТҮҮНИЙ ЯАМЫН
ЗАМ, ТЭЭВЭР
Архив 2
(гарын үсгийн тайлал)
21 дүгээр сарын 29
ЭХ ХЯ
Саид Тариф
Дарын 26 А/17

4.5.5.1 Цаг уурын мэдээллийг түгээх/дэлгэцээр үзүүлэхэд ашиглаж байгаа хагас автомат системтэй байгаа тохиолдолд автоматаар ажиглах боломжгүй цаг уурын элементүүдийг гараар оруулах боломжтой байна.

4.5.5.2 Аэродромын цаг уурын тоног төхөөрөмжүүд нь хэмжилт хийх шаардлагатай бүсийг төлөөлөхүйц байршилд байрлана.

Тайлбар. Аэродромын үйл ажиллагааны талбайд тоног төхөөрөмжийг байрлуулах, агаарын хөлөгт учрах гэмтлийн эрсдэлийг хамгийн бага болгох зорилготой техникийн шаардлагуудыг Конвенцын Хавсралт 14, Боть I, Бүлэг 9 (Конвенцын Хавсралт 14, Volume I, Chapter 9)-д тусгасан.

4.5.5.3 Нисэхийн цаг уурын станц дахь цаг уурын багаж хэрэгслүүдийг Дэлхийн цаг уурын байгууллага (WMO)-оос баталсан практик, журам, техникийн шаардлагын дагуу ажиллуулж, засвар үйлчилгээ хийнэ.

Тайлбар. ДЦУБ-ын журам, техникийн шаардлагуудыг Ажиглалтын багаж хэрэгсэл ба аргуудын гарын авлага (ДЦУБ-8), Боть I - Цаг уурын хувьсагчдын хэмжилт, Боть II - Ажиглалтын системүүд; болон Боть III - Ажиглалтын системийн чанарын баталгаа ба менежмент (Guide to Instruments and Methods of Observation (WMO-No. 8), Volume I— Measurement of Meteorological Variables, Volume II— Observing Systems; and Volume III— Quality Assurance and Management of Observing Systems)-д тусгасан.

4.5.5.4 Хагас автомат ажиглалтын системийн нэг хэсэг болсон автомат тоног төхөөрөмжийн өгөгдлийн дэлгэц нь тухайн орон нутгийн нислэг хөдөлгөөний үйлчилгээний нэгж, цаг уурын үйлчилгээний нэгжид үзүүлж буй мэдээллийн хэсэг байх бөгөөд нэг эх үүсвэртэй байна. Эдгээр дэлгэцүүд дээр цаг уурын элемент бүрийн хамаарах байршлыг тохиромжтойгоор тэмдэглэнэ.

4.6 Цаг уурын элементийг ажиглах болон мэдээлэх (Observing and reporting meteorological elements)

Тайлбар. Цаг уурын элементийг PANS-MET (Doc 10157)-ийн Section 2.2-т тусгасны дагуу ажиглаж мэдээлнэ.

4.6.1 Газар орчмын салхи (Surface wind)

4.6.1.1 Газар орчмын салхины дундаж чиглэл, хурд мөн түүний эрс өөрчлөлтүүдийг хэмжиж, градус, м/с-ээр мэдээлнэ.

4.6.1.2 **Зөвлөмж** – *Тухайн газрын байнгын болон тусгай мэдээнд өгсөн газар орчмын салхины ажиглалт нь нисэн гарах гэж буй агаарын хөлөгт зурвасын дагуух, харин нисэн ирж буй агаарын хөлөгт газардах бүс (touchdown zone)-ийг заана.*

4.6.1.3 **Зөвлөмж** – *METAR, SPECI-д өгсөн газар орчмын салхины ажиглалтын мэдээ нь нэг зурвастай бол зурвасын бүхий л хэсэг дэх нөхцөл байдлыг, нэгээс олон зурвастай тохиолдолд тэдгээр зурвасыг бүхэлд нь илэрхийлсэн байна.*

4.6.1.4 Дэлгэц

а) Газар орчмын салхины мэдрүүр бүртэй холбоотой дэлгэцүүдийг цаг уурын өртөө, НХҮ-ний нэгжид суурилуулна.

ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ...
...ртэгийн дугаар 607
...УЛГАР ҮНЭН
Архив2
...алын нэр)
Чанар
...н үсгийн тайлал)
26 01 ...газар сарын 29

Монгол...
ЭХ ХУВЬ
Саид Терин ...
Дагын ...
2026 А/17

Цаг уурын өртөө болон НХҮ-ний нэгжид суурилуулсан дэлгэцүүдийн мэдрүүрүүд нэг эх үүсвэртэй байх бөгөөд нэмэлт мэдрүүрүүдийг байрлуулсан тохиолдолд дэлгэцэд мэдрүүр бүрийн ХБЗ-ын аль хэсгүүдийг хянаж буйг нарийн ялган зааж өгсөн байх шаардлагатай.

b) Автомат төхөөрөмжийн тусламжтайгаар газар орчмын салхины мэдрүүр бүр дээрх чиглэл, хурдны утгыг дундажлах болон эрс өөрчлөлтийг тодорхойлон дэлгэцээр үзүүлнэ

4.6.1.5 Хэмжилтийн нарийвчлал

a) Газар орчмын салхины чиглэл, хурд мөн салхины дундаж хурдны хазайлтын нарийвчлалыг Конвенцын Хавсралт 3-ын Attachment А-д заасны дагуу Нэмэлт А-д тусгасан.

4.6.2 Алсын барааны харагдац (Visibility)

4.6.2.1 Бүлэг 1-д тодорхойлсон АБХ-ыг хэмжиж, эсхүл ажиглаж, метрээр, эсхүл километрээр мэдээлнэ.

Тайлбар. Багажийн заалтыг АБХ болгон хувиргах зааврыг PANS-MET (Doc 10157)-ийн Attachment D-д заасны дагуу Нэмэлт D-д тусгасан.

4.6.2.2 **Зөвлөмж** – *Орон нутгийн байгуулалтын болон тусгай ажиглалтын мэдээнд өгсөн АБХ-ын ажиглалт нь нисэн гарах гэж буй агаарын хөлөгт зурвасын дагуух, харин нисэн ирж буй агаарын хөлөгт газардах бүсийг заана.*

4.6.2.3 **Зөвлөмж** – *METAR, SPECI-д өгсөн АБХ-ын ажиглалт нь аэродромын нөхцөл байдлыг илэрхийлнэ.*

4.6.2.4 Дэлгэц

a) АБХ-ыг хэмжихдээ автомат ажиглалтын систем ашигладаг бол мэдрүүр бүрд холбоотой АБХ-ын өгөгдлийг гаргах дэлгэцүүдийг цаг уурын өртөө, НХҮ-ний нэгжүүдэд суурилуулна. Цаг уурын өртөө болон НХҮ-ний нэгжүүдэд суурилуулсан дэлгэцүүдийн мэдрүүрүүд нь нэг эх үүсвэртэй байна.

4.6.3 ХБЗ-ын дагуух АБХ (Runway Visual Range)

Тайлбар. ХБЗ-ын дагуух АБХ-ын зааврыг Manual of Runway Visual Range Observing and Reporting Practices (Doc 9328)-д тусгасан болно.

4.6.3.1 Энэ заалт хамааралгүй тул орхилт хийгдсэн.

4.6.3.2 Бүлэг 1-д тодорхойлсон ХБЗ-ын дагуух АБХ-ыг АБХ муудах үед тодорхойлно. Үүнд:

a) CAT I ангиллаар тоноглогдсон ойртолт болон суултын үйл ажиллагаанд зориулсан ойртолтын нарийвчлалтай зурвасууд;

b) хөөрөлтөд ашиглагддаг, өндөр чадалтай ХБЗ-ын дагуух болон тэнхлэгийн гол шугамын гэрэлтэй зурвасууд

Тайлбар. Нарийвчлалтай ойртолтын зурвасуудыг Конвенцын Хавсралт 14, Volume I, Chapter 1, "Instrument runway"-д тодорхойлсон болно.

ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
ГАР ҮНЭН
Архив
Хянасан
26 01 дугаар сарын 29
МОНГОЛ УЛС
ЗАМ, ТЭЭВРИЙН
ЭХ ХУВ
Сайд
26 А/17

4.6.3.3 4.6.3.1 болон 4.6.3.2-д тодорхойлсон ХБЗ-ын дагуух АБХ-ийг АБХ, эсхүл ХБЗ-ын дагуух АБХ-ын хэмжээний аль нэг нь 1500 метрээс бага болсон үед метрээр илэрхийлж мэдээлнэ.

4.6.3.4 ХБЗ-ын дагуух АБХ-ын үнэлгээ нь дараах байдлыг илэрхийлнэ.

a) нарийвчлалгүй, эсхүл ойртолт болон суултын CAT I ангиллаар тоноглогдсон үйл ажиллагаанд зориулагдсан зурвасын газардах бүс;

4.6.3.5 ХБЗ-ын дагуух АБХ-ыг үнэлэхэд ашигладаг автомат төхөөрөмжийн ашиглалтын байдалд гарсан өөрчлөлтийг аэродромын НХҮ болон НМҮ-ний нэгжүүдэд цаг алдалгүй мэдээлнэ.

4.6.3.6 Дэлгэц

a) ХБЗ-ын дагуух АБХ-ын хэмжилтийг автоматжуулсан төхөөрөмжийн тусламжтайгаар хийдэг бол нэг дэлгэцийг (эсхүл зайлшгүй шаардлагатай бол хэд хэдийг) цаг уурын өртөө, НХҮ-ний нэгжүүдэд суурилуулна. Цаг уурын өртөө болон НХҮ-ний нэгжүүдэд суурилуулсан дэлгэцүүдийн мэдрүүрүүд нь нэг эх үүсвэртэй байна.

4.6.4 Цаг агаарын үзэгдэл (Present weather)

4.6.4.1 Аэродром дээрх цаг агаарын үзэгдлийг ажиглаж, мэдээлнэ. Цаг агаарын дараах үзэгдлүүдийг-заавал тодорхойлно. Үүнд:

a) Хур тунадас: бороо, шиврээ бороо, цас, зайрмагтсан хур тунадас (тэдгээрийн эрчмийг оруулаад)
b) Алсын барааны харагдац муутгагч: униар, будан, манан, хэт хөрсөн манан
c) дуу цахилгаан (ойролцоо дуу цахилгаан ороод)

4.6.4.2 **Зөвлөмж** – *Орон нутгийн байнгын болон тусгай мэдээнд цаг агаарын үзэгдлийн мэдээлэл нь тухайн аэродром дээрх цаг агаарын нөхцөл байдлыг илэрхийлсэн байна.*

4.6.4.3 **Зөвлөмж** – *METAR, SPECI-д цаг агаарын үзэгдлийн мэдээлэл нь аэродром дээрх болон зарим цаг агаарын онцгой үзэгдлийн хувьд аэродромын ойролцоох нөхцөл байдлыг илэрхийлсэн байна.*

4.6.4.4 Байршил

a) Цаг агаарын үзэгдлүүдийг автомат төхөөрөмжийн системээр ажигладаг бол мэдрүүрийг орчноо хамгийн сайн төлөөлөхүйц газар байрлуулна.

4.6.5 Үүлшил (Clouds)

4.6.5.1 Үүлний хэмжээ, төрөл болон суурийн өндрийг ажиглаж, мэдээлэх бөгөөд шаардлагатай бол үйл ажиллагаанд нөлөөлөх үүлийг тодорхойлно. Тэнгэр бүрхэг үед үүлний хэмжээ, үүлний төрөл, үүлний суурийн өндрийн оронд босоо чиглэлийн АБХ-ыг ажиглаж, хэмжсэн тохиолдолд мэдээлнэ. Үүлний суурийн өндөр болон босоо чиглэлийн АБХ-ыг метрээр (ft) мэдээлнэ.

ЭРЧИЛЛЭЛ ОРЧИН, УУРЫН ЯАМ
ЭРЧИЛЛЭЛТИЙН ЯАМ
ийн дугаар 283
Р ҮНЭН
Архив2
ын нэр)
стийн тайлал)
26 01 ар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Дайчин 26 А/17

4.6.5.2 **Зөвлөмж** - *Тухайн газрын байнгын болон тусгай мэдээнд үүлний ажиглалтыг ашиглахдаа зурвасын босго дээр гэж ойлгоно.*

4.6.5.3 **Зөвлөмж** – *METAR, SPECI-д үүлний ажиглалт нь аэродром болон түүний орчмын нөхцөл байдлыг илэрхийлнэ.*

4.6.5.4 Дэлгэц

a) Үүлний хэмжээ болон үүлний суурийн өндрийг хэмжихдээ автоматжуулсан системийг ашигладаг бол үүлний суурийн өндрийн дэлгэцүүдийг цаг уурын өртөө болон HXY-ний нэгжүүдэд суурилуулна. Эдгээр суурилуулсан дэлгэцүүдийн мэдрүүрүүд нэг эх үүсвэртэй байна.

4.6.6 Агаарын болон шүүдэр цэгийн температур (Air tempetarure and dew point temperature)

4.6.6.1 Агаарын болон шүүдэр цэгийн температурыг Цельсийн градусаар хэмжиж, мэдээлнэ.

4.6.6.2 **Зөвлөмж** – *Тухайн газрын байнгын, тусгай болон METAR, SPECI-д агаарын болон шүүдэр цэгийн температурын ажиглалт нь бүх зурвасын нөхцөл байдлыг илэрхийлнэ.*

4.6.6.3 Дэлгэц

a) Агаарын температур болон шүүдэр цэгийн температурыг хэмжихдээ автомат төхөөрөмжийн систем ашигладаг бол дэлгэцийг цаг уурын өртөө, HXY-ний нэгжүүдэд суурилуулна. Цаг уурын өртөө болон HXY-ний нэгжүүдэд суурилуулсан дэлгэцүүдийн мэдрүүр нь нэг эх үүсвэртэй байна.

4.6.7 Агаарын даралт (Atmospheric pressure)

4.6.7.1 Агаарын даралтыг хэмжиж, QNH-ын утгыг гектопаскал (гПа)-аар, QFE-ын утгыг миллиметр мөнгөн усны багана(мм муб)-аар тооцоолж мэдээлнэ.

4.6.7.2 Дэлгэц

a) Агаарын даралтыг хэмжихдээ автомат төхөөрөмжийн систем ашигладаг бол QNH дэлгэц болон хэрэв зайлшгүй шаардлагатай бол 4.7.3.2 b)-ийн дагуу QFE дэлгэцийг цаг уурын өртөө, бүсийн HXY-ний нэгжүүдэд суурилуулна. Цаг уурын өртөө, бүсийн HXY-ний нэгжүүдэд суурилуулсан дэлгэцүүдийн мэдрүүрүүд нь нэг эх үүсвэртэй байна.

4.6.8 Нэмэлт мэдээлэл (Supplementary information)

4.6.8.1 **Зөвлөмж** – *Ойртолт болон өндөр авалтын бүс дэх цаг агаарын онцгой нөхцөл байдлын талаарх боломжит нэмэлт мэдээллийг аэродромын ажиглалтын мэдээнд оруулна. Боломжтой бол тухайн цаг агаарын нөхцөлийн байршлыг тодорхойлсон байна.*

ЗАСАГ ЗАХИРГААНЫ ӨВЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛЬДАР ҮНЭН
Архив
(албан тушаалын нэр)
(гарын үсгийн тайлал)
26 01 (үгаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн
Дарын 26 А/17

4.7 Автомат ажиглалтын системээс гаргаж буй цаг уурын мэдээлэл (Reporting meteorological information from automatic observing systems)

4.7.1 **Зөвлөмж** – *Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь автомат ажиглалтын системээс гарч буй METAR, SPECI-ийг ажлын болон ажлын бус цагаар ашиглахдаа Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-д мэдээлсэн нисэх буудлын үйл ажиллагааны цагийн хуваарийг мөрдөнө.*

Тайлбар. Цаг уурын автомат ажиглалтын системийг ашиглах зааврыг ICAO-ын баримт бичиг Doc 9837-д тусгасан болно.

4.7.2 **Зөвлөмж** – *Автомат ажиглалтын системээс гарсан орон нутгийн газрын байнгын болон тусгай ажиглалтын мэдээг Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-д мэдээлсэн нисэх буудлын үйл ажиллагааны цагийн хуваарийг мөрдөнө.*

4.7.3 Автомат цаг уурын ажиглалтын системээс гаргаж буй тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-ийг "AUTO" таних үгээр ялгана.

4.7.4 *Нислэгийн цаг уурын бодит мэдээний үйлчилгээнд ашигладаг цаг уурын автомат станцын ажиглалтын аль нэг мэдрүүрт гэмтэл доголдол гарч тухайн элементийн бодит ажиглалтын хангалтыг хийх боломжгүй тохиолдолд цаг уурын бодит ажиглалтын мэдээг бүрэн бус мэдээ гэж үзнэ.

4.8 Галт уулын идэвхжилийг ажиглах болон мэдээлэх (Observing and reporting volcanic activity)

4.8.1 Монгол улсын хувьд идэвхтэй галт уул байхгүйгээс ажиглалт болон мэдээг гаргахгүй ба галт уулын сэрэмжлүүлгийн төвөөс ирүүлсэн галт уулын үнсний тухай мэдээлэл, галт уулын дэлбэрэлтийн мэдээллийг хүлээн авч нисэх баг, агаарын тээвэрлэгчдэд дамжуулна.

4.9 Цаг уурын мэдээллийн түгээлт (Dissemination of meteorological reports)

4.9.1 METAR ба SPECI (METAR and SPECI)

4.9.1.1 METAR ба SPECI мэдээг олон улсын OPMET өгөгдлийн санд түгээнэ.

4.9.1.2 METAR ба SPECI мэдээг нисэх буудлуудад түгээнэ.

4.9.1.3 Цаг агаарын нөхцөл байдал муудсаныг илэрхийлсэн SPECI-г ажиглалтын дараа нэн даруй түгээнэ. Цаг уурын нэг элемент муудаж, нөгөө элемент сайжирсан байдлыг илэрхийлсэн SPECI-г мөн ажиглалтын дараа нэн даруй түгээх шаардлагатай.

4.9.1.4 **Зөвлөмж** – *Цаг агаарын нөхцөл байдал сайжирсныг илэрхийлсэн SPECI-г 10 минутын турш тогтвортой хадгалагдсаны дараа түгээнэ. Хэрэв шаардлагатай бол уг мэдээг түгээхийн өмнө 10 минутын хугацааны төгсгөлд ажиглагдсан нөхцөл байдлыг тусгасан байдлаар засварлана.*

БАЙГАЛЬ ОРЧИНГ ХАМГААЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар . 607
ХУУЛБАР ҮНЭН
Архив
(албан тушаалын нэр)
Чимуун
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
26 он ны 01 дүгээр сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид Төрийн
дугаар 26 он А/17

4.9.2 Орон нутгийн байнгын болон тусгай мэдээ (Local routine report and local special report)

4.9.2.1 Орон нутгийн байнгын мэдээг PANS-MET (Doc 10157)-ийн Section 2.1.1, 2.1.2-ын дагуу нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжүүдэд, нисэх буудалд үйл ажиллагаа явуулж буй операторууд болон бусад хэрэглэгчдэд дамжуулна.

4.9.2.2 Орон нутгийн тусгай мэдээг тогтоосон нөхцөл байдал үүссэн даруйд орон нутгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжүүдэд дамжуулна. Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон нислэг хөдөлгөөний байгууллагын хооронд тохиролцсоны дагуу дараах тохиолдолд уг мэдээг гаргах шаардлагагүй болно. Үүнд:

a) Орон нутгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгж дэх дэлгэц нь цаг уурын станцын дэлгэцтэй ижил мэдээллийг бодитоор харуулж, уг дэлгэцийн мэдээллийг ашиглан орон нутгийн байнгын болон тусгай мэдээнд багтсан аливаа элементийн утга шинэчлэгдэж байвал;

b) Аэродром дээрх ажиглагч нь орон нутгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжид хөөрч буух зурвасын алсын барааны харагдац (RVR) нь нэг, эсхүл хэд хэдэн босго утгыг давж өөрчлөгдөж байгааг шууд мэдээлж байвал

Орон нутгийн тусгай мэдээг нисэх буудалд үйл ажиллагаа явуулж буй операторууд болон бусад хэрэглэгчдэд мэдээлнэ.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХҮЛБАР ҮНЭН
Архив
(албан тушаалын нэр)
Чанцал
(гарын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид Тоонын
Дэлгэрэнгүй 26 А/17

Бүлэг 5. Агаарын хөлгөөс хийсэн цаг уурын ажиглалтын мэдээ

Тайлбар. Энэ бүлэгт холбоотой журам стандартыг PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 3-д хамтад нь тусгасан.

5.1 Улсын үүрэг (Obligations of States)

Тухайн улсад бүртгэлтэй, агаарын замд нислэг үйлдэж буй агаарын хөлгөөс ажиглалт хийх, эдгээр ажиглалтыг нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага хүлээн авч, бүртгэх, дамжуулах ажлыг зохион байгуулна.

5.2 Агаарын хөлгөөс хийсэн ажиглалтын төрөл (Types of aircraft observations)

Агаарын хөлгөөс дараах ажиглалтуудыг хийнэ. Үүнд:

a) нислэгийн замд болон өндөр авалтын үед агаарын хөлгөөс хийх байнгын ажиглалт;
b) нислэгийн үед агаарын хөлгөөс хийх тусгай болон байнгын бус ажиглалтууд.

5.3 Агаарын хөлгөөс хийсэн байнгын ажиглалт (Routine aircraft observations)

Агаарын хөлгөөс хийсэн байнгын ажиглалтын мэдээг нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын хүсэлтээр НХҮ-ний албатай харилцан тохиролцсоны дагуу хүлээн авна.

5.3.1-5.3.4 Энэ заалт хамааралгүй тул орхилт хийгдсэн.

5.4 Агаарын хөлгөөс хийх байнгын ажиглалтаас чөлөөлөх (Routine aircraft observations - exemptions)

Агаар газрын өгөгдлийн холбоогоор тоноглогдоогүй агаарын хөлөг нь агаарын хөлгөөс хийсэн байнгын ажиглалтаас чөлөөлөгдөнө.

5.5 Агаарын хөлгөөс хийсэн тусгай ажиглалт (Special aircraft observations)

Агаарын хөлөгт дараах нөхцөл байдал тохиолдох, эсхүл ажиглагдсан үед тусгай ажиглалтуудыг хийнэ. Үүнд:

a) дунд хүчтэй, эсхүл хүчтэй сэгсрэлт;
b) дунд хүчтэй, эсхүл хүчтэй мөстөлт;
c) уулын хүчтэй долгион;
d) мөндрийн голомтгүй халхлагдсан, далдлагдсан, эсхүл нөөлөг салхины шугам дах дуу цахилгаан;
e) мөндрийн голомттой халхлагдсан, далдлагдсан, эсхүл нөөлөг салхины шугам дах дуу цахилгаан;
f) хүчтэй шороон, эсхүл элсэн шуурга;
g) галт уулын үнсэн үүл;
h) галт уулын дэлбэрэлтийн өмнөх идэвхжил, эсхүл галт уулын дэлбэрэлт;

Тайлбар. Галт уулын идэвхжилийн үе гэдэг нь хэвийн бус байдал илрэх болон, эсхүл нэмэгдэж буй галт уул идэвхжилийг хэлнэ.

i) Хөөрч буух зурвасын үрэлтийн байдлыг мэдээлэхгүй.

ОЛЬ ОРШИЛТЫН ЯАМ
ОФИЦИАЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архив
(гүшаалын нэр)
Чанцал
(арын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 А/17

5.6 Агаарын хөлгөөс хийсэн бусад байнгын бус ажиглалт (Other non-routine aircraft observations and reports)

Тайлбар. Энэ хэсэгт хамаарах журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 3.2-т тусгасан.

Энэ зүйлийн 5.5-д тусгагдаагүй бусад цаг агаарын нөхцөл байдал (тухайлбал: салхины шилжлэг) тохиолдох мөн агаарын хөлгийн даргын үзэж байгаагаар бусад агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй ажиллагаанд, эсхүл үр ашигт байдалд нөлөөлнө гэж үзсэн тохиолдолд нэн даруй холбогдох НХҮ-ний нэгжид мэдээлнэ.

5.7 Нислэгийн үед агаарын хөлгөөс хийсэн ажиглалтыг мэдээлэх (Reporting of aircraft observations)

Тайлбар. Энэ хэсэгт хамаарах журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 3.2-т тусгасан.

5.7.1 Нислэгийн үед агаарын хөлгөөс хийсэн ажиглалтуудыг агаар-газрын өгөгдлийн холбоогоор мэдээлнэ. Агаар-газрын өгөгдлийн холбоо боломжгүй тохиолдолд агаарын хөлгөөс хийсэн тусгай болон бусад байнгын бус ажиглалтуудыг дуут холбоогоор мэдээлнэ.

5.7.2 Нислэгийн үед агаарын хөлгөөс хийсэн ажиглалтыг даруй мэдээлнэ.

5.7.3 Агаарын хөлгөөс хийсэн ажиглалтыг тус тусад нь байнгын болон тусгай ажиглалтын мэдээ хэлбэрээр мэдээлнэ. Агаар газар хоорондын өгөгдлийн холбоогоор дамжуулах байнгын болон тусгай мэдээнд, хамгийн багадаа дараах цаг уурын мэдээлэл багтсан байна. Үүнд:

a) салхины чиглэл;
b) салхины хурд;
c) агаарын температур;
d) мэдээ гаргах нөхцөл (зөвхөн агаарын хөлгөөс хийсэн тусгай ажиглалтын мэдээнд хамаарна).

5.8 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжээс агаарын хөлгийн мэдээг дамжуулах (Relay of air-reports by air traffic services units)

5.8.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага, НХҮБ хооронд байгуулсан гэрээний дагуу дараах байдлаар дамжуулна. Үүнд:

a) дуут холбоогоор мэдээлсэн агаарын хөлгөөс хийсэн тусгай мэдээг НХҮ-ний нэгжүүд нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагад даруй мэдээлнэ;
b) НХҮ-ний нэгжүүд байнгын болон тусгай мэдээг өгөгдлийн холбоогоор дамжуулан нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага, WAFC's болон нисэхийн суурин үйлчилгээний интернэтэд суурилсан үйлчилгээ эрхлэх бүсийн агаарын навигацийн гэрээгээр томилогдсон төвүүдэд даруй мэдээлнэ.

5.8.2 **Зөвлөмж** – *Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон нислэг хөдлөөний байгууллагатай дараах зохицуулалтыг хийнэ. Үүнд:*

a) *тусгай ажиглалтын мэдээг 60 минутын турш мэдээлнэ.*

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨВЧЛӨЛТИЙН ЯАМ
Архив
(Өөрчлөлтийн тайлал)
26 01 дугаар сарын 29
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 А/17

b) *бусад агаарын хөлгөөс хийсэн тусгай ажиглалтын мэдээг автоматаар дамжуулахдаа салхи болон агаарын температурын мэдээг дамжуулахгүй.*

5.9 Агаарын хөлгөөс хийсэн ажиглалтын мэдээг түгээх (Dissemination of air-reports)

5.9.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага дуут холбоогоор хүлээн авсан тусгай ажиглалтын мэдээг нэн даруй Дэлхийн Цаг Агаарын Урьдчилсан Мэдээний Төв (WAFCs) болон томилогдсон төвүүдэд интернэтэд суурилсан нисэхийн суурин үйлчилгээгээр гэрээний дагуу дамжуулна.

5.9.2 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага галт уулын дэлбэрэлтийн өмнөх галт уулын идэвхжил, галт уулын дэлбэрэлт, галт уулын үнсэн үүлний тухай хүлээж авсан агаарын хөлгөөс хийсэн тусгай ажиглалтын мэдээг галт уулын үнснээс сэрэмжлүүлэх төвүүдэд нэн даруй дамжуулна.

5.9.3 Агаарын хөлгөөс хийсэн тусгай ажиглалтын мэдээг нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага хүлээн авсан боловч урьдчилан мэдээлэхийн инженер тухайн үзэгдлийг үргэлжлэхгүй гэж тооцвол SIGMET мэдээ гаргах шаардлагагүй боловч агаарын хөлгөөс хийсэн тусгай ажиглалтын мэдээг SIGMET мэдээний нэгэн адил бусад цаг уурын байгууллага, WAFS төвүүдэд гэрээний дагуу дамжуулна.

Тайлбар. Нисэж буй агаарын хөлөгт дамжуулах тусгай ажиглалтын мэдээний загварыг PANS-MET (Doc 10157)-ийн Appendix 3, Table A3-2-д тусгасан.

5.9.4 WAFC-д хүлээн авсан агаарын хөлгөөс хийсэн ажиглалтын мэдээг цаг уурын үндсэн мэдээлэл болгон цааш түгээнэ.

Тайлбар. Цаг уурын үндсэн мэдээллийг түгээх үйл ажиллагаа нь Дэлхийн Цаг Уурын Байгууллага (WMO)-ын Дэлхийн Харилцаа Холбооны Систем (GTS)-ээр дамжин явагддаг.

5.9.5 **Зөвлөмж** – *Агаарын навигаци болон цаг уурын тусгай шаардлагын хүрээнд цаг уурын байгууллагын хоорондын гэрээгээр харилцан тохиролцсоны дагуу нэмэлтээр түгээнэ.*

5.9.6 Агаарын хөлгөөс хийсэн ажиглалтын мэдээг хүлээн авсан форматын дагуу солилцоно.

ОНЦГОЙ ОНЦ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(албан тушаалын нэр)
(гарын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 23

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
Дагалын 26 А/17

Бүлэг 6. Аэродромын болон чиглэлийн цаг агаарын урьдчилсан мэдээ

Тайлбар. Энэ бүлэгт холбоотой журам стандартыг PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 4, 5-д тусгасан.

6.1 Урьдчилсан мэдээний ашиглалт (Use of forecasts)

Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагаас шинэчлэн гаргасан урьдчилсан мэдээ (тухайлбал: аэродромын байнгын урьдчилсан мэдээ) нь өмнө гаргасан ижил байршил, ижил хугацааны ижил төрлийн урьдчилсан мэдээг автоматаар хүчингүй болгоно.

6.2 Аэродромын цаг агаарын урьдчилсан мэдээ (Aerodrome meteorological forecast information)

6.2.1 Аэродромын урьдчилсан мэдээ (TAF)

Тайлбар. Энэ хэсэгтэй холбоотой журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 4.1-д тусгасан.

6.2.1.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 4, 5, Appendix 4, 7-ын дагуу урьдчилсан мэдээ боловсруулж, нийлүүлнэ.

Тайлбар. Аэродромын урьдчилсан мэдээг гаргах аэродромуудын талаарх мэдээлэл болон эдгээр урьдчилсан мэдээний хүчинтэй байх хугацааг Бүс нутгийн цахим агаарын навигацийн төлөвлөгөө (eANP), Volume II)-д тусгасан болно.

6.2.1.2 Аэродромын урьдчилсан мэдээг үйлчлэх хугацаанаас 1 цагаас ихгүй хугацааны өмнө зохиох ба аэродром дээр тодорхой хугацаанд үүсэж бий болох цаг агаарын нөхцөлүүдийн тухай товч бөгөөд тодорхой мэдээллийг агуулна.

6.2.1.3 Аэродромын урьдчилсан мэдээ, түүнд оруулсан залруулгыг TAF хэлбэртэй бичих бөгөөд дараах цаг агаарын элементүүдийг тусгана. Үүнд:

a) газар орчмын салхи;
b) АБХ;
c) цаг агаарын үзэгдэл;
d) үүлшил;
e) урьдчилсан мэдээний үйлчлэх хугацаанд нэг, эсхүл хэд хэдэн элементүүдийн онцгой өөрчлөлтүүд.

Гэрээний дагуу TAF-д оруулах нэмэлт элементүүдийг тусгаж болно.

Тайлбар 1. Аэродромын урьдчилсан мэдээний техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 4, 4.1.1.1 and 4.1.1.2-д тусгасан.

Тайлбар 2. TAF-д мэдээлсэн АБХ-ыг урьдчилан мэдээлж байгаа давамгайлсан АБХ гэж үзнэ.

6.2.1.4 TAF бэлтгэдэг нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь урьдчилсан мэдээгээ тасралтгүй шинэчлэн, шаардлагатай үед нэн даруй нарийвчилна. Урьдчилсан мэдээний урт болон доторх өөрчлөлтийн тоог аль болох бага байлгах хэрэгтэй.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМНЫ ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дүгээр сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУУЛ
Сайд
26 А/17

Тайлбар. TAF-ыг нарийвчлах арга зүй, зааврыг Manual of Aeronautical Meteorological Practice (Doc 8896)-ийн Chapter 3-д тусгасан.

6.2.1.5 Цаашид үргэлжлүүлэх боломжгүй TAF-ийг цуцална.

6.2.1.6 *Олон улсын нислэгт үйлчлэх урт хугацааны TAF (30 цаг), орон нутгийн нислэгт үйлчлэх богино хугацааны TAF (9 цаг) мэдээг зохиохдоо тухайн хугацаанд, тухайн аэродромд зориулж нэг л TAF мэдээгээр үйлчлэх зарчмыг баримтална.

6.2.1.7 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь тухайн аэродромд нэгээс илүүгүй хүчинтэй TAF гаргана.

6.2.1.8 TAF болон нарийвчилсан мэдээг Олон улсын OPMET өгөгдлийн сан болон бүсийн төвүүдэд интернэтэд суурилсан нисэхийн суурин үйлчилгээний системээр дамжуулна.

6.2.1.9 *Өөрчлөлтийн бүлэг, эсхүл TAF мэдээнд залруулга хийх шалгуур (Criteria for the indication of changes and/or preparation of amendments to TAF)

Цаг уурын элемент	Өөрчлөлтийн бүлэг, эсхүл TAF мэдээнд залруулга хийх шалгуур	Тайлбар
Газар орчмын салхи	салхины дундаж хурд 5м/с (10кт) ба түүнээс дээш үед урьдчилсан мэдээлсэн газар орчмын салхины дундаж чиглэл 60° ба түүнээс ихээр өөрчлөгдөх; газар орчмын салхины дундаж хурд 5м/с (10кт) ба түүнээс ихээр өөрчлөгдөх; газар орчмын салхины дундаж хурд 7.5м/с (15кт) ба түүнээс дээш байх үед урьдчилан мэдээлсэн газар орчмын салхины дундаж хурдны хазайлт (өөвхийлөлт) 5м/с (10кт) ба түүнээс ихээр өөрчлөгдөх; газар орчмын салхины урьдчилан мэдээлсэн өөрчлөлт нь үйл ажиллагааны ашиглалтын босго утгад өөрчлөлт орсон: • ХБЗ-т өөрчлөлт орсон бол; • ашиглагдаж байгаа аэродром дээр тухайн агаарын хөлгийн ашигладаг хязгаараас ХБЗ-ын арын салхи/ хөндлөнгийн салхи давсан бол.	Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь агаарын тээврийн байгууллагууд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (ATS)-ний байгууллага харилцан зөвшилцөж тогтоосон босго утгыг үндэслэнэ.
АБХ	АБХ дараах утгуудын нэг, эсхүл хэд хэдэн утгад хүрч өөрчлөгдөх, эсхүл давж сайжрах; АБХ дараах утгуудын нэг, эсхүл хэд хэдэн утгад хүрч өөрчлөгдөх, эсхүл давж муудах: • 150, 350, 600, 800, 1500, эсхүл 3000м.	VFR ил харааны нислэгтэй аэродромуудад АБХ 5000м-т шалгуурт орно.
Цаг агаарын үзэгдэл	дараах цаг агаарын үзэгдэл, эсхүл эдгээр хавсарсан үзэгдлүүдийн аль нэг нь эхлэх, дуусах, эсхүл эрчимжил нь өөрчлөгдөх: • хэт хөрсөн манан • зайрмагтсан хур тунадас • дунд хүчтэй, эсхүл хүчтэй хур тунадас (аадрыг оруулаад) • шөрөөн шуурга • элсэн шуурга	

ҮНДЭСНИЙ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Суртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архив
(албан тушаалын нэр)
Гарын үсэг
(гарын үсгийн тайлбар)
26 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид Төрийн албаны
Дугаар 26 А/17

	• дуу цахилгаан дараах цаг агаарын үзэгдлүүд эхлэх, эсхүл зогсох: • шороон, элсэн, эсхүл цасан явган шуурга; • намын элсэн, шороон болон цасан шуурга; • нөөлөг салхи; юүлүүр хэлбэрийн үүл (Торнадо, эсхүл усан догшин хүй)	
Үүлшил	BKN, эсхүл OVC хэмжээтэй үүлний масс, эсхүл хамгийн доод давхаргын үүлний суурийн өндөр нь дараах утгуудын нэг, эсхүл хэд хэдэн утгад хүрч дээшлэх, давах, эсхүл; BKN, эсхүл OVC хэмжээтэй үүлний масс, эсхүл хамгийн доод давхаргын үүлний суурийн өндөр нь дараах утгуудын нэг, эсхүл хэд хэдэн утгад хүрч доошлох, давах: • 30, 60, 150, эсхүл 300м (100, 200, 500, эсхүл 1000 ft) 450м (1500 фт)-ээс нам өндөртэй үүлний масс, эсхүл давхаргын хэмжээ дараах байдлаар өөрчлөгдөх: • NSC, FEW, эсхүл SCT -ээс BKN, эсхүл OVC болох; • BKN, эсхүл OVC -ээс NSC, FEW, эсхүл SCT болох.	
Босоо чиглэлийн АБХ	босоо чиглэлийн АБХ дараах утгуудын нэг, эсхүл хэд хэдэн утгад хүрч сайжрах, давах, эсхүл; босоо чиглэлийн АБХ дараах утгуудын нэг, эсхүл хэд хэдэн утгад хүрч муудах, эсхүл давах: • 30, 60, 150 эсхүл 300м (100, 200, 500, эсхүл 1000 ft)	
Температур	Байхгүй	
Бусад	бусад шалгуурууд тухайн аэродромын үйл ажиллагааны минимумд тулгуурлана.	Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон холбогдох агаарын тээвэрлэгчид тохиролцсоны дагуу SPECI гаргах шалгууртай ижил төстэй байхаар авч үзнэ.

Тайлбар. ICAO-ын баримт бичиг Doc 8896-ын дагуу өөрчлөлтийн бүлэг, эсхүл TAF мэдээнд залруулга хийх шалгуурт нийцүүлэн мэдээлнэ.

6.2.2 Суултын (хандлагын) урьдчилсан мэдээ (Landing forecasts (trend forecasts))

Тайлбар. Энэ хэсэгтэй холбоотой журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 4-д тусгасан.

6.2.2.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь суултын урьдчилсан мэдээг PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 4-ийн дагуу боловсруулах бөгөөд энэ мэдээг тухайн газрын хэрэглэгчид болон тухайн аэродромоос ойролцоогоор 1 цагийн зайд нислэг үйлдэж буй агаарын хөлөгт зориулан гаргана.

6.2.2.2 Суултын урьдчилсан мэдээг хандлагын урьдчилсан мэдээний хэлбэрээр бэлтгэнэ.

...ЬЖ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
...ЛТГЭЛИЙН ДЭВ...
...ГЭЭР ТЭМДЭГЛЭВ
Архив2
...ШАВЛЫН НЭР)
Чанцал
...ЫН ҮСГИЙН ТАЙЛАЛ)
...ЛГААР САРЫН 29
26 01

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид ...
26 А/17

6.2.2.3 Хандлагын урьдчилсан мэдээ нь тухайн аэродром дээрх цаг уурын эрс өөрчлөлтийн тухай товч мэдээллийг агуулах ба тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д орно. Хандлагын урьдчилсан мэдээний үйлчлэх хугацаа нь мэдээ гаргасан хугацаанаас хойш 2 цаг байх ба энэ нь суултын урьдчилсан мэдээ болно.

Тайлбар. хандлагын урьдчилсан мэдээтэй холбоотой техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 4, 4.2.1.1, 4.2.1.2-т тусгасан.

6.2.2.4 Хандлагын урьдчилсан мэдээнд ашигласан хэмжих нэгж нь үндсэн мэдээнд хэрэглэсэн нэгжтэй ижил байна.

6.2.3 Хөөрөлтийн урьдчилсан мэдээ (Forecasts for take-off)

Тайлбар. Энэ хэсэгтэй холбоотой журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 4.3-т тусгасан.

6.2.3.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь PANS-MET (Doc 10157)-ийн Section 4.3-ын дагуу хөөрөлтийн урьдчилсан мэдээг боловсруулж, нийлүүлнэ.

6.2.3.2 **Зөвлөмж** – *Хөөрөлтийн урьдчилсан мэдээ нь хөөрөх, буух зурвас дээр тодорхой хугацааны турш бий болох мэдээллийг агуулах ба газар орчмын салхины чиглэл, хурд, түүний өөрчлөлт, температур, даралт (QNH) болон бусад элементүүдийг өгнө.*

6.2.3.3 **Зөвлөмж** – *Хөөрөлтийн урьдчилсан мэдээг TAF мэдээг гаргах хугацаатай давхцуулж, 3 цагийн үйлчлэх хугацаатайгаар боловсруулж агаарын тээвэрлэгчид болон нисэх багийн гишүүдэд дамжуулна.*

6.2.3.4 **Зөвлөмж** – *Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь хөөрөлтийн урьдчилсан мэдээнд байнга хяналт тавих бөгөөд шаардлагатай үед даруй залруулга хийнэ.*

6.3 Чиглэлийн цаг агаарын урьдчилсан мэдээ (En-route meteorological forecast information)

6.3.1 Дэлхийн бүсийн урьдчилсан мэдээний төвүүдийн урьдчилсан мэдээ (Forecasts by world area forecast centres)

Тайлбар. Энэ хэсэгтэй холбоотой журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 5.1-д тусгасан.

6.3.1.1 Өндрийн агаарын торлосон цэгэн болон цаг агаарын аюултай үзэгдлийн урьдчилсан мэдээг Дэлхийн бүсийн урьдчилсан мэдээний төвүүд (WAFCs) нь нэгдсэн формат, кодоор гаргана.

6.3.2 Нам өндрийн нислэгт зориулсан районы урьдчилсан мэдээ (GAMET area forecasts for low level)

Тайлбар. Энэ хэсэгтэй холбоотой журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 5.2-т тусгасан.

6.3.2.1 Нислэгийн хөдөлгөөний үйл ажиллагаа нислэгийн түвшин FL100-аас доош түвшинд нислэгийн нягтаршилтай үед (эсхүл уулархаг

бүсэд нислэгийн түвшин FL150 хүртэл, эсхүл зайлшгүй тохиолдолд түүнээс өндөр үед) тухайн районы урьдчилсан мэдээ (GAMET)-ний давтамж, урьдчилсан мэдээний хүчинтэй хугацааг 6.3.2.3-т заасны дагуу бэлтгэж, түгээнэ.

6.3.2.2 Нислэгийн түвшин FL100-аас доош түвшний хөдөлгөөний нягтрал нь 7.5.1.1-д заасны дагуу AIRMET-ийн мэдээлэл шаардагдах тохиолдолд Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагатай харилцан тохиролцож районы урьдчилсан мэдээг бэлтгэнэ. Товчилсон энгийн хэллэг ашиглах үед урьдчилсан мэдээг районы урьдчилсан мэдээ (GAMET) болгон бэлтгэнэ.

6.3.2.3 Нам өндрийн нислэгт зориулсан районы урьдчилсан мэдээг (AIRMET мэдээ гаргахад дэмжлэг болгох зорилгоор) 3 цаг тутамд 3 цагийн хүчинтэй хугацаатай гаргаж, хүчинтэй хугацаа эхлэхээс дор хаяж 1 цагийн өмнө нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага гаргана.

6.3.2.4 Нам өндрийн нислэгт зориулсан районы урьдчилсан мэдээг холбогдох нислэгийн мэдээллийн бүсэд цаг уурын байгууллагууд хоорондоо харилцан солилцоно.

6.3.2.5 **Зөвлөмж** – *Нам өндрийн нислэгт зориулсан районы урьдчилсан мэдээг хэрэглэгчдэд түгээнэ.*

6.3.2.6 *ICAO-ын баримт бичиг Doc 9377-ын 3.5.9-д заасны дагуу нам өндрийн нислэгт зориулсан чиглэлийн дагуух цаг агаарын онцгой нөхцөл байдал, аюултай үзэгдлийн талаар товчилсон энгийн хэллэг хэлбэрээр районы урьдчилсан мэдээг гаргана.

6.3.2.7 *Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь хариуцаж буй аэродромоос 50 км-ийн радиус доторх нам өндрийн нислэгт зориулж районы урьдчилсан мэдээг гаргах бөгөөд байнгын хяналт тавьж, шаардлагатай үед цаг алдалгүйгээр залруулга хийнэ.

6.3.2.8 *Нам өндрийн нислэгт зориулсан районы урьдчилсан мэдээг 3 цагийн үйлчлэх хугацаатайгаар, нислэг эхлэхээс дуусах хугацаанд 3 цаг тутамд TAF мэдээг гаргах хугацаатай давхцуулж гаргаж, үйлчилж эхлэх хугацаанаас 1 цагаас багагүй хугацааны өмнө хэрэглэгчдэд дамжуулна. Районы урьдчилсан мэдээг дэлгэрэнгүй бичвэр хэлбэрээр бэлтгэнэ.

6.3.2.9 Районы урьдчилсан мэдээ нь тодорхой хугацааны турш бий болох мэдээллийг агуулах ба үүнд өндрийн болон газар орчмын салхины чиглэл, хурд түүний өөрчлөлт, АБХ, үзэгдэл, үүлшил, уулсын харагдцын мэдээг өгнө.

6.3.3 Галт уулын үнсний зөвлөмжийн төвүүдийн урьдчилсан мэдээ (Forecasts by volcanic ash advisory centres)

Тайлбар. Энэ хэсэгтэй холбоотой журам, техникийн шаардлагыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 5.3-т тусгасан болно.

ГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
(хуудасны дугаар 683)
ГУЛБАР ҮНЭН
Архивч
(эзэн тушаалын нэр)
(гарын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид Тариан
26 А/17

Бүлэг 7. Зөвлөмж, сэрэмжлүүлэг, мэдэгдэл агуулсан цаг уурын мэдээлэл

Тайлбар. Энэ бүлэгт холбоотой журам стандартыг PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 6-д тусгасан.

7.1 Галт уулын үнсний зөвлөмжийн мэдээлэл болон улсын галт уулын ажиглалтын төвүүдээс ирүүлсэн мэдээлэл (Volcanic ash advisory information and information from State volcano observatories)

Тайлбар. Энэ хэсэгт холбоотой журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 6.1-д тусгасан.

7.1.1 Галт уулын үнсний зөвлөмжийн мэдээллийг галт уулын үнсний зөвлөмжийн төв гаргана.

7.1.2 Энэ заалт хамааралгүй тул орхилт хийгдсэн.

7.2 Тропикийн циклоны зөвлөмжийн мэдээлэл (Tropical cyclone advisory information)

Тайлбар. Энэ хэсэгт холбоотой журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 6.2-д тусгасан.

7.2.1 Тропикийн циклоны зөвлөмжийн мэдээллийг тропикийн циклоны зөвлөмжийн төвөөс албан ёсоор гаргана.

7.3 Сансрын цаг агаарын зөвлөмжийн мэдээлэл (Space weather advisory information)

Тайлбар. Энэ хэсэгт холбоотой журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET(Doc 10157)-ийн Section 6.3-д тусгасан.

7.3.1 Сансрын цаг агаарын зөвлөмжийн мэдээллийг дэлхийн сансрын цаг агаарын төв (SWXC) албан ёсоор гаргана.

7.4 SIGMET мэдээлэл (SIGMET information)

Тайлбар. Энэ хэсэгт холбоотой журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET(Doc 10157)-ийн Section 6.4-д тусгасан.

7.4.1 Ерөнхий заалтууд (General provisions)

7.4.1.1 SIGMET мэдээллийг нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагаас PANS-MET (Doc 10157)-ийн Section 6.4-ийн дагуу боловсруулах бөгөөд уг мэдээлэлд агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөх тодорхой нислэгийн замын дагуу агаар мандал дахь цаг агаарын болон бусад үзэгдлийн бодит, эсхүл ирээдүйн төлөв байдлын тухай болон уг үзэгдлийн цаг хугацаа, орон зайн өөрчлөлтийн тухай бичсэн товч мэдээллийг өгнө. SIGMET мэдээлэлд дараах үзэгдлүүдийн аль нэгийг заавал тусгана.

1) Дуу цахилгаан
2) Тропикийн циклон
3) Турбулент

ӨӨРЧЛӨЛТИЙН ...
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архив 2
...баан тушаалын нэр)
...
...эг)(гарын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 29
МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУЛЬ
26 А/17

4) Мөстөлт
5) Уулын долгион
6) Шороон шуурга
7) Элсэн шуурга
8) Галт уулын үнс
9) Цацраг идэвхт үүл

7.4.1.2 Тухайн бүсэд үзэгдэл ажиглагдахгүй болох, эсхүл цаашид ажиглагдахгүй гэж үзэж байгаа тохиолдолд SIGMET мэдээллийг цуцална.

7.4.1.3 SIGMET мэдээний үйлчлэх хугацаа 4 цагаас ихгүй байна.

7.4.1.4 Энэ заалт хамааралгүй тул орхилт хийгдсэн.

7.4.1.5 Галт уулын үнсний мэдээлэл агуулсан SIGMET болон NOTAM мэдээнд Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон холбогдох ACC, FIC хоорондоо уялдаатай ажиллана.

7.4.1.6 SIGMET мэдээг үйлчилж эхлэх хугацаанаас 4-с илүүгүй цагийн өмнө гаргана.

7.4.1.7 **Зөвлөмж** – *Агаарын зайг нислэгийн мэдээллийн бүс (FIR) болон дээд агаарын зайн нислэгийн мэдээллийн бүс (UIR) гэж хуваагдсан тохиолдолд SIGMET нь FIR-ын байршил заагчаар тодорхойлогдоно.*

Тайлбар. SIGMET мэдээлэл нь Нислэгийн Мэдээллийн Бүсийн (FIR) хажуугийн хязгаарт багтах бүх агаарын зайд хамаарна. Өөрөөр хэлбэл, энэ нь FIR болон UIR (дээд нислэгийн мэдээллийн бүс)-д мөн хүчинтэй. Цаг агаарын үзэгдлээс шалтгаалан SIGMET гаргахад нөлөөлсөн бүс нутаг болон/эсвэл нислэгийн түвшнийг SIGMET мэдээлэлд тусгасан байдаг.

7.4.2 SIGMET мэдээллийн түгээлт (Dissemination of SIGMET information)

7.4.2.1 SIGMET мэдээллийг Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага, Дэлхийн бүсийн урьдчилсан мэдээний төв (WAFC) болон хэрэглэгч, бусад цаг уурын албадад дамжуулна.

7.4.2.2 SIGMET мэдээг нисэхийн суурин холбооны интернэтэд суурилсан үйлчилгээний үйл ажиллагааны хүрээнд Олон улсын OPMET өгөгдлийн сангууд болон бүсийн агаарын навигацийн гэрээгээр томилогдсон төвүүдэд дамжуулна.

7.5 AIRMET мэдээлэл (AIRMET information)

Тайлбар. Энэ хэсэгт холбоотой журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET(Doc 10157)-ийн Section 6.5-д тусгасан.

7.5.1 Ерөнхий заалтууд (General provisions)

7.5.1.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь PANS-MET (Doc 10157)-ийн Section 6.5-ын дагуу боловсруулах бөгөөд тухайн бүсийн нислэгийн түвшин FL100 (шаардлагатай бол түүнээс дээш эсвэл уулархаг

бүсэд FL150-аас доош)-с доош нам өндрийн нислэгт зориулсан AIRMET мэдээллийг гаргана. AIRMET мэдээлэлд Бүлэг 6-ийн 6.3.2-д заасан нам өндрийн нислэгт зориулсан районы урьдчилсан мэдээнд тусгагдаагүй, нам өндрийн нислэгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөх тодорхой нислэгийн чиглэл дэх цаг агаарын үзэгдлийн бодит, эсхүл ирээдүйн төлөв байдал, үзэгдлийн цаг хугацаа, орон зайн өөрчлөлтийн мэдээллийг өгнө. AIRMET мэдээлэлд дараах үзэгдлүүдийн аль нэгийг заавал оруулна

1) Газар орчмын салхины хурд
2) Газрын гадаргын алсын бараа
3) Дуу цахилгаан
4) Уулсын халхлагдалт
5) Үүл
6) Мөстөлт
7) Сэгсрэлт
8) Уулын долгион

Тайлбар. AIRMET мэдээний техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 6, 6.5.1-д тусгасан.

7.5.1.2 Тухайн бүсэд үзэгдэл ажиглагдахгүй болох, эсхүл цаашид ажиглагдахгүй гэж үзэж байгаа тохиолдолд AIRMET мэдээллийг цуцална.

7.5.1.3 AIRMET мэдээний үйлчлэх хугацаа 4 цагаас хэтрэхгүй байна.

7.5.2 AIRMET мэдээллийн түгээлт (Dissemination of AIRMET information)

7.5.2.1 **Зөвлөмж** – *Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага AIRMET мэдээллийг бусад цаг уурын байгууллага болон хэрэглэгчдэд дамжуулна.*

7.5.2.2 Энэ заалт хамааралгүй тул орхилт хийгдсэн.

7.6 Аэродромын сэрэмжлүүлэг (Aerodrome warnings)

7.6.1 Ерөнхий заалтууд (General provisions)

7.6.1.1 Аэродромын сэрэмжлүүлгийг нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь PANS-MET (Doc 10157)-ийн Appendix 7-ын дагуу боловсруулах бөгөөд уг мэдээнд зогсоолд байгаа агаарын хөлөг болон аэродромын байгууламж, тоног төхөөрөмж болон түүний үйлчилгээнд сөргөөр нөлөөлж болзошгүй цаг агаарын нөхцөлүүдийн талаарх товч мэдээллийг өгнө.

Тайлбар. Аэродромын сэрэмжлүүлэг мэдээний загварыг PANS-MET (Doc 10157)-ийн Appendix 7-ынTable A7-6-д тусгасан.

7.6.1.2 **Зөвлөмж** – *Аэродромын сэрэмжлүүлгийг дараах нэг, эсхүл хэд хэдэн цаг агаарын үзэгдлүүд ажиглагдсан, эсхүл ажиглагдах нөхцөл бүрдсэн үед мэдээлнэ.*

- салхины хурд 17м/с (34kt) хүрэхээр бол, эсхүл түүнээс их үед);
- дуу цахилгаан
- мөндөр;

ӨЗРЧЛӨЛТИЙН ЯАМ
УУЛЗАР ҮНЭН
Архивч
Чанцан
МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ

- цас (цас нэмэгдэж орсон, эсхүл орох нөхцөл бүрдсэн бол үүнийг оруулаад)
- зайрмагтсан хур тунадас
- хяруу
- хяруу, эсхүл цан
- элсэн шуурга
- шороон шуурга
- ихсэж буй элс болон шороо
- газар орчмын хүчтэй салхи болон өрөвхийлөлт
- нөөлөг салхи
- химийн хорт бодис
- тухайн газрын гэрээний дагуу бусад үзэгдлүүд.

7.6.1.3 **Зөвлөмж** – *Аэродромын сэрэмжлүүлгийг аэродром дээр үзэгдэл ажиглагдахгүй болох, эсхүл цаашид ажиглагдахгүй гэж үзэж байгаа тохиолдолд цуцална.*

7.6.2 Аэродромын сэрэмжлүүлэг мэдээний түгээлт (Dissemination of aerodrome warnings)

Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь Аэродромын сэрэмжлүүлгийг бусад цаг уурын байгууллага болон хэрэглэгчдэд түгээнэ.

7.7 Салхины шилжлэгийн сэрэмжлүүлэг (Wind shear warnings)

Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь PANS-MET (Doc 10157)-ийн Section 6.7-д тусгасны дагуу салхины шилжлэгийн сэрэмжлүүлгийг гаргана.

7.7.1 Ерөнхий заалтууд (General provisions)

Тайлбар. Салхины шилжлэгийн сэрэмжлүүлэг нь салхины шилжлэгийн нөхцөл байдлыг тодорхой болгох зорилготой юм.

7.7.1.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь НХҮ-ний байгууллага болон агаарын тээвэрлэгчтэй хамтран салхины шилжлэг (wind shear)-ийг аюулгүй байдлын хүчин зүйл гэж үзэх эсэхийг тодорхойлох үнэлгээг хийж, нөхцөл бүрдсэн үед салхины шилжлэгийн сэрэмжлүүлгийг PANS-MET (Doc 10157)-ийн Section 6.7-ын дагуу гаргах бөгөөд агаарын тээвэрлэгч болгон НХҮ-ний байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага, заавартай байна.

Тайлбар. Салхины шилжлэгийн сэрэмжлүүлэг мэдээний загварыг PANS-MET (Doc 10157)-ийн Appendix 7-ын Table A7-7-д тусгасан

7.7.1.2 **Зөвлөмж** – *Нисэн гарч буй болон нисэн ирж буй агаарын хөлөгт зориулсан салхины шилжлэгийн сэрэмжлүүлгийг тухайн мэдээний өгөгдсөн хугацаанд салхины шилжлэг илрээгүй гэсэн мэдээлэл агаарын хөлгөөс ирсэн тохиолдолд цуцална.*

7.7.1.3 Салхины шилжлэг илрүүлэх тоног төхөөрөмжгүй аэродромд цаг агаарын нөхцөл, физик газарзүйн онцлог, уул зүйн нөлөөлөл, фронтын шилжилт, хувьсал зэрэгт дүн шинжилгээ хийж нисэх баг, агаарын тээврийн байгууллагууд, НХҮ-ний нэгжүүдэд сэрэмжлүүлэг, зөвлөмж, зөвлөгөө өгнө. Цаг уурын радарт борооны бөөн (СВ) үүлтэй холбоотойгоор илэрсэн тохиолдолд, мөн нисэх баг, НХҮ-ний нэгжээс

ОРЧИН ҮЕИЙН ХЯНАЛТ ЗӨВЧЛӨЛТИЙН ЗАМ 607 ЗАРТНЭН Архивлалын нэр) Чанар (үсгийн тайлал) 26 01 хуудасны тоо 29
МОНГОЛ УЛСЫН ЭХ ХУВЬ 26 А/17

ирүүлсэн салхины шилжлэгийн мэдээллийг хүлээн авч, нэн даруй дараагийн нислэгт сэрэмжлүүлэг, зөвлөмж, зөвлөгөө өгнө.

7.7.2 Салхины шилжлэгийн сэрэмжлүүлэг мэдээний түгээлт (Dissemination of wind shear warnings)

7.7.2.1 Салхины шилжлэгийн сэрэмжлүүлгийг Annex-3, PANS-MET (Doc 10157), болон Manual on Low-level Wind Shear (Doc 9817)-ийн дагуу түгээнэ.

7.7.2.2. Энэ заалт хамааралгүй тул орхилт хийгдсэн.

ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ЗЫРЧЛОЛТИЙН ЯАМ
...ийн дугаар 607
...Р ҮНЭН
Архивч
...лын нэр)
Чанцал
...үсгийн тайлал)
26 01 ...эр сарын 09

МОНГОЛ УЛСЫ
ЗАМ, ТЭЭВРИЙН Я
ЭХ ХУВ
Сайд Тэрбиш ...
...дэлбэ ...нэ 26 ...нэ А/17

Бүлэг 8. Нисэхийн уур амьсгалын мэдээлэл

Тайлбар. Энэ бүлэгт холбоотой журам стандартыг PANS-MET(Doc 10157)-ийн Chapter 7-д тусгасан.

8.1 Ерөнхий зүйл (General provisions)

Тайлбар 1. Журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 7.1-д тусгасан.

Тайлбар 2. Цаг уурын байгууллагуудын хооронд байгуулсан гэрээний дагуу нисэхийн уур амьсгалын мэдээллийн шаардлагыг үндэсний хэмжээнд хангах боломжгүй тохиолдолд ажиглалтын тоон өгөгдлийн цуглуулалт, боловсруулалт болон хадгалалтыг олон улсад ашиглах боломжтой компьютерын хэрэгслээр дамжуулж болох ба нисэхийн уур амьсгалын шаардлагатай мэдээллийг бэлтгэх үүргийг хүлээнэ.

8.1.1 Нислэгийн үйл ажиллагааны төлөвлөлтөд ашиглагдах нисэхийн уур амьсгалын мэдээллийг аэродромын уур амьсгалын хураангуй болон хүснэгт хэлбэрээр бэлтгэж гаргасан байна. Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон хэрэглэгчид хооронд байгуулсан гэрээний дагуу нисэхийн хэрэглэгчдийг тус мэдээллээр хангана.

8.1.2 **Зөвлөмж** – *Нисэхийн уур амьсгалын мэдээллийг хамгийн багадаа 5 жилийн ажиглалтын мэдээг үндэслэн боловсруулах ба хэрэглэгчдийг мэдээллээр хангахдаа ажиглалтын хугацааг дурдсан байна.*

8.1.3 **Зөвлөмж** – *Шинээр ашиглалтад оруулж буй зурвас болон шинээр барьж буй аэродромуудын бэлтгэл ажил хангагдахаас өмнө уур амьсгалын тоон өгөгдлийг цуглуулсан байна.*

8.2 Аэродромын уур амьсгалын хүснэгт (Aerodrome climatological tables)

Тайлбар. Журам болон техникийн PANS-MET (Doc 10157)-ийн Section 7.2-д тусгасан.

Зөвлөмж - *Шаардлагатай ажиглалтын мэдээллийг цуглуулах, хадгалах ажлыг зохион байгуулж, дараах зүйлийг хийх чадвартай байх ёстой. Үүнд:*

a) үндсэн болон бэлтгэл аэродромд зориулсан аэродромын уур амьсгалын хүснэгт бэлтгэх;
b) агаарын тээвэрлэгчдийг уур амьсгалын хүснэгтэн мэдээллээр хангах

8.3 Аэродромын уур амьсгалын хураангуй (Aerodrome climatological summaries)

Тайлбар. Журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 7.3-д тусгасан.

Зөвлөмж – *Аэродромын уур амьсгалын хураангуйг WMO-аас тогтоосон журмын дагуу мөрдөж ажиллана. Мэдээллийг хадгалах, боловсруулах, олж авах боломжтой тооцоолох төхөөрөмж байгаа тохиолдолд хураангуйг нийтлэх, эсхүл нисэхийн хэрэглэгчдийн хүсэлтээр өөр хэлбэрээр гаргаж өгнө. Иймэрхүү тооцоолох хэрэгсэл байхгүй тохиолдолд хураангуйг WMO-аас тогтоосон загварыг ашиглан бэлтгэж, шаардлагатай бол нийтэлж, шинэчилнэ.*

8.4 Цаг уурын ажиглалтын мэдээний хуулбар (Copies of meteorological observational data)

Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага бүр судалгаа шинжилгээ, шинжлэн шалгах ажиллагаа, үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөхөд шаардлагатай цаг уурын ажиглалтын мэдээг харилцагч байгууллагууд болон агаарын навигацийн цаг уурын үйлчилгээний ашиглалттай холбоотойгоор бусад хэрэглэгчдийн хүсэлтээр гаргаж өгөх боломжийг бүрдүүлсэн байна.

8.5 Нисэхийн уур амьсгалын мэдээлэл солилцох (Exchange of aeronautical climatological information)

Зөвлөмж - *Нисэхийн уур амьсгалын мэдээллийг солилцохдоо цаг уурын байгууллагууд хоорондоо хүсэлт явуулна. Энэхүү мэдээллийг авахыг хүссэн агаарын тээвэрлэгч болон нисэхийн бусад хэрэглэгчид уг мэдээллийг бэлтгэдэг нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагатай холбогдоно.*

АЛЬ СРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(Баг түшаалын нэр)
Цанцаа
(гарын үсгийн тайлал)
26 01 сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Дугаар 26 А/17

Бүлэг 9. Агаарын тээвэрлэгч болон нисэх багийн гишүүдэд үзүүлэх цаг уурын үйлчилгээ

Тайлбар. Агаарын тээвэрлэгч болон нисэх багийн гишүүдэд үзүүлэх цаг уурын үйлчилгээг PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 8-д тусгасан.

9.1 Ерөнхий зүйл (General provisions)

9.1.1 Агаарын тээвэрлэгчид болон нисэх багийн гишүүдийг дараах цаг уурын мэдээллээр хангана. Үүнд:

a) агаарын тээвэрлэгчдийн нислэгийн өмнөх төлөвлөлт;
b) нислэгийн үйл ажиллагааны удирдлагын төвлөрсөн системийг ашигласан агаарын тээвэрлэгчдийн нислэгийн үеийн шинэчилсэн төлөвлөлт;
c) нислэгийн өмнөх нисэх багийн гишүүдийн ашиглалт;
d) нислэг үйлдэж буй агаарын хөлөг.

9.1.2 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь агаарын тээвэрлэгчтэй хамтран зөвшилцөж дараах зүйлийг тогтооно:

а) цаг уурын мэдээний төрөл болон хэлбэр;
б) тухайн мэдээллээр хангах арга болон хэрэгсэл;

9.1.3 Агаарын тээвэрлэгчид болон нисэх багийн гишүүдэд өгөх цаг уурын мэдээлэл нь нислэгийн чиглэл, хугацаа, өндөр болон газар зүйн хамрах хүрээний хувьд нийцсэн байна. Уг мэдээлэл нь тогтсон цаг хугацаанд хамаарах ба буухаар төлөвлөсөн аэродром хүртэлх болон буухаар төлөвлөсөн аэродромоос агаарын тээвэрлэгчдийн тодорхойлсон бэлтгэл аэродром хүртэлх цаг уурын ирээдүйн төлөв байдлын тухай мэдээллийг багтаасан байна.

9.1.4 Агаарын тээвэрлэгчид болон нисэх багийн гишүүдийг дараах мэдээллээр хангана. Үүнд:

а) Аэродромын болон чиглэлийн ажиглалтын мэдээ
б) Аэродромын болон чиглэлийн урьдчилсан мэдээ

Тайлбар. Үйл ажиллагаа явуулагчид болон нислэгийн багийн гишүүдэд нийлүүлэх цаг уурын мэдээллийн жагсаалт нь PANS-MET (Doc 10157)-ийн 8.1.1.2-д тусгасан.

9.1.5 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон агаарын тээвэрлэгч хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол урьдчилсан мэдээг цаг хугацаа, өндөр, газарзүйн хамрах хүрээний хувьд төлөвлөсөн нислэгийн замыг хамарсан тохиолдолд WAFC's-аас өгсөн тоон урьдчилсан мэдээнээс гарна.

9.1.6 Хэрэв урьдчилсан мэдээг WAFCs-аас гаргасан гэж үзвэл түүнд агуулагдах цаг уурын мэдээлэл өөрчлөгдөхгүй.

9.1.7 Агаарын тээвэрлэгчдийн нислэгийн өмнөх төлөвлөлт, нислэгийн үеийн шинэчилсэн төлөвлөлт хийхэд шаардлагатай нислэгийн түвшин FL100-өөс дээш өндрийн салхи, өндрийн агаарын температур болон онцгой үзэгдлийн SIGWX урьдчилсан мэдээг хүлээн авсан даруйд нислэг эхлэхээс 3 цагийн өмнө гаргаж өгнө. Агаарын тээвэрлэгчдийн нислэгийн өмнөх төлөвлөлт, нислэгийн

үеийн шинэчилсэн төлөвлөлт хийхэд шаардлагатай цаг уурын бусад мэдээллүүдийг даруй гаргаж өгнө.

9.1.8 Энэ заалт хамааралгүй тул орхилт хийгдсэн.

9.1.9 Агаарын тээвэрлэгчид болон нисэх багийн гишүүд, нислэгийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь бусад улсын цаг уурын байгууллагуудаас шаардлагатай мэдээ, мэдээллийг солилцож хамтран ажиллана.

9.1.10 Агаарын тээвэрлэгч, нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага хоорондын тохиролцсоны дагуу тогтоосон байрлал, цаг хугацаанд агаарын тээвэрлэгч болон нисэх багийн гишүүдэд цаг уурын мэдээллүүдийг гаргаж өгнө. Нислэгийн өмнөх төлөвлөлтөд үзүүлж буй үйлчилгээ нь тухайн улсын нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй нислэгээр хязгаарлагдана. Аэродром дээр нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагагүй тохиолдолд цаг уурын мэдээлэл өгөх зохицуулалтыг нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон холбогдох агаарын тээвэрлэгчид хооронд байгуулсан гэрээний дагуу зохицуулна.

9.2 Зөвлөмж, зөвлөгөө болон дэлгэцийн мэдээллийн үйлчилгээ (Briefing, consultation and display)

Тайлбар. Зөвлөмж, зөвлөгөө, дэлгэцийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэхэд нислэгийн өмнөх автоматжуулсан мэдээллийн системийг ашиглах шаардлагуудыг 9.4-т үзүүлсэн болно.

9.2.1 Нисэх багийн гишүүд болон бусад нислэгийн үйл ажиллагаанд холбогдолтой бие бүрэлдэхүүний хүсэлтийн дагуу зөвлөмж болон, эсхүл зөвлөгөөг өгнө. Энэ зөвлөмж, зөвлөгөө өгөх гол зорилго нь нислэгийн чиглэл дэх, буухаар төлөвлөсөн, бэлтгэл болон бусад холбогдох аэродром дээрх цаг уурын бодит, ирээдүйн төлөв байдлын тухай хамгийн сүүлийн шинэчлэгдсэн мэдээллийг өгөхөд оршино. Мөн түүнчлэн нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон агаарын тээвэрлэгч нар харилцан тохиролцсон бол нислэгийн баримт бичигт тусгагдсан мэдээллүүдэд холбогдох тайлбар болон нэмэлт хийж болно.

9.2.2 Зөвлөмж, зөвлөгөө болон дэлгэцийн мэдээллийн үйлчилгээнд ашиглах цаг уурын мэдээлэлд 9.1.4-д заасан зарим, эсхүл бүх мэдээллийг багтаасан байна.

9.2.3 Хэрэв нислэгийн баримт бичигт тусгагдсан аэродромын урьдчилсан мэдээ нь тухайн аэродром дээрх цаг уурын төлөв байдалтай мэдэгдэхүйц зөрсөн тохиолдолд нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагаас нисэх багийн гишүүдэд зөрүүтэй холбоотой цаг агаарын талаар зөвлөмж, зөвлөгөө өгнө.

9.2.4 Нисэн гарах аэродромд үйлчилгээ үзүүлж буй нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь шаардлагатай зөвлөмж, зөвлөгөө, дэлгэцийн мэдээллийн үйлчилгээ болон нислэгийн баримт бичгээр тухайн нислэгийг хангана. Дээрх үйлчилгээг үзүүлэх боломжгүй аэродром дээрх нисэх багийн гишүүдэд үзүүлэх үйлчилгээний асуудлыг нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон холбогдох агаарын тээвэрлэгчдийн хооронд байгуулсан гэрээний дагуу зохицуулна. Онцгой нөхцөл байдалд, тухайлбал нислэг удаан

хугацаагаар саатах тохиолдолд тухайн аэродромд үйлчилгээ үзүүлж буй нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь шаардлагатай гэж үзвэл шинэчилсэн давтан зөвлөмж, зөвлөгөө болон нислэгийн баримт бичгээр хангах, эсхүл үүнийг хэрэгжүүлэх боломжгүй бол уг хангалтын ажлыг дахин зохион байгуулна.

9.2.5 **Зөвлөмж** – *Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон агаарын тээвэрлэгчдийн хооронд байгуулсан гэрээнд заасан хугацаанд нисэх багийн гишүүд болон бусад нисэхийн үйл ажиллагаанд холбогдолтой бие бүрэлдэхүүнүүд нь тухайн цаг уурын албан дээр очиж шаардлагатай зөвлөмж, зөвлөгөө болон нислэгийн баримт бичгийг авна. Аэродромын тухайн нөхцөл байдалд зөвлөмж болон зөвлөгөөг биечлэн өгөх боломжгүй бол нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага утсаар, эсхүл бусад тохиромжтой холбооны төхөөрөмжөөр дамжуулан уг үйлчилгээг үзүүлнэ.*

9.2.6 **Зөвлөмж -** *Дэлгэцийн мэдээлэл нь нисэх багийн гишүүд эсвэл холбогдох бусад нислэгийн ажилтнуудад хялбар хүртээмжтэй байна.*

9.3 Нислэгийн баримт бичиг (Flight documentation)

Тайлбар 1. Нислэгийн баримт бичигтэй холбоотой шаардлагыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 8.2-д тусгасан.

Тайлбар 2. Нислэгийн баримт бичгийг бүрдүүлэхийн тулд нислэгийн өмнөх автоматжуулсан мэдээллийн системийг ашиглахад тавигдах шаардлагыг 9.4-т тусгасан болно.

9.3.1 Нислэгийн баримт бичигт 9.1.4-д заасан мэдээллийг агуулсан байна.

9.3.2 Нислэгийн баримт бичигт багтсан цаг уурын мэдээлэл нь нислэгийн өмнөх төлөвлөлт, нислэгийн үеийн шинэчилсэн төлөвлөлтөд бэлтгэж өгсөн мэдээллээс мэдэгдэхүйц зөрүүтэй болсон тохиолдолд агаарын тээвэрлэгч нь энэ тухай шуурхай мэдээлэх ба холбогдох нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага агаарын тээвэрлэгчид хооронд байгуулсан гэрээний дагуу боломжийн хирээр залруулсан мэдээллээр үйлчилнэ.

9.3.3 **Зөвлөмж** - *Нислэгийн баримт бичгийг гардуулсны дараа агаарын хөлөг хөөрөхөөс өмнө нислэгийн баримт бичигт өөрчлөлт хийх шаардлага гарсан тохиолдолд зайлшгүй өөрчлөлт болон шинэчилсэн мэдээллийг агаарын тээвэрлэгчдэд, эсхүл НХҮ-ний нэгжээр дамжуулан агаарын хөлөгт дамжуулна.*

9.3.4 **Зөвлөмж -** *Тусгай маршрутын өндрийн салхи болон өндрийн агаарын температурын урьдчилсан мэдээ бүхий нислэгийн баримт бичгийг нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон агаарын тээвэрлэгч хооронд хэлэлцэж тохирно.*

Тайлбар. Зургийн хэлбэр загварыг Manual of Aeronautical Meteorological Practice" (Doc 8896)-д тусгасан.

9.3.5 Бусад цаг уурын байгууллагаас хүлээж авсан цаг уурын мэдээллүүдэд өөрчлөлт оруулахгүйгээр нислэгийн баримт бичгийг оруулна.

БАР ҮНЭН
Архив
гүшаалын нэр)
Ханын
(гарын үсгийн тайлал)
01 дугаар сарын 29
МОНГОЛ УЛСЫН
ЭЖ ХУВЬ
Сайд
26 А/17

9.3.6 **Зөвлөмж** - *Нислэгийн баримт бичигт багтсан зургууд нь тодорхой, ойлгомжтой, уншихад хялбар өндөр стандартад нийцсэн байна.*

Тайлбар. Нислэгийн баримт бичигт оруулсан зургийн үзүүлэлт болон нарийвчлалыг PANS-MET(Doc 10157)-ийн Section 8.2.3.1-д тусгасан.

9.3.7 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь нисэх багийн гишүүдэд өгсөн мэдээллийн хэвлэмэл хувь болон цахим файлуудыг гаргасан өдрөөс хойш хамгийн багадаа 30 хоногийн хугацаанд хадгална. Уг мэдээллийг байцаалт, эсхүл шинжлэн шалгах ажиллагаанд бэлтгэж өгөх бөгөөд уг зорилгоор тухайн байцаалт, эсхүл шинжлэн шалгах ажиллагааг дуустал хадгална.

9.4 Зөвлөмж, зөвлөгөө, нислэгийн төлөвлөлт, нислэгийн баримт бичигт зориулсан нислэгийн өмнөх автомат мэдээллийн систем (Automated pre-flight information systems for briefing, consultation, flight planning and flight documentation)

Тайлбар. Журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 8.3-д тусгасан.

9.4.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь агаарын тээвэрлэгчид болон нисэх багийн гишүүдэд зөвлөмж зөвлөгөө өгөх, нислэгийн төлөвлөлт, нислэгийн баримт бичигт оруулах зорилгоор цаг уурын дэлгэцэн мэдээллээр хангахдаа нислэгийн өмнөх автомат мэдээллийн системийг ашигладаг бол 9.1-ээс 9.3-р заалтуудын дагуу мэдээлнэ.

9.4.2 **Зөвлөмж** - *Агаарын тээвэрлэгчид, нисэх багийн гишүүд болон нисэхийн бусад ажилчдыг цаг уурын мэдээллээр хангах, НМҮ-д нэвтрэх нөхцөлийг бүрдүүлдэг нислэгийн өмнөх автоматжуулсан мэдээллийн систем нь нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон иргэний нисэхийн байгууллага, эсхүл эрх олгосон холбогдох агентлаг хоорондын байгуулсан гэрээний дагуу, Конвенцын Хавсралт 15-ын 2.1.1 с)-ийн заалтын дагуу үйлчилгээ үзүүлнэ.*

Тайлбар. Цаг уурын болон НМҮ-ний холбогдох мэдээллийн 9.1-ээс 9.3, болон Procedures for Air Navigation Services - Aeronautical Information Management (PANS-AIM (Doc 10066))-ийн 5.5-д тус тус тусгасан болно.

9.4.3 Нислэгийн өмнөх автоматжуулсан мэдээллийн системийг агаарын тээвэрлэгчид, нисэх багийн гишүүд болон бусад нисэхийн ажилчдыг цаг уурын мэдээлэл, НМҮ-ний нэгдсэн цэгээр хангах зорилгоор ашиглаж байгаа тохиолдолд холбогдох нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь Бүлэг 2-ын 2.2.2-д заасны дагуу чанарын хяналт тавих, чанарын менежментээр хангах үүргийг хүлээнэ.

Тайлбар. НМҮ-ний мэдээлэл ба мэдээллийн чанарын баталгаажуулалттай холбогдолтой үүргүүдийг Конвенцын Хавсралт 15, Chapter 1,2 болон 3 дахь заалтуудад тусгасан болно.

9.4.4 Нислэгийн өмнөх мэдээллийг автоматжуулсан системээр өөрөө танилцах боломжтой болгохдоо эдгээр систем нь агаарын тээвэрлэгч болон нисэх багийн гишүүдэд шаардлагатай тохиолдолд цаг уурын байгууллагатай утсаар эсвэл бусад холбооны хэрэгслээр зөвлөлдөх боломжтой байна.

ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дугаар сарын 29
МОНГОЛ УЛСЫН
ЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 А/17

9.5 Нислэг үйлдэж буй агаарын хөлөгт зориулсан цаг уурын мэдээлэл (Meteorological information for aircraft in flight)

Тайлбар. Журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 8.4-д тусгасан.

9.5.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь нислэг үйлдэж буй агаарын хөлөгт зориулсан цаг уурын мэдээллийг холбогдох НХҮ-ний нэгжид өгөх ба тэдгээрийн хооронд байгуулсан гэрээний дагуу VOLMET радио нэвтрүүлгээр дамжуулна.

9.5.2 Бүлэг 10-т заасны дагуу нислэг үйлдэж буй агаарын хөлөгт зориулсан цаг уурын мэдээллийг НХҮ-ний нэгжүүдэд дамжуулна.

9.5.3 Хэрэв нислэг үйлдэж буй агаарын хөлгөөс цаг уурын мэдээлэл хүсвэл, хүсэлтийг хүлээн авсан нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага шаардлагатай бол бусад холбогдох цаг уурын байгууллагын тусламжтайгаар мэдээллийг хүргэхээр зохион байгуулна.

9.5.4 Бүлэг 11-т заасны дагуу VOLMET радио нэвтрүүлэгчээр цаг уурын мэдээллийг дамжуулна.

ЦАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
20 26 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУУЛ
Сайд
дарын 26 А/17

Бүлэг 10. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, эрэн хайх, авран туслах үйлчилгээ болон нислэгийн мэдээллийн үйлчилгээнд зориулсан цаг уурын мэдээлэл

Тайлбар. Энэ бүлэгт холбоотой журам стандартыг PANS-MET (Doc 10157)-ийн Chapter 9-д тусгасан.

10.1 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжид зориулсан мэдээлэл (Information for air traffic services units)

Тайлбар. Журам болон техникийн PANS-MET (Doc 10157)-ийн Section 9.1-д тусгасан.

10.1.1 Ерөнхий зүйл (General)

10.1.1.1 Цаг уурын эрх бүхий байгууллага нь ИНҮТ ТӨХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулна. Нислэгийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь НХҮ-ний нэгж бүртэй холбогдон ажиллах ба уг нэгжийн үйл ажиллагааны чиглэлд шаардлагатай хамгийн сүүлийн хугацааны цаг уурын мэдээллээр хангах, эсхүл хангалтын ажлыг зохион байгуулна.

10.1.1.2 **Зөвлөмж** - *Нислэгийг цаг уурын мэдээгээр хангахдаа нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь аэродромын хөдөлгөөний удирдлагын цамхаг, эсхүл ойртолтын удирдлагын нэгжтэй харилцан ажиллана.*

10.1.1.3 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь нислэгийг цаг уурын мэдээгээр хангахдаа FIC, эсхүл ACC-тэй харилцан ажиллана.

10.1.1.4 **Зөвлөмж** - *Тухайн газрын нөхцөл байдлын улмаас холбогдох цаг уурын байгууллагын үүргийг хэд хэдэн цаг уурын байгууллага хамтран гүйцэтгэнэ.*

10.1.1.5 Агаарын хөлгийн онцгой байдлын үед НХҮ-ний нэгжээс шаардсан цаг уурын мэдээллийг аль болох богино хугацаанд гаргаж өгнө.

10.1.2 Мэдээллээр хангах, түгээх, дамжуулах зохицуулалт (Supply, dissemination and transmission arrangements)

10.1.2.1 Шаардлагатай тохиолдолд бодит цаг агаарын мэдээ, урьдчилсан мэдээг нисэхийн холбооны станцуудаар Нислэгийн Мэдээллийн Төв (FIC), эсхүл Бүсийн удирдлагын төв (ACC)-д илгээнэ.

10.1.2.2 **Зөвлөмж** - *Хэрэв тооцоолон боловсруулсан өндрийн агаарын торлосон цэгийн тоон өгөгдлийг нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний (ATS) нэгжүүдэд ATS компьютерт ашиглах зорилгоор хүргэж байгаа бол, дамжуулалтын зохион байгуулалтыг нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон холбогдох ATS эрх бүхий байгууллагын хооронд тохиролцсоны дагуу гүйцэтгэнэ. Урьдчилсан мэдээ боловсруулагдсан даруй аль болох хурдан энэ өгөгдлийг хүргэнэ.*

ХУУЛБАР ҮНЭН
Архив 2
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
26 оны 01 дугаар сарын 29
МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 А/17

10.2 Эрэн хайх, авран туслах үйлчилгээний нэгжид зориулсан мэдээлэл (Information for search and rescue services units)

Тайлбар. Журам болон техникийн PANS-MET (Doc 10157)-ийн Section 9.2-д тусгасан.

10.2.1 Ерөнхий зүйл (General)

Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь НХҮ-ний байгууллагатай байгуулсан гэрээний дагуу цаг уурын үйлчилгээг ямар хэлбэрээр хангахыг шийдвэрлэх ба эрэн хайх авран туслах үйл ажиллагааны туршид тухайн ЭХАТ үйлчилгээний нэгжтэй холбоотой ажиллана.

10.2.2 Мэдээллийн жагсаалт (List of information)

Эрэн хайх, аврах туслах үйлчилгээний нэгжид өгөгдөх мэдээлэлд, алга болсон агаарын хөлгийн хамгийн сүүлд мэдэгдсэн байршил болон түүний төлөвлөсөн маршрутын дагуу тухайн үеийн цаг агаарын нөхцөл байдлыг тусгасан байна. Үүнд:

a) нислэгийн замын дагуух цаг агаарын онцгой үзэгдэл;
b) үүлний төрөл болон тоо хэмжээ, борооны бөөн үүл, доод суурийн өндөр болон дээд хилийн өндөр;
c) алсын барааны харагдац болон алсын барааны харагдцыг муутгагч үзэгдэл;
d) газар орчмын болон өндрийн салхи;
e) газрын гадаргын байдал, тухайлбал: цасан бүрхэц, эсхүл үер;
g) MSL дэх даралт;

10.3 Нисэхийн мэдээллийн үйлчилгээний нэгжид зориулсан мэдээлэл (Information for aeronautical information services units)

10.3.1 Ерөнхий (General)

Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь нисэхийн мэдээллийн үйлчилгээний холбогдох нэгжүүдийг цаг уурын шинэчилсэн мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна.

10.3.2 Мэдээллийн жагсаалт (List of information)

Дараах мэдээллийг нисэхийн мэдээллийн үйлчилгээний нэгжид нийлүүлнэ.

a) Агаарын навигацийн нисэхийн цаг уурын үйлчилгээний мэдээллийг Нисэхийн мэдээллийн эмхэтгэлд (AIP)-д оруулна.

Тайлбар. Энэхүү мэдээллийн нарийвчлал Procedures for Air Navigation Services Aeronautical Information Management (PANS-AIM (Doc 10066)-ийн Appendix 3-ын Part 1-ийн GEN 3.5 болон Part 3-ын AD 2.2, 2.11, 3.2 болон 3.11-д тусгасан болно.

b) NOTAM бэлтгэхэд шаардлагатай дараах мэдээлэлд:
   1) Нисэхийн цаг уурын үйлчилгээний үйл ажиллагааны онцгой өөрчлөлтийн тухай мэдээлэл. Энэ мэдээллийг Конвенцын Хавсралт 15-ын 6.3.2.2 ба 6.3.2.3-т заасан хугацаанаас өмнө нийлүүлнэ.
   2) Галт уулын зөвлөмжийн төвөөс хүлээн авсан галт уулын идэвхжилийн мэдээлэл.

Тайлбар. Тусгай мэдээнд шаардагдах тусгай мэдээллийг Конвенцын Хавсралт 3-ын Chapter 3, 3.3.2 h) болон Chapter 4, 4.8-д тусгана.

ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
Чанцал
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дүгээр сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 A/17

3) Галт уулын зөвлөмжийн төвөөс хүлээн авсан цацраг идэвхт бодис агаарт тархсан тухай мэдээлэл

Тайлбар. Тусгай мэдээнд шаардагдах тусгай мэдээллийг Конвенцын Хавсралт 3-ын Chapter 3, 3.4.2 g)-д тусгана.

c) Нисэхийн мэдээллийн цуврал (AIC) бэлтгэхэд шаардлагатай дараах мэдээлэлд:

1) Нисэхийн цаг уурын үйл ажиллагаа, үйлчилгээ, байгууламжид орох чухал өөрчлөлтийн урьдчилсан тооцоолол
2) Тодорхой цаг агаарын үзэгдэл нислэгийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө

ИРГЭЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архив
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн ... албан ...
Дарын 26 ... А/17 ...

Бүлэг 11. Цаг уурын мэдээллийг солилцох харилцаа холбооны ашиглалт

Тайлбар 1. Энэ бүлэгт холбоотой журам стандартыг PANS-MET(Doc 10157)-ийн Chapter 10-д тусгасан.

Тайлбар 2. Улс бүр энэ бүлэгт дурдсан холбооны тоног төхөөрөмжүүдийг хэрэглэх өөрийн дотоод зохион байгуулалт, хариуцлагыг шийдвэрлэх үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрнө.

11.1 Харилцаа холбоонд тавигдах шаардлага (Requirements for communications)

11.1.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага, НХҮ-ний нэгжүүдэд (аэродромын хөдөлгөөний удирдлагын цамхаг, ойртолтын удирдлагын нэгж) шаардагдах цаг уурын мэдээллээр хангах боломжтой холбооны төхөөрөмжүүдтэй байна.

11.1.2 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь ЭХАТ бүс, СТА болон FIR's-үүдэд үйлчилгээ үзүүлж буй НХҮ-ний болон ЭХАТ үйлчилгээний нэгжүүдийг шаардлагатай цаг уурын мэдээллээр хангах тохиромжтой нисэхийн цахилгаан холбооны төхөөрөмжүүдтэй байна.

11.1.3 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь бусад хэрэглэгчдэд дэлхийн бүсийн урьдчилсан мэдээг тохиромжтой байдлаар түгээхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

11.1.4 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон нисэхийн цаг уурын өртөө, нислэгийн хөдөлгөөний удирдлагын цамхаг, ойртолтын удирдлагын нэгжүүд хоорондын цахилгаан холбооны төхөөрөмж нь шууд ярих боломжийг хангасан бөгөөд тэдгээрийн хурд нь цэгүүд хооронд ойролцоогоор 15 секундийн хугацаанд холбоо тогтооход хангалттай байх ёстой.

11.1.5 **Зөвлөмж** - *FIC, бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төв, авран туслах ажиллагааг зохицуулах төв, нисэхийн холбооны станцууд болон нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага хооронд байгуулсан гэрээний дагуу цахилгаан холбооны төхөөрөмж нь дараах боломжуудыг хангасан байна. Үүнд:*

a) шууд ярих холбоо, тэдгээрийн хурд нь цэгүүд хооронд ойролцоогоор 15 секундийн хугацаанд холбоо тогтооход хангалттай байна.

b) өгөгдөл дамжуулах холбоо, хүлээн авагч нь өгөгдлийг бичгийн хэлбэрээр шаардсан тохиолдолд түүнийг дамжуулах хугацаа нь 5 минутаас хэтрэхгүй байна.

Тайлбар. 11.1.4 ба 11.1.5-д дурдсан "ойролцоогоор 15 секунд" гэж шилжүүлэгч самбартай "5 минут" гэдэг нь дахин дамжуулах хэвлэмэл холбоог хэлнэ.

11.1.6 **Зөвлөмж** - *11.1.4 ба 11.1.5-д заасан холбооны төхөөрөмжүүдэд шаардлагатай бол нэмэлтээр бусад дүрс болон дуут холбоог суурилуулж болно. Тухайбал: хаалттай хэлхээний телевиз, эсхүл тусдаа мэдээлэл боловсруулах систем.*

11.1.7 **Зөвлөмж** - *Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон агаарын тээвэрлэгчид хооронд зөвшилцсөний дагуу агаарын*

ЗАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
Бүртгэлийн дугаар 607
ХУУДАС ХУЛЭЭН
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлбар)
20 оны дугаар сарын
МОНГОЛ УЛС
ЗАМ, ТЭЭВРИЙН ДА
ЭХ ХУУД
Дагалдах 26 А/17

тээвэрлэгчдийг нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон бусад холбогдох эх үүсвэрүүдээс цаг уурын мэдээллийг хүлээн авахад шаардлагатай цахилгаан холбооны төхөөрөмжүүдийг суурилуулах боломжоор хангана.

11.1.8 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь бусад цаг уурын байгууллагуудтай шуурхай үйл ажиллагааны мэдээллийг солилцоход шаардлагатай холбооны төхөөрөмжүүдээр хангагдсан байна.

11.1.9 **Зөвлөмж** - *Цаг уурын шуурхай үйл ажиллагааны мэдээллийг солилцоход ашиглагдаж буй цахилгаан холбооны тоног төхөөрөмжүүд нь нисэхийн суурин холбооны үйлчилгээ байх, эсхүл цаг хугацааны хувьд эрсдэлтэй бус цаг уурын шуурхай үйл ажиллагааны мэдээллийг солилцоход хоёр талын, (олон талт болон) эсхүл бүсийн хэмжээний агаарын навигацийн гэрээ байгуулсан тохиолдолд үйл ажиллагааны шаардлагыг хангасан нийтийн интернэт ашиглаж болно.*

Тайлбар 1. Дэлхийн бүсийн урьдчилан мэдээлэх төвүүдийн ашигладаг нисэхийн суурин холбооны интернэтэд суурилсан үйлчилгээ нь дэлхийн цаг уурын мэдээллийн солилцоог хангахад ашиглагддаг.

Тайлбар 2. Цаг хугацааны хувьд эрсдэлтэй бус цаг уурын үйл ажиллагааны мэдээлэл болон интернэтийн холбогдох нөхцөлүүдийн зааварчилгааг ICAO-ын баримт бичиг Doc 9855-д тусгасан болно.

11.1.10 **Зөвлөмж** - *Хэрэв өндрийн торлосон цэгийн өгөгдөл тоон хэлбэртэй, НХҮ компьютерт ашиглах боломжтой бол, дамжуулалтын зохицуулалтыг нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон холбогдох НХҮ эрх бүхий байгууллагын хооронд тохиролцсоны дагуу хийнэ.*

11.1.11 **Зөвлөмж** - *Хэрэв өндрийн торлосон цэгийн өгөгдөл тоон хэлбэртэй бол нислэгийн төлөвлөлтийг цахимаар боловсруулах зорилгоор агаарын тээвэрлэгч нийлүүлэхдээ, дамжуулалтын зохицуулалтыг холбогдох дэлхийн бүсийн урьдчилсан мэдээний төв (WAFC), нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон холбогдох агаарын тээвэрлэгчдийн хооронд тохиролцсоны дагуу хийнэ.*

11.2 Нисэхийн суурин холбоо болон нийтийн интернэтийн ашиглалт - (Use of aeronautical fixed service communications and the public Internet)

Тайлбар. Журам болон техникийн PANS-MET (Doc 10157)-ийн Section 10.1-д тусгасан.

11.2.1 Цаг уурын бюллетен (Meteorological bulletins)

11.2.1.1 Нисэхийн суурин холбооны үйлчилгээ, эсхүл интернэтээр дамжих цаг уурын шуурхай мэдээлэл агуулсан цаг уурын товхимлыг холбогдох нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага бэлтгэнэ.

Тайлбар. Нисэхийн суурин холбооны үйлчилгээгээр дамжих цаг уурын шуурхай мэдээлэл агуулсан цаг уурын товхимлыг Конвенцын Хавсралт 10, Volume II, Chapter 4-т тусгасан болно.

11.2.1.2 Ашиглалтын зориулалттай цаг уурын мэдээлэл бүхий мэдээ нь 5 минутаас бага хугацаанд дамжигдсан байна.

ИРГЭЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дүгээр сарын 29

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 А/17

11.2.2 Дэлхийн бүсийн урьдчилан мэдээлэх систем (World area forecast system forecasts)

11.2.2.1 **Зөвлөмж** – *Дэлхийн бүсийн урьдчилан мэдээлэх систем (WAFS)-ийн урьдчилсан мэдээг түгээхэд ашиглагдах харилцаа холбооны хэрэгсэл нь нисэхийн суурин холбоо эсвэл интернэт байна.*

11.2.2.2 **Зөвлөмж** – *WAFS-ийн урьдчилсан мэдээг дижитал өгөгдлийн холбооны тоног төхөөрөмж ашиглан тоон хэлбэрээр дамжуулна. Урьдчилсан мэдээг түгээхэд ашиглагдах аргачлал, сувгийг тодорхойлно.*

11.3 Нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээний төхөөрөмжийн ашиглалт (Use of aeronautical mobile service communications)

Тайлбар. Журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 10.2-д тусгасан.

Агаарын хөлгөөс болон агаарын хөлөгт дамжуулж буй цаг уурын мэдээллийн агуулга ба формат нь энэхүү баримт бичгийн зүйл, заалтуудад нийцсэн байна.

11.4 D-VOLMET радио нэвтрүүлгийн холболтын үйлчилгээг ашиглах – (Use of aeronautical data link service D - VOLMET)

Энэ заалт хамааралгүй тул орхилт хийгдсэн.

11.5 Нисэхийн радио нэвтрүүлгийн үйлчилгээний ашиглалт – VOLMET радио нэвтрүүлэг (Use of aeronautical broadcasting service - VOLMET broadcasts)

Тайлбар. Журам болон техникийн тодорхойлолтыг PANS-MET (Doc 10157)-ийн Section 10.4-д тусгасан.

11.5.1 Хэт өндөр давтамж (VHF)-тай сувгаар үргэлжлэн хийж буй VOLMET радио нэвтрүүлгээр METAR, SPECI (боломжтой бол хандлагын урьдчилсан мэдээний хамт)-ийг дамжуулна.

11.5.2 Өндөр давтамж (HF)-тай сувгаар хуваарийн дагуу хийж буй VOLMET радио нэвтрүүлгээр METAR, SPECI (боломжтой бол хандлагын урьдчилсан мэдээний хамт)-ийг, TAF болон SIGMET мэдээллийг дамжуулж болно.

ТӨРИЙН ӨМЧИЙН ОНЦГОЙ АЛБАТ ЗҮЙЛИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Шуурхайн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
Чанчин
(Нэр үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дүгээр сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУЛБ
Саид Тушаал
Дугаар 26 А/17

Хавсралт 1. Нислэгийн баримт бичиг - загвар зураг болон маягт (Flight documentation - model charts and forms)

(Бүлэг 9-ийг үзнэ үү)

MODEL A OPMET мэдээлэл (OPMET information)

MODEL IS Стандарт даралтын гадаргын өндрийн салхи, өндрийн агаарын температурын зураг (Upper wind and upper-air temperature chart for standard isobaric surface)

Жишээ 1 - сум, өд, дарцаг (тэгш өнцөгт хэлбэрийн (Mercator projection))

Жишээ 2 - сум, өд, дарцаг (туйлын хэлбэрийн (Polar stereographic projection))

MODEL SWH Цаг агаарын онцгой үзэгдлийн зураг (өндрийн) (Significant weather chart (high level))

Жишээ. Туйлын хэлбэрийн (Polar stereographic projection) (олгойдох урсгалын босоо хэмжээг харуулсан)

MODEL SWM Цаг агаарын онцгой үзэгдлийн зураг (дунд өндрийн) (Significant weather chart (medium level))

MODEL SWL Цаг агаарын онцгой үзэгдлийн зураг (нам өндрийн) (Significant weather chart (low level))

Жишээ 1

Жишээ 2

MODEL TCG Тропикийн циклоноос сэрэмжлүүлэх мэдээлэл- График форматын (Tropical cyclone advisory information in graphical format)

MODEL VAG Галт уулын үнснээс сэрэмжлүүлэх мэдээлэл- График форматын (Volcanic ash advisory information in graphical format)

Жишээ 1. Тэгш өнцөгт хэлбэрийн (Mercator projection)

Жишээ 2. Туйлын хэлбэрийн (Polar stereographic projection)

MODEL STC Тропикийн циклоны SIGMET- График форматын (SIGMET for tropical cyclone in graphical format)

MODEL SVA Галт уулын үнсний SIGMET- График форматын (SIGMET for volcanic ash in graphical format)

Жишээ 1. Тэгш өнцөгт хэлбэрийн (Mercator projection)

Жишээ 2. Туйлын хэлбэрийн (Polar stereographic projection)

MODEL SGE Тропикийн циклон, галт уулын үнснээс бусад цаг агаарын онцгой үзэгдлийн SIGMET- График форматын (SIGMET for phenomena other than tropical cyclone and volcanic ash in graphical format)

MODEL SN Нислэгийн баримт бичигт ашигласан тэмдэглэлийн тайлбар хуудас (Sheet of notations used in flight documentation)

***НИ-5 ХУУДАС** Нүүр

5,000 м, эсхүл түүнээс дээш өндрийн (дунд өндөр) нислэгт зориулсан НИ-5 хуудас

5,000 м-ээс доош өндрийн (нам өндөр) нислэгт зориулсан НИ-5 хуудас

НИСЭХИЙН ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архив2
(Албан тушаалын нэр)
Хонгор
(нэр үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Тоонин
Дамдин 26-А/17

ОРМЕТ МЭДЭЭЛЭЛ **MODEL A**

Гаргасан: Цаг уурын алба (өдөр, цаг UTC)

ЭРЧИМШИЛ

4.2.1.4 *Харанхуйд алсын барааг тодорхойлохын тулд алсын барааны гэрлэн тэмдэгтийг байрлуулж ашиглана.

4.2.1.5 *Хэрэв ажиглалтын бүх цэгт алсын барааг багажаар хэмжих бүрэн боломжтой бол алсын бараа тодорхойлох тэмдэгтийг ашиглахгүй, (эсхүл босгохгүй) байж болно.

4.2.1.6 *АБХ-ыг хэмжих төхөөрөмжөөр тоноглогдсон тохиолдолд 1500м юм уу түүнээс бага зайд алсын барааг багажаар хэмжинэ. Харин түүнээс их зайд бол тэмдэгт босгох юм уу байгалийн тэмдэгтийг ашиглана.

Тайлбар. АБХ-ыг нүдэн баримжаагаар тодорхойлох зааврыг Manual of Runway Visual Range Observing and Reporting Practices (DOC 9328)-ийн Chapter 10-т тусгасан болно.

4.2.2 Дэлгэц (Displays)

Зөвлөмж - *АБХ-ыг хэмжихдээ автомат ажиглалтын систем ашигладаг бол мэдрүүр бүрд холбоотой АБХ-ын өгөгдлийг гаргах дэлгэцүүдийг цаг уурын өртөө, НХҮ-ний нэгжүүдэд суурилуулна. Цаг уурын өртөө болон НХҮ-*

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ХУУЛЬДАР ЯМАН
Архивч
(Албан тушаалын нэр)
Гончуг
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
20 26 оны 01 дугаар сарын 29

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУПГ
Санд Терийн
дарсын 26 А/17

ний нэгжүүдэд суурилуулсан дэлгэцүүдийн мэдрүүрүүд нь нэг эх үүсвэрээс холбогдсон байх бөгөөд 4.2.1-д заасны дагуу нэмэлт төхөөрөмж байрлуулсан тохиолдолд дэлгэцэд мэдрүүр бүрийн аль ХБЗ болон ХБЗ-ын аль хэсгүүдийг хянаж байгааг нарийн ялгаж зааж өгсөн байх шаардлагатай.

4.2.3 Дундажлах (Averaging)

Зөвлөмж - *АБХ-ыг хэмжихдээ автомат ажиглалтын систем ашигладаг бол бодит тодорхойлогч утгыг тодорхойлохын тулд тэдгээрийн мэдээллийн гаралтын хугацаа нь хамгийн багадаа 60 секунд тутамд шинэчлэгдэх ёстой бөгөөд тухайн хугацааг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:*

a) тухайн газрын байгын болон тусгай мэдээнд, НХУ-ний нэгжүүдэд АБХ-ыг үзүүлж байгаа дэлгэцүүдэд 1 минутаар;

b) хэрэв 10 минутын хугацаанд өмнөх ажиглалттай харьцуулахад АБХ илт тогтворгүй болсон тохиолдолд, дундаж утгыг авахдаа тогтворгүй болсон хугацааны дараах тохиолдлыг л ашиглах бөгөөд дээрх тохиолдол ажиглагдаагүй үед METAR, SPECI-д 10 минутаар тус тус дундажлана.

Тайлбар. 2.3-т заасан SPECI гаргах шалгуурт хүрэх, эсхүл давсан үзэгдэх орчин дор хаяж сүүлийн 2 минут үргэлжилсэн, огцом, тогтвортой өөрчлөлт гарсан тохиолдолд мэдэгдэхүйц тасалдал үүсдэг.

4.2.4 Мэдээлэх (Reporting)

4.2.4.1 Тухайн газрын байгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-ийн АБХ-ыг мэдээлэхдээ 800 метрээс доош бол 50м, 800 метрээс 5км хүртэл 100м, 5-10км бол 1км-ийн зайцтайгаар, харин 10км, эсхүл түүнээс их боловч CAVOK-ийн нөхцөлөөс бусад тохиолдолд 10км гэж тус тус мэдээлнэ. Энэ хэмжлийн хуваарийг ашиглан мэдээлэхэд тохирохгүй байгаа дурын ажиглалтын хэмжлийг ойролцоо, эсхүл бага утгад шилжүүлж авна.

Тайлбар. CAVOK-ийг ашиглах тодорхойлолтуудыг 2.3-д тусгасан болно.

4.2.4.2 Тухайн газрын байгын болон тусгай мэдээнд ХБЗ-ын дагуух АБХ-ын тодорхойлсон нэгжийг түүний утгатай нь хамт мэдээлнэ.

4.2.4.3 **Зөвлөмж** - *Тухайн газрын байгын болон тусгай мэдээнд АБХ-ыг хэмжихдээ автомат төхөөрөмжийн систем ашигладаг бол дараах байдлаар өгнө. Үүнд:*

a) хэрэв АБХ-ын хэмжилтийг Бүлэг 4-ийн 4.6.2.2-д заасны дагуу ХБЗ-ын дагуух хэд хэдэн цэгээс хийдэг бол эхлээд газардах бүсийн мэдээг, дараа нь зайлшгүй тохиолдолд ХБЗ-ын дундаж цэгийн болон төгсгөл цэгийн мэдээг зааж өгнө;

b) хэд хэдэн ХБЗ-ыг ашиглаж байгаа тохиолдолд АБХ-ын хэмжилтийг ХБЗ болгон дээр хийж, ХБЗ-уудын АБХ-ын мэдээ бүрийг авч улмаар аль хэрэгцээтэй байгаа ХБЗ-ын АБХ-ын хэмжилтийг мэдээлнэ.

4.2.4.4 **Зөвлөмж** – *Бүлэг 1-д тодорхойлсны дагуу METAR, SPECI-д давамгайлах АБХ-ыг мэдээлэх бөгөөд хэрэв зүг бүрд адилгүй байвал дараах байдлаар өгнө. Үүнд:*

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ...
ХУУДАС ...
Архивч
(Албан тушаалын нэр)
Чагуул
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
26 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид Терийн ...
дарын 26 01/17

a) *хэрэв хамгийн бага АБХ нь давамгайлах АБХ-аас ялгаатай, эсхүл 1500 метрээс бага, эсхүл давамгайлах АБХ-аас 50%-р бага мөн 5000м-ээс бага бол ажиглагдсан хамгийн бага АБХ-ын аэродромтой харьцуулсан ерөнхий чиглэлийг найман зовхисоор илэрхийлж мэдээлнэ. Хэрэв алсын барааны хамгийн бага харагдац нэгээс олон зүгт ажиглагдаж байвал тэдгээрээс шуурхай үйл ажиллагаанд ач холбогдолтойг нь авч мэдээлнэ.*
b) *АБХ огцом өөрчлөгдөж АБХ-ыг тодорхойлох боломжгүй болсон тохиолдолд АБХ-ын зөвхөн хамгийн бага утгыг чиглэл заахгүйгээр мэдээлнэ.*

4.3 ХБЗ-ын дагуух АБХ (Runway visual range)

4.3.1 Байршил (Siting)

4.3.1.1 **Зөвлөмж** - *ХБЗ-ын дагуух АБХ-ын мэдрүүрийг ХБЗ-аас ойролцоогоор 2.5м (7.5ft) өндөрт, эсхүл ажиглагч ажиглаж байгаа тохиолдолд 5м (15ft) өндөрт байрлуулна.*

4.3.1.2 **Зөвлөмж** - *ХБЗ-ын дагуух АБХ-ын тэнхлэгийн шугамаас 120м-ээс илүүгүй зайд хэмжинэ. Ажиглалт хийж буй цэг нь газардах бүсийг илэрхийлдэг байх үүднээс түүнийг ХБЗ-ын босго цэгээс ойролцоогоор 300м зайд байрлуулна. Ажиглалт хийж буй цэг нь ХБЗ-ын дунд цэг болон төгсгөл цэгийн илэрхийлэгч байх үүднээс тэдгээрийг босгоноос 1000м-ээс 1500м, харин ХБЗ-ын төгсгөлөөс 300 метрийн зайд байрлуулна. Тухайн цэгийн нарийвчилсан байршил болон хэрэв шаардлагатай бол нэмэлт ажиглалтын цэгийг ХБЗ-ын урт, намаг, манан үүсэж болзошгүй газар зэрэг нисэхийн, цаг уурын болон уур амьсгалын нөхцөлийг тооцсоны үндсэн дээр байгуулна.*

4.3.2 Хэрэглэлийн систем (Instrumented systems)

Тайлбар. Хэрэглэлийн загвараас хамаарч нарийвчлал нь өөр өөр байж болох тул ХБЗ-ын дагуух АБХ-ыг үнэлэх хэрэглэлийг сонгохын өмнө гүйцэтгэлийн шинж чанарыг шалгана. Урагш цацах хэмжигч (forward-scatter meter)-ийн шалгалт тохируулга нь трансмиссометр хэмжигдэхүүний стандартын дагуу мөрдөж, баталгаажсан байх ёстой бөгөөд тэдгээрийн нарийвчлалыг баталгаажуулсан байна. ХБЗ-ын дагуух АБХ-ын хэрэглэлийн трансмиссометр болон урагш цацах хэмжигч (forward-scatter meter)-ийн зааврыг Manual of Runway Visual Range Observing болон Reporting Practices (Doc 9328)-т үзүүлсэн болно.

4.3.2.1 **Зөвлөмж** - *CAT I хэрэглэл ашиглан ойртолт болон буулт хийхэд зориулсан ХБЗ-ын дагуух АБХ-ыг үнэлэхдээ трансмиссометр болон урагш цацах хэмжигч (forward-scatter meter) системийг ашиглана.*

4.3.3 Дэлгэц (Display)

4.3.3.1 ХБЗ-ын дагуух АБХ-ын хэмжилтийг автоматжуулсан төхөөрөмжийн тусламжтайгаар хийдэг бол нэг дэлгэцийг (эсхүл, зайлшгүй шаардлагатай бол хэд хэдийг) цаг уурын өртөө, НХҮ-ний нэгжүүдэд суурилуулна. Цаг уурын өртөө болон НХҮ-ний нэгжүүдэд суурилуулсан дэлгэцүүдийн мэдрүүрүүд нь нэг эх үүсвэрээс байх бөгөөд 4.3.1.2-д заасны дагуу нэмэлт төхөөрөмж суурилуулсан тохиолдолд дэлгэцэд мэдрүүр бүрийн аль ХБЗ болон ХБЗ-ын аль хэсгүүдийг хянаж байгааг нарийн ялгаж зааж өгсөн байх шаардлагатай.

БАЙГАЛЬ ОРЧИН ЯАМ
ХУУЛБАРТНЭН
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛ
ЭХ ХУУ
Сайд
дарын 26

4.3.3.2 **Зөвлөмж** - *ХБЗ-ын дагуух АБХ-ыг хүн тодорхойлдог бол мэдээлэх утгад өөрчлөлт гарсан тохиолдолд (3.2.2 a), эсхүл b)-д зааснаас бусад тохиолдолд) ХБЗ-ын дагуух АБХ-ыг (RVR) тухайн газрын НХҮ-ний нэгжид мэдээлнэ. Ажиглалтыг хийснээс хойш 15 секундийн дотор дамжуулна.*

4.3.4 Дундажлах (Averaging)

ХБЗ-ын дагуух АБХ-ыг хэмжихдээ автомат төхөөрөмжийн систем ашигладаг бол бодит тодорхойлогч утгыг авахын тулд тэдгээрийн мэдээллийн гаралтын хугацаа нь хамгийн багадаа 60 секунд тутамд шинэчлэгдэх ёстой. ХБЗ-ын дагуух АБХ-ын хугацааг дараах байдлаар дундажлана. Үүнд:

a) тухайн газрын байнгын болон тусгай мэдээнд болон НХҮ-ний нэгжид АБХ-ыг үзүүлж байгаа дэлгэцүүдэд 1 минутаар;

b) хэрэв 10 минутын хугацаанд өмнөх ажиглалттай харьцуулахад ХБЗ-ын дагуух АБХ илт тогтворгүй болсон тохиолдолд, дундаж утгыг авахдаа тогтворгүй болсон хугацааны дараах тохиолдлыг л ашиглах бөгөөд дээрх тохиолдол ажиглагдаагүй үед METAR, SPECI-д 10 минутаар.

Тайлбар. ХБЗ-ын дагуух АБХ гэнэт тогтвортой өөрчлөгдөж хамгийн багадаа 2 минутын хугацаанд 800м, 550м, 300м, болон 175м-ийн утгуудад хүрч муудахад мэдэгдэхүйц тасалдал үүсдэг.

4.3.5 ХБЗ-ын гэрлийн хүч (Runway light intensity)

Зөвлөмж - *ХБЗ-ын дагуух АБХ-ыг үнэлэхдээ автомат төхөөрөмжийн систем ашигладаг бол ХБЗ болгон дээр тусад нь тооцоог хийнэ. Тухайн газрын байнгын болон тусгай мэдээнд тооцоог дараах гэрлийн хүчийг ашиглан ойролцоогоор дараах байдлаар бодно. Үүнд:*

a) ХБЗ-д ашиглаж буй гэрлийн хүч нь гэрэл асаалттай болон боломжит хамгийн их хүчнээс 3%-иас их байна;

b) ХБЗ-д зонхилох үйл ажиллагааны нөхцөлд ашиглахад зориулсан гэрэл нь асаалттай болон хамгийн их гэрлийн хүч нь 3%-аас бага байхаар бол тохиромжтой гэрлийн хүчийг ашиглана;

c) гэрэл нь унтраалттай ХБЗ-д: гэрлийн хүч (агаарын хөлгийг хүлээн авахад зориулсан сулавтар түвшинд тохируулсан гэрлийн хүч)-ийг зонхилох нөхцөлд ашиглахад зориулсан тохиромжтой гэрлийн хүчээр METAR, SPECI-д ХБЗ дээр байрласан гэрлийн хүчний байж болох хамгийн дээд чадал дээр үндэслэн ХБЗ-ын дагуух АБХ-ын зайг мэдээлнэ.

Тайлбар. Багажийн заалтыг ХБЗ-ын дагуух АБХ-ын зай руу хөрвүүлэх зааврыг Конвенцын Хавсралт 3-ын Attachment D-д заасны дагуу Нэмэлт D-д тусгасан болно.

4.3.6 Мэдээлэх (Reporting)

4.3.6.1 Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д ХБЗ-ын дагуух АБХ-ыг мэдээлэхдээ ХБЗ-ын дагуух АБХ 400м-ээс доош бол 25м-ийн зайцтайгаар, 400м-ээс 800м хүртэл бол 50м-ийн зайцтайгаар, 800м-ээс дээш бол 100м-ийн зайцтайгаар тус тус мэдээлнэ. Уг өгөгдлийн хуваарийг ашиглан мэдээлэхэд тохиромжгүй бол ажиглалтын хэмжилтийг ойролцоо бага утгад шилжүүлж авна.

4.3.6.2 **Зөвлөмж** - *ХБЗ-ын дагуух АБХ-ын хамгийн бага хэмжээг 50м, харин хамгийн их хязгаарыг 2000м-р тооцно. Тухайн газрын байнгын*

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
Бүртгэлийн дугаар 607
ХҮЛЭЭН АВСАН ТӨЛӨВ
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
20 26 оны 01 дугаар сарын 27
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЭХ ХУВИЛ
Саид Төрийн албаны дарын 26 А/14

болон тусгай мэдээ, METAR, SPECI-д АБХ энэ хязгаарыг давсан, эсхүл доош орсон тохиолдолд ХБЗ-ын дагуух АБХ-ын зайг 50м-ээс бага, эсхүл 2000м-ээс дээш гэж мэдээлнэ.

4.3.6.3 Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д дараах байдлаар өгнө. Үүнд:

a) ХБЗ-ын дагуух АБХ-ыг үнэлэхэд ашиглаж байгаа системийн дээд хязгаарыг давсан үед тухайн газрын байнгын болон тусгай мэдээнд "ABV" гэсэн товчлолоор, METAR, SPECI-д "P" товчлолоор дээд хязгаарыг давсныг тодорхойлж мэдээлнэ;

b) ХБЗ-ын дагуух АБХ ашиглаж байгаа системийн доод хязгаараас доош орсон үед тухайн газрын байнгын болон тусгай мэдээнд "BLW" гэсэн товчлолоор, METAR, SPECI-д "M" товчлолоор доод хязгаараас доош орсныг тодорхойлж мэдээлнэ.

4.3.6.4 Тухайн газрын байнгын болон тусгай мэдээнд дараах байдлаар өгнө. Үүнд:

a) хэмжилт хийсэн нэгжийг зааж өгөх;

b) ХБЗ-ын дагуух АБХ-ыг ХБЗ-ын нэг цэгээс хийж байвал өөрөөр хэлбэл буулт хийх бүсэд хийж байвал ажиглалтын мэдээг тодорхой байршил заахгүйгээр;

c) ХБЗ-ын хэд хэдэн цэг дээр ХБЗ-ын дагуух АБХ-ын хэмжилтийг хийж байгаа бол эхлээд буулт хийх бүсийн илэрхийлэгч утгыг, дараа нь ХБЗ-ын дунд цэгийн болон төгсгөл цэгийн илэрхийлэгч утгыг зааж өгөх бөгөөд тэгэхдээ эдгээр утгуудын аль нь илэрхийлэгч утгыг агуулсан цэг болохыг тодорхойлж өгнө;

d) хэд хэдэн ХБЗ-ыг ашиглаж байгаа тохиолдолд ХБЗ тус бүрийн АБХ-ын утга бүрийг авч эдгээр утгатай харгалзах зурвасыг мэдээлнэ.

4.3.6.5 **Зөвлөмж** – *METAR, SPECI-д дараах зүйлсийг тодорхойлж өгнө. Үүнд:*

a) ХБЗ дээр ажиглалт хийсэн цэгийг мэдээлэх шаардлагагүй зөвхөн газардах бүсийг илэрхийлэгч утгыг мэдээлнэ;

b) хэд хэдэн ХБЗ дээр агаарын хөлгийн буулт үйлддэг бол газардах бүсийн ХБЗ-ын дагуух АБХ-ыг ХБЗ тус бүр дээр гэхдээ дөрвөөс илүүгүй АБХ-ын утга бүрийн харгалзах зурвасыг хамт мэдээлнэ.

4.3.6.5 **Зөвлөмж** – *ХБЗ-ын дагуух АБХ-ыг хэмжихдээ автомат төхөөрөмжийн систем ашигладаг бол METAR, SPECI-д ХБЗ-ын дагуух АБХ-ын өөрчлөлтийг мэдээлэхдээ: Хэрэв ХБЗ-ын дагуух АБХ-ын 10 минутын хугацааны хандлага нь эхний 5 минутын хугацааны дундаж утга хоёр дахь 5 минутын хугацааны дунджаас 100м, эсхүл түүнээс ихээр өөрчлөгдөж байвал 10 минутын хугацааны давтамжтайгаар өгнө. ХБЗ-ын дагуух АБХ-ын хандлага нь дээшилсэн, эсхүл буурсан хандлагыг үзүүлж байгааг харгалзан "U", эсхүл "D" товчлолыг, 10 минутын хугацааны хандлага нь илт хазайлт байхгүйг илэрхийлж байвал "N" товчлолыг тус тус хэрэглэх ба хандлагын тухай мэдээлэл байхгүй бол мэдээнд товчлол оруулах шаардлагагүй.*

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГЕРЭЭНИЙ ХЭЛТЭС
637
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
20 оны дугаар сарын

МОНГОЛ УЛСЫН
ЭЗЭМШЛИЙН ЭРХ ХУВЬ
Хуудас 26 А/14

4.4 Цаг агаарын үзэгдэл (Present weather)

4.4.1 Байршил (Siting)

Зөвлөмж - *Дараах 4.4.2.3 болон 4.4.2.4-д заасан цаг агаарын үзэгдлүүдийг автомат төхөөрөмжийн системээр ажигладаг бол мэдрүүрийг орчноо хамгийн сайн төлөөлөхүйц газар байрлуулна.*

4.4.2 Мэдээлэх (Reporting)

4.4.2.1 Тухайн газрын байнгын болон тусгай мэдээнд цаг агаарын үзэгдлүүдийг мэдээлэхдээ тухайн үзэгдлийн төрөл болон шинж чанарыг өгөх бөгөөд тэдгээрийг эрчимшлээс нь хамааруулан ангилна.

4.4.2.2 METAR, SPECI-д цаг агаарын үзэгдлүүдийг мэдээлэхдээ тухайн үзэгдлийн төрөл болон шинж чанарыг өгөх бөгөөд тэдгээрийг аэродромтой ойролцоо байдал болон эрчимшлээс нь хамааруулан ангилна.

4.4.2.3 **Зөвлөмж** – *Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д дараах цаг агаарын ажиглагдаж буй үзэгдлүүдийг тус тусын товчлол болон харгалзах шалгуурын хамт мэдээлнэ. Үүнд:*

a) хур тунадас:

жижиг мөндөр, эсхүл цасан туйлаадас GS

- *Хамгийн том мөндрийн диаметр 5мм, эсхүл түүнээс доош байвал мэдээлнэ.*

b) АБХ-ыг бууруулдаг үзэгдлүүд (усны уурын):

манан FG

4.4.2.4 **Зөвлөмж** – *Автоматаар өгөгдөх тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-ийн 4.4.2.3 а)-д орсон хур тунадасны төрлүүдийг автомат ажиглалтын систем нь тухайн хур тунадсыг тодорхойлох боломжгүй тохиолдолд UP товчлолыг хэрэглэнэ.*

4.4.2.5 Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д дараах цаг агаарын ажиглагдаж буй үзэгдлүүдийн шинж чанарыг мэдээлэх шаардлагатай тохиолдолд тэдгээрийн тус тусын товчлол болон харгалзах шалгуурыг хамтад нь мэдээлнэ. Үүнд:

дуу цахилгаан TS

- *Хур тунадастай дуу цахилгааны тухай мэдээг мэдээлэхдээ Хүснэгт Х3-1 болон А3-2-д үзүүлсэн загварын дагуу хэрэглэнэ. Өмнөх ажиглалтын 10 минутын хугацаанд аэродром дээр дуу цахилгаан, эсхүл гялбаа ажиглагдсан гэхдээ ажиглалтын хугацаанд хур тунадас ажиглагдаагүй бол "TS" товчлолыг нэмэлт тэмдэглэлгүйгээр хэрэглэнэ.*

зайрмагтсан FZ

- *Хүснэгт Х3-1 болон Х3-2-д үзүүлсэн загварын дагуу тухайн цаг агаарын үзэгдлийн төрлийн хамт зайрмагтсан усан дусал, хур тунадсыг мэдээлнэ.*
- *Тайлбар - Ажиглагч ажиглаж байгаа аэродром дээр цахилгааанжилт илрүүлэх төхөөрөмжийг нэмэлтээр*

ОЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 807
ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
Чагуу
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
26 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУУЛЬ
Сайд Төрийн
даргын 26 оны А/14

хэрэглэж болно. Автомат ажиглалтын систем бүхий аэродромд дуу цахилгаан илрүүлэх зорилгоор цахилгаанжилт илрүүлэх төхөөрөмжийн зааврыг Аэродром дээрх цаг уурын автомат ажиглалтын системийн гарын авлага (Баримт бичиг 9837) (Manual on Automatic Meteorological Observing Systems at Aerodromes (Doc 9837))-д тусгасан болно

4.4.2.6 **Зөвлөмж** – *Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д дараах цаг агаарын ажиглагдаж буй үзэгдлийн шинж чанарыг мэдээлэх шаардлагатай тохиолдолд тэдгээрийн товчлол болон харгалзах шалгуурыг хамтад нь мэдээлнэ. Үүнд*:

аадар тунадас SH
- *Хүснэгт Х3-1, Х3-2-д үзүүлсэн загварын дагуу тухайн цаг агаарын үзэгдлийн төрлийн хамт мэдээлнэ. Аэродромын ойр орчимд ажиглагдсан аадар хур тунадсыг мэдээлэхдээ (4.4.2.8-ыг үзнэ үү) VCSH товчлолыг хур тунадасны төрөл болон эрчимшлийг заахгүйгээр хэрэглэнэ.*

намын шуурга BL
- *Хүснэгт Х3-1 болон Х3-2-д үзүүлсэн загварын дагуу цаг агаарын үзэгдлийн төрлүүдээс тохирох газрын гадаргаас 2м (6ft), эсхүл түүнээс дээш өндөрт үүссэн цаг агаарын үзэгдлийг төрлийн хамт хэрэглэнэ.*

явган шуурга DR
- *Хүснэгт Х3-1 болон Х3-2-д үзүүлсэн загварын дагуу цаг агаарын үзэгдлийн төрлүүдээс газрын гадаргаас 2м (6ft) хүртэл, эсхүл түүнээс доош үүссэн цаг агаарын үзэгдлийг төрөлтэй хамт хэрэглэнэ.*

нимгэн MI
- *Газрын гадаргаас дээш 2м (6ft)-ээс нам өндөртэй.*

хэсэг бусаг BC
- *Аэродром орчмыг бүрхсэн хэсэг бусаг манан.*

Хэсэгчилсэн PR
- *Аэродромын ихэнх хэсэг мананд бүрхэгдсэн.*

4.4.2.7 **Зөвлөмж** - *Автоматаар өгөгдөх тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д 4.4.2.6-д дурдсан аадар тунадас (SH) нь конвекцын үүл байгаа эсэхийг харгалзан үзэх аргад үндэслэн тодорхойлох боломжгүй үед хур тунадасны хэмжээг SH-р тодорхойлохгүй болно.*

4.4.2.8 **Зөвлөмж** - *Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д зайлшгүй тохиолдолд аэродром орчимд ажиглагдаж буй цаг агаарын үзэгдлүүдийн эрчимшлийг дараах байдлаар мэдээлнэ. Үүнд:*

	Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ	METAR, SPECI
Сул хүчтэй	FBL	-
Дунд хүчтэй	MOD	заагчгүйгээр
Хүчтэй	HVY	+

БАЙГАЛЬ ОРЧИН, ХУР АМЬСГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
Бүртгэлийн дугаар 607
ХАВСАРЫН ҮНЭН
..... Архивч
(Албан тушаалын нэр)
.....
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дүгээр сарын 29

МОНГОЛ УЛС
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид Төрийн ... дарын 26 ... А/17

Хүснэгт Х3-1 болон Х3-2-д үзүүлсэн загварын дагуу цаг агаарын үзэгдлүүдийн төрлүүдийг ашиглана. Сул хүчтэй эрчимшлийг зөвхөн хур тунадсанд зааж өгнө.

Орчим	VC
- *Аэродромын ажиглалтын цэгээс ойролцоогоор 8 болон 16км-ийн хооронд 4.4.2.5 болон 4.4.2.6-ийн дагуу мэдээлэгдээгүй тохиолдолд Хүснэгт Х3-2-д үзүүлсэн загварын дагуу бодит цаг агаарын үзэгдлүүдийн хамт зөвхөн METAR, SPECI-д ашиглана.*	

4.4.2.9 Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д:

a) аэродром дээр болон түүний ойр орчимд нислэг үйлдэхэд нөлөөлөх бодит цаг агаарын бүрэн тодорхойлолтыг өгөх үүднээс зайлшгүй тохиолдолд 4.4.2.3 болон 4.4.2.4-д орсон бодит цаг агаарын үзэгдлүүдийн нэг, эсхүл хэд хэдэн гэхдээ хамгийн ихдээ гурван товчлолыг аэродром орчмын үзэгдэл, 4.4.2.8-д орсон эрчимшил, эсхүл 4.4.2.5 болон 4.4.2.6-д орсон шинж байдлуудын харгалзах нөхцөлүүдийн тодорхойлогчийг ашиглана.

b) аэродром орчимд ажиглагдах цаг агаарын үзэгдлүүдийг эрчимшил, шинж байдал болон үзэгдлийн төрөл гэсэн дарааллаар мэдээлнэ.

c) цаг агаарын хоёр өөр төрлийн үзэгдэл ажиглагдвал тус тусад нь эрчимшлийн хамт мэдээлнэ. Ажиглалтын хугацаанд өөр өөр төрлийн хур тунадас ажиглагдвал бүх хур тунадасны шинжийг төлөөлүүлж давамгайлах хур тунадасны эрчимшлээр эхэнд нь мэдээлнэ.

4.4.2.10 **Зөвлөмж** – *Автоматаар өгөгдөх тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д систем/ мэдрүүрт түр зуурын саатал гарсны улмаас автомат ажиглалтын систем цаг агаарын байдлыг ажиглаж чадахгүй үед цаг агаарын байдал "/ /"-тэмдэглэгээгээр бичигдэнэ.*

4.5 Үүлшил (Clouds)

4.5.1 Байршил (Siting)

Зөвлөмж – *Үүлний хэмжээ болон үүлний суурийн өндрийг хэмжихдээ автоматжуулсан системийг ашигладаг бол орчноо төлөөлж чадахуйц газарт мэдрүүрүүдийг байрлуулна. Тухайн газрын байнгын болон тусгай мэдээг мэдээлэхэд зориулж суултын нарийвчилсан оролтын төхөөрөмжтэй ХБЗ бүхий аэродромуудад эдгээр мэдрүүрүүдийг байрлуулахдаа найдвартай мэдээ авах боломжтой ХБЗ-ын суултын босго цэг дээр байрлуулна. Энэ зорилгоор мэдрүүр нь буулт хийх босго цэгээс 1200м-ээс (4000ft) багагүй зайд байрлуулна.*

4.5.2 Дэлгэц (Display)

Зөвлөмж – *Үүлний хэмжээ болон үүлний суурийн өндрийг хэмжихдээ автоматжуулсан системийг ашигладаг бол үүлний суурийн өндрийн дэлгэцүүдийг цаг уурын өртөө болон НХУ-ний нэгжүүдэд суурилуулна. Эдгээр суурилуулсан дэлгэцүүдийн мэдрүүрүүд нэг эх үүсвэрээс байх бөгөөд 4.5.1-д 607 заасны дагуу нэмэлт мэдрүүрийг байрлуулсан тохиолдолд дэлгэцэд мэдрүүр бүрийн аль бүсийг хянаж байгааг нарийн ялгаж зааж өгсөн байна.*

4.5.3 Хянах түвшин (Reference level)

Үүлний суурийн өндрийг аэродромын өндрөөс дээш авна. Нарийвчилсан оролтын төхөөрөмжийг ашигладаг ХБЗ-ын босго цэг нь аэродромын өндрөөс 15м (50ft), эсхүл түүнээс нам бол, тухайн газрын шийдвэрийн дагуу үүлний суурийн өндрийг ХБЗ-ын босго цэгтэй харьцуулж мэдээлнэ.

4.5.4 Мэдээлэх (Reporting)

4.5.4.1 **Зөвлөмж** – *Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д үүлний суурийн өндрийг мэдээлэхдээ 3000 м (10000 ft) хүртэлх өндөрт 30м (100ft) гэсэн зайцтайгаар мэдээлнэ.*

4.5.4.2 **Зөвлөмж** – *Цаг уурын болон НХҮБ хооронд байгуулсан гэрээний дагуу агаарын хөлгийн ойртолт, суултын үед аэродром дээр АБХ багассан тохиолдолд тухайн газрын байнгын болон тусгай мэдээнд үүлний суурийн өндрийг 90м (300ft) хүртэлх өндөрт 15м (50ft)-ийн зайцтайгаар, 90м (300ft)-ээс 3000м (10000ft)-ийн өндөрт 30м (100ft)-ийн зайцтайгаар, босоо чиглэлийн АБХ-ыг 90м (300ft) хүртэлх өндөрт 15м (50ft)-ийн зайцтайгаар, 90м (300ft)-ээс 600м (2000ft)-ийн хооронд 30м (100ft)-ийн зайцтайгаар мэдээлнэ.*

4.5.4.3 **Зөвлөмж** – *Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д дараах байдлаар мэдээлнэ. Үүнд:*

a) үүлний хэмжээг мэдээлэхдээ "FEW" (1-ээс 2 октант), "SCT" (3-аас 4 октант), "BKN" (5-аас 7 октант), эсхүл "OVC" (8 октант) гэсэн товчлолыг ашиглана;

b) бороо, бөөн үүл болон цамхаг хэлбэрийн үүлийг CB, TCU гэсэн товчлолыг ашиглан мэдээлнэ;

c) босоо чиглэлийн АБХ-ыг мэдээлэхдээ 600м (2000ft) хүртэлх өндөрт 30м (100ft) зайцтайгаар мэдээлнэ;

d) нислэгт нөлөөлөх үүл ажиглагдаагүй, босоо чиглэлийн АБХ хязгаарлагдаагүй боловч CAVOK товчлолыг хэрэглэхэд тохиромжгүй нөхцөлд NSC товчлолыг ашиглана;

e) хэд хэдэн давхаргын үүл ажиглагдсан, эсхүл үүлшил нь нислэгт нөлөөлөхөөр салангид хэлбэртэй үед үүлний хэмжээ болон үүлний суурийн өндрийг нам өндөртэй үүлнээс эхэлж өсөх дарааллаар, дараах шалгууртай тохируулж авна. Үүнд:

1) хамгийн нам давхаргын үүлийг хэмжээнээс хамаарахгүйгээр FEW, SCT, BKN, эсхүл OVC гэж мэдээлнэ;

2) дараагийн давхаргын үүл 2/8 хэмжээнээс их бүрхсэн бол SCT, BKN, эсхүл OVC гэж мэдээлнэ;

3) түүний дээд давхаргын үүл 4/8 хэмжээнээс их бүрхсэн бол BKN, эсхүл OVC гэж мэдээлнэ;

4) 1)-ээс 3)-т ажиглагдсан болон мэдээлэгдээгүй бороо, бөөн үүл болон цамхаг хэлбэрийн бөөн үүл ажиглагдсан бол;

f) үүлний суурийн өндөр сарнисан, сийрэгжсэн, эсхүл түргэн өөрчлөгдөж байгаа үед үүлний суурийн өндөр, түүний хэсгүүдийг мэдээлнэ;

g) үүлний салангид давхарга (масс) нь бороо, бөөн үүл болон цамхаг хэлбэрийн бороо, бөөн үүлнээс бүрдсэн үед нийт

ХЯНАЛЬ ОРЧИН, УУР
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архив г
(Албан тушаалын нэр)
Гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн
Дугтын 26 А/17

үүлний суурийн өндөр, үүлний төрлийг зөвхөн борооны бөөн үүл гэж мэдээлнэ.

Тайлбар. Цамхаг хэлбэрийн бөөн үүл нь босоо чиглэлд өргөн тархсан хөгжингүй бөөн үүл юм.

4.5.4.4 энэ зүйлийн 4.5.4.1, 4.5.4.2 болон 4.5.4.3 с)-д ажигласан утгууд нь ашиглахад тохиромжгүй тохиолдолд хэмжилтийг дараагийн ойролцоо хэмжилтийн хуваарийн бага хэмжигдэхүүнд шилжүүлж авна.

4.5.4.5 Тухайн газрын байнгын болон тусгай мэдээнд дараах зүйлсийг мэдээлнэ. Үүнд:

a) үүлний суурийн өндөр болон босоо чиглэлийн АБХ-ыг хэмжсэн нэгжийг тэмдэглэнэ;
b) хэд хэдэн ХБЗ-ыг ашиглаж байгаа тохиолдолд эдгээр ХБЗ дээрх үүлний суурийн хэмжилтийг багажийн тусламжтайгаар гүйцэтгэж байгаа бол үүлний суурийн өндрийг мэдээлэхдээ ХБЗ тус бүрийн үүлний суурийн өндрийн утга бүрийг авч эдгээр утгатай харгалзах ХБЗ зурвасыг мэдээлнэ.

4.5.4.6 **Зөвлөмж** – *Автоматчилагдсан тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д дараах байдлаар мэдээлнэ. Үүнд:*

a) автомат ажиглалтын системийн тусламжтайгаар үүлний төрлийг ажиглах боломжгүй бол үүлний бүлэг болгоны үүлний төрлийг заагч дээр "///" тэмдэглэгээг орлуулж мэдээлнэ;
b) автомат ажиглалтын систем нь үүл илрүүлээгүй тохиолдолд "NCD" товчлолыг хэрэглэнэ;
c) автомат ажиглалтын систем нь борооны бөөн үүл болон цамхаг хэлбэрийн борооны бөөн үүлийг илрүүлсэн гэхдээ үүлний суурийн өндрийг тодорхойлж чадахгүй байгаа тохиолдолд үүлний хэмжээ болон суурийн өндрийг тус бүр "///" тэмдэглэгээгээр орлуулж мэдээлнэ;
d) тэнгэр битүү, автомат систем, эсхүл мэдрүүр түр хугацаагаар ажилгүй болсон тохиолдолд босоо чиглэлийн АБХ-ыг автомат системээр тодорхойлох боломжгүй бол түүнийг "///" тэмдэглэгээгээр орлуулж мэдээлнэ.

4.6 Агаарын температур болон шүүдэр цэгийн температур (Air temperature and dew-point temperature)

4.6.1 Дэлгэц (Display)

Зөвлөмж – *Агаарын температур болон шүүдэр цэгийн температурыг хэмжихдээ автомат төхөөрөмжийн систем ашигладаг бол дэлгэцийг цаг уурын өртөө, НХҮ-ний нэгжүүдэд суурилуулна. Цаг уурын өртөө болон НХҮ-ний нэгжүүдэд суурилуулсан дэлгэцүүдийн мэдрүүр нь нэг эх үүсвэртэй байна.*

4.6.2 Мэдээлэх (Reporting)

4.6.2.1 Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д агаарын температур болон шүүдэр цэгийн температурыг Цельсийн градусын бүхэл оронгоор мэдээлнэ. 0.5°-ыг Цельсийн градусын ойролцоох дээд градуст шилжүүлж авна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХАТАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн
дарын 26 он А/17

4.6.2.2 Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д 0°-аас дооших температуруудад ялгагч тэмдэглэгээ тавина.

4.7 Агаарын даралт (Atmospheric pressure)

4.7.1 Дэлгэц (Display)

Агаарын даралтыг хэмжихдээ автомат төхөөрөмжийн систем ашигладаг бол QNH дэлгэц болон хэрэв зайлшгүй шаардлагатай бол 4.7.3.2 b)-ийн дагуу QFE дэлгэцийг цаг уурын өртөө, бүсийн НХҮ-ний нэгжүүдэд суурилуулна. Цаг уурын өртөө, бүсийн НХҮ-ний нэгжүүдэд суурилуулсан дэлгэцүүдийн мэдрүүрүүд нь нэг эх үүсвэртэй байна. 4.7.3.2 d)-д заасны дагуу QFE-ийн утгыг нэгээс олон ХБЗ-ын дэлгэцээр харуулах тохиолдолд QFE-ийн утгыг харуулсан ХБЗ-ыг тодорхойлохын тулд дэлгэцийг тодорхой тэмдэглэнэ.

4.7.2 Хянах түвшин (Reference level)

Зөвлөмж – *QFE-ийг тооцоолох хянах түвшин нь аэродромын өндөр байна. Босго цэг нь тухайн аэродромын өндрөөс 2м (7ft), эсхүл түүнээс доош нарийвчилсан оролтын төхөөрөмжгүй ХБЗ болон нарийвчилсан оролтын төхөөрөмж суурилуулсан ХБЗ-уудад хэрэв QFE-ийг мэдээлэх шаардлагатай бол тооцоолох түвшинг тухайн аэродромын босго цэгийн өндөртэй харьцуулна.*

4.7.3 Мэдээлэх (Reporting)

4.7.3.1 Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д QNH болон QFE-ийн өгөгдлийг гектопаскалийн аравны хувиар тооцох ба дөрвөн цифр ашиглаж бүхэл гектопаскалиар мэдээлнэ. Энэ хэмжилтийн хуваарийг ашиглан мэдээллийг дамжуулахад тохиромжгүй тохиолдолд хэмжилтийн утгыг ойролцоох доод бүхэл гектопаскалд шилжүүлж авна.

4.7.3.2 Тухайн газрын байнгын болон тусгай мэдээнд дараах байдлаар авна. Үүнд:

a) QNH-ийг багтаана;
b) цаг уурын болон холбогдох НХҮБ хооронд байгуулсан гэрээний дагуу, эсхүл шаардлагатай тохиолдолд хэрэглэгчдийн хүсэлтээр QFE-ийг багтаана;
c) QNH, QFE-ийн утгыг хэмжихэд хэрэглэдэг нэгжийг хамт мэдээлнэ;
d) хэрэв нэгээс дээш ХБЗ-тай үед QFE-ийн утга шаардлагатай бол ХБЗ бүрд QFE утгыг мэдээлэх бөгөөд мөн тухайн ХБЗ-ыг зааж өгнө.

4.7.3.3 METAR, SPECI-д зөвхөн QNH-ийн утгыг мэдээлнэ.

4.8 Нэмэлт мэдээлэл (Supplementary information)

4.8.1 Мэдээлэх (Reporting)

4.8.1.1 **Зөвлөмж** – *Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI-д доорх саяхан болж өнгөрсөн цаг агаарын үзэгдлүүд (тухайлбал: тогтмол мэдээ гаргасны дараа, эсхүл сүүлийн нэг цагт*

ХУЛГАЙЛАХ ЭРХИЙН ӨӨРТӨӨ ... Архивч ... Хянуулсан ... 26 ... 21 дугаар сарын 29
МОНГОЛ УЛСЫН ... ЭХ ХУВЬ ... Сайд ... 26 ... А/17

аэродром дээр ажиглалтын хугацаанд бус хугацаанд богино хугацаатайгаар ажиглагдсан цаг агаарын үзэгдлүүд)-ийг Хүснэгт Х3-1 болон Х3-2-д үзүүлсний дагуу хамгийн ихдээ гурав хүртэл бүлгээр нэмэлт мэдээлэлд багтаан мэдээлнэ. Үүнд:

- зайрмагтсан хур тунадас
- дунд хүчтэй, эсхүл хүчтэй хур тунадас (аадар тунадсыг оруулаад)
- намын цасан шуурга
- шороон шуурга, элсэн шуурга
- дуу цахилгаан
- юүлүүр хэлбэрийн үүл (Торнадо, эсхүл усан догшин хуй)
- галт уулын үнс

Тайлбар. Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага хэрэглэгчид хоорондзөвшилцөөний үндсэн дээр SPECI-ийг гаргахад саяхан болж өнгөрсөн цаг агаарын үзэгдлийн тухай мэдээлэхгүй байж болно.

4.8.1.2 **Зөвлөмж** – *Тухайн газрын байнгын болон тусгай мэдээнд цаг агаарын дараах нөхцөл байдал, эсхүл тэдгээрийн хослолыг нэмэлт мэдээлэлд багтаан мэдээлнэ. Үүнд:*

- борооны бөөн үүл	CB
- дуу цахилгаан	TS
- дунд хүчтэй, эсхүл хүчтэй сэгсрэлт	MOD TURB, SEV TURB
- салхины шилжлэг	WS
- мөндөр	GR
- хүчтэй нөөлөг салхи	SEV SQL
- дунд хүчтэй, эсхүл хүчтэй мөстөлт	MOD ICE, SEV ICE
- зайрмагтсан хур тунадас	FZDZ, FZRA
- уулын хүчтэй долгион	SEV MTW
- шороон болон элсэн шуурга	DS, SS
- намын цасан шуурга	BLSN
- юүлүүр хэлбэрийн үүл	FC

Үзэгдлийн байршлыг зааж өгнө. Шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэлд товчилсон энгийн хэллэгээр бичнэ.

4.8.1.3 **Зөвлөмж** – *Автомат ажиглалтын системээр хур тунадасны төрлийг ялгах боломжгүй тохиолдолд 4.8.1.1-д тусгагдсан саяхан болж өнгөрсөн цаг агаарын үзэгдлүүдийг автоматчилагдсан METAR, SPECI-д нэмэлтээр өгөхдөө Хүснэгт Х3-2-д заасны дагуу мэдээлнэ.*

Тайлбар. Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага хэрэглэгчид хоорондзөвшилцөөний үндсэн дээр SPECI-ийг гаргахад саяхан болж өнгөрсөн цаг агаарын үзэгдлийн тухай мэдээлэхгүй байж болно.

ЗӨВЧИЛСӨН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архив2
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2025 оны 21 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид
дагын 26 А/17

Хүснэгт Х3-1. Тухайн газрын байнгын болон тусгай мэдээний загвар

Түлхүүр: М - Заавал оруулах, мэдээ бүрийн нэг хэсэг;
О - Сонголттой оруулах;
С – шаардлагатай үед оруулах;

Тайлбар 1. Тухайн газрын байнгын болон тусгай мэдээнд орох тоон элементүүдийн хамрах хүрээ болон нарийвчлалыг Хүснэгт Х3-4-т тусгасан болно.

Тайлбар 2. Товчлолын тайлбарыг Procedures for Air Navigation Services – ICAO Abbreviations and Codes (PANS-ABC (Doc 8400))-т үзүүлсэн болно.

Бүлэг 4 -т тусгагдсан элемент	Агуулга	Загвар			Жишээ
Мэдээний төрлийг тодорхойлогч (М)	Мэдээний төрөл (М)	MET REPORT, эсхүл SPECIAL			MET REPORT SPECIAL
Байршил заагч (М)	ICAO-ийн байршил заагч (М)	nnnn			YUDO[1]
Ажиглалтын хугацаа (М)	Ажиглалт хийж буй өдөр болон цаг UTC-аар	nnnnnnZ			221630Z
Автомат мэдээг тодорхойлогч (С)	Автомат мэдээг тодорхойлогч	AUTO			AUTO
Газар орчмын салхи (М)	Элементийн нэр (М)	WIND			WIND 240/4MPS (WIND 240/8KT) WIND RWY 18 TDZ 190/6MPS (WIND RWY 18 TDZ 190/12KT) WIND VRB1MPS (WIND VRB01MPS) WIND CALM WIND VRB BTN 350/AND 050/1MPS (WIND VRB BTN 350/ AND 050/2KT) WIND 270/ABV49MPS (WIND 270/ABV99KT) WIND 120/3MPS MAX 9 MNM 2 (WIND 120/6KT MAX 18 MNM 4) WIND 020/5MPS VRB BTN 350/ AND 070/ (WIND 020/10KT VRB BTN 350/ AND 070/) WIND RWY 14R MID 140/6MPS (WIND RWY 14R MID 140/12KT) WIND RWY 27 TDZ 240/8MPS MAX 14 MNM 5 END 250/7MPS (WIND RWY 27 TDZ 240/16KT MAX 28 MNM 10 END 250/14KT)
	ХБЗ (О)[2]	RWY nn[L], эсхүл RWY nn[C], эсхүл RWY nn[R]			
	ХБЗ-ын хэсэг (О)[3]	TDZ			
	Салхины чиглэл (М)	nnn/	VRB BTN nnn/ AND nnn/ эсхүл VRB	CALM	
	Салхины хурд (М)	[ABV] n[n][n]MPS, (эсхүл [ABV] n[n]KT)			
	Хурдны хазайлт (С)[4]	MAX [ABV] nn[n] MNM n [n]			
	Чиглэлийн хазайлт (С)[5]	VRB BTN nnn/ AND nnn/	-		
	ХБЗ-ын хэсэг (О)[3]	MID			
	Салхины чиглэл (О)[3]	nnn/	VRB BTN nnn/ AND nnn/, эсхүл VRB	CALM	
	Салхины хурд (О)[3]	[ABV] n[n][n]MPS, (эсхүл [ABV] n[n]KT)			
	Хурдны хазайлт (С)[4]	MAX [ABV] nn[n] MNM n [n]			
	Чиглэлийн хазайлт (С)[5]	VRB BTN nnn/ AND nnn/	-		
	ХБЗ-ын хэсэг (О)[3]	END			
	Салхины чиглэл (О)[3]	nnn/	VRB BTN nnn/ AND nnn/, эсхүл VRB	CALM	
	Салхины хурд (О)[3]	[ABV] n[n][n]MPS, (эсхүл [ABV] n[n]KT)			
	Хурдны хазайлт (С)[4]	MAX [ABV] nn[n] MNMn[n]			
	Чиглэлийн хазайлт (С)[5]	VRB BTN nnn/ AND nnn/			

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дүгээр сарын 29

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид Төрийн дарын 26 А/17

Бүлэг 4-т тусгагдсан элемент	Агуулга	Загвар			Жишээ
АБХ (М)	Элементийн нэр (М)	VIS		C A V O K	VIS 350M CAVOK VIS 7KM VIS 10KM VIS RWY 09 TDZ 800M END 1200M VIS RWY 18C TDZ 6KM RWY 27 TDZ 4000M
	ХБЗ (О)[2]	RWY nn[L], эсхүл RWY nn[C], эсхүл RWY nn[R]			
	ХБЗ-ын хэсэг (О)[3]	TDZ			
	АБХ (М)	n[n] [n] [n]M, эсхүл n[n]KM			
	ХБЗ-ын хэсэг (О)[3]	MID			
	АБХ (0)[3]	n[n] [n] [n]M, эсхүл n[n]KM			
	ХБЗ-ын хэсэг (О)[3]	END			
	АБХ (О)[3]	n[n] [n] [n]M, эсхүл n[n]KM			
ХБЗ-ын дагуух АБХ (С)[6]	Элементийн нэр (М)	RVR			RVR RWY 32 400M RVR RWY 20 1600M RVR RWY 10L BLW 50M RVR RWY 14 ABV 2000M RVR RWY 10 BLW 150M RVR RWY 12 ABV 1200M RVR RWY12 TDZ 1100M MID ABV 1400M RVR RWY 16 TDZ 600M MID 500M END 400M RVR RWY 26 500M RWY 20 800M
	ХБЗ (С)[7]	RWY nn[L], эсхүл RWY nn[C], эсхүл RWY nn[R]			
	ХБЗ-ын хэсэг (С)[8]	TDZ			
	ХБЗ-ын дагуух АБХ (М)	[ABV ,эсхүл BLW] nn[n][n]M			
	ХБЗ-ын хэсэг (С)[8]	MID			
	ХБЗ-ын дагуух АБХ (С)[8]	[ABV, эсхүл BLW] nn[n][n]M			
	ХБЗ-ын хэсэг (С)[8]	END			
	RVR (С)[8]	[ABV, эсхүл BLW] nn[n][n]M			
Цаг агаарын үзэгдэл (С)[9, 10]	Цаг агаарын үзэгдлийн эрчимшил (С)[9]	FBL, эсхүл MOD, эсхүл HVY	-		MOD RA HWY TSRA HWY DZ FBL SN HZ FG VA MIFG HWY TSRASN FBL SNRA FBL DZ FG HWY SHSN BLSN HYY TSUP //
	Цаг агаарын үзэгдлийн төрөл болон шинж байдал (С)[9, 11]	DZ, эсхүл RA SN, эсхүл SG PL, эсхүл DS SS, эсхүл FZDZ, эсхүл FZUP[12] FC[13], эсхүл FZRA, эсхүл SHGR, эсхүл SHGS, эсхүл SHRA, эсхүл SHSN, эсхүл SHUP[12] , эсхүл TSGR, эсхүл TSGS, эсхүл TSRA, эсхүл TSSN, эсхүл TSUP[12] , эсхүл UP[12]	FG, эсхүл BR, эсхүл SA DU, эсхүл HZ FU, эсхүл VA SQ, эсхүл PO, эсхүл TS BCFG, эсхүл BLDU, эсхүл BLSA, эсхүл BLSN, эсхүл DRDU, эсхүл DRSA, эсхүл DRSN, эсхүл FZFG, эсхүл MIFG, эсхүл PRFG, эсхүл //[12]		

ГАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дүгээр сарын 29

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд
дарын 26 А/12

Бүлэг 4-т тусгагдсан элемент	Агуулга	Загвар			Жишээ
Үүлшил (М)[14]	Элементийн нэр (М)	CLD			CLD NSC CLD SCT 300M OVC 600M (CLD SCT 1000FT OVC 2000FT) CLD OBSC VER VIS 150M (CLD OBSC VER VIS 500FT) CLD BKN TCU 270M (CLD BKN TCU 900FT) CLD RWY 08R BKN 60M RWY 26 BKN 90M (CLD RWY 08R BKN 200FT RWY 26 BKN 300FT) CLD /// CB ///M (CLD /// CB ///FT) CLD /// CB 400M (CLD /// CB 1200FT) CLD NCD
	ХБЗ (О)[2]	RWY nn[L], эсхүл RWY nn[C], эсхүл RWY nn[R]			
	Үүлний хэмжээ (М), эсхүл босоо АБХ (О)[9]	FEW, эсхүл SCT, эсхүл BKN, эсхүл OVC, эсхүл ///[12]	OBSC	NSC, эсхүл NCD[12]	
	Үүлний төрөл (С)[9]	CB, эсхүл TCU ///[12]	-		
	Үүлний суурийн өндөр эсхүл босоо АБХ-ын хэмжээ (О)[9]	n[n][n][n]M, (эсхүл n[n][n][n]FT), эсхүл ///M, (эсхүл ///FT)[12]	[VER VIS n[n][n]M, (эсхүл VER VIS n[n][n][n]FT), Эсхүл VER VIS ///M, (эсхүл VER VIS ///FT)[12]		
Агаарын температур (М)	Элементийн нэр (М)	T			T17 TMS08
	Агаарын температур (М)	[MS]nn			
Шүүдэр цэгийн температур (М)	Элементийн нэр (М)	DP			DP15 DPMS18
	Шүүдэр цэгийн температур (М)	[MS]nn			
Даралтын утга (М)	Элементийн нэр (М)	QNH			QNH 0995HPA QNH 1005HPA QNH 1022HPA QFE 1001HPA QNH 0987HPA QFE RWY 18 0956HPA RWY 24 0955HPA
	QNH (М)	nnnnHPA			
	Элементийн нэр (О)	QFE			
	QFE (О)	[RWY nn[L], эсхүл RWY nn[C], эсхүл RWY nn[R]] nnnnHPA [RWY nn[L], эсхүл RWY nn[C], эсхүл RWY nn[R]] nnnnHPA			
Нэмэлт мэдээлэл	Цаг агаарын онцгой үзэгдэл (С)[9]	CB, эсхүл TS, эсхүл MOD TURB, эсхүл SEV TURB, эсхүл WS, эсхүл GR, эсхүл SEV SQL, эсхүл MOD ICE, эсхүл SEV ICE, эсхүл FZDZ, эсхүл FZRA, эсхүл SEV MTW, эсхүл SS, эсхүл DS, эсхүл BLSN, эсхүл FC[15]			FC IN APCH WS IN APCH 60M-WIND 360/13MPS WS RWY 12 REFZRA CB IN CLIMB-OUT RETSRA
	Үзэгдлийн байршил (С)[9]	IN APCH [n[n][n][n]M-WIND nnn/n[n]MPS], *эсхүл* IN CLIMB-OUT [n[n][n][n]M-WIND nnn/n[n]MPS] (IN APCH [n[n][n][n]FT-WIND nnn/n[n]KT], *эсхүл* IN CLIMB-OUT [n[n][n][n]FT-WIND nnn/n[n]KT]), *эсхүл* RWY nn[L], *эсхүл* RWY nn[C], *эсхүл* RWY nn[R]			
	Өнгөрсөн хугацааны үзэгдэл (С)[9, 10]	RERASN, эсхүл REFZDZ, эсхүл REFZRA, эсхүл REDZ, эсхүл RE[SH]RA, эсхүл RE[SH]SN, эсхүл RESG, эсхүл RESHGR, эсхүл RESHGS, эсхүл REBLSN, эсхүл RESS, эсхүл REDS, эсхүл RETSRA, эсхүл RETSSN, эсхүл			

ЦАГ АГААР ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ҮЙЛЧЛЭЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР УНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
Гарын үсэг(гарын үсгийн тайлал)
01 дугаар сарын 27

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Тэрбийн
дарын 26 А/17

Бүлэг 4-т тусгагдсан элемент	Агуулга	Загвар			Жишээ
		RETSGR, эсхүл RETSGS, эсхүл REFC, эсхүл REPL, эсхүл REUP[12] , эсхүл REFZUP[12] , эсхүл RETSUP[12] , эсхүл RESHUP[12] , эсхүл REVA, эсхүл RETS			
Хандлагын урьдчилсан мэдээ (О)[16]	Элементийн нэр (М)	TREND			TREND NOSIG
	Өөрчлөлтийн бүлэг (М) [17]	NOSIG	BECMG, эсхүл TEMPO		TREND BECMG FEW 600M (TREND BECMG FEW 2000FT)
	Өөрчлөлтийн хугацаа (С)[9]		FMnnnn, эсхүл TLnnnn эсхүл ATnnnn		TREND TEMPO 250/18MPS MAX 25 (TREND TEMPO 250/36KT MAX 50)
	Салхи (С)[9]		nnn/ [ABV] [n][n]MPS [MAX [ABV]nn[n]], (эсхүл nnn/ [ABV] n[n][n]KT [MAX [ABV]nn])		TREND BECMG AT1800 VIS 10KM NSW
	АБХ (С)[9]		VIS n[n][n][n]M эсхүл VIS n[n]KM	CAVOK	TREND BECMG TL1700 VIS 800M FG TREN BECMG FM1030 TL1130
	Цаг агаарын үзэгдлийн эрчимшил (С)[9]		FBL, эсхүл MOD, эсхүл HVY	-	NSW
	Цаг агаарын үзэгдлийн шинж байдал болон төрөл (С) [9, 10, 11]		DZ, эсхүл RA SN, эсхүл SG, PL, эсхүл DS SS, эсхүл FZDZ, эсхүл FZRA, эсхүл SHGR, эсхүл SHGS, эсхүл SHRA, эсхүл SHSN, эсхүл TSGR, эсхүл TSGS, эсхүл TSRA, эсхүл TSSN	FG, эсхүл BR, эсхүл SA, эсхүл DU, эсхүл HZ, эсхүл FU, эсхүл VA, эсхүл SQ, эсхүл PO, эсхүл FC, эсхүл TS, эсхүл BCFG, эсхүл BLDU, эсхүл BLSA, эсхүл BLSN, эсхүл DRDU, эсхүл DRSA, эсхүл DRSN, эсхүл FZFG, эсхүл MIFG, эсхүл PRFG	
	Элементийн нэр(С)[9]		CLD		
	Үүлний хэмжээ болон босоо АБХ (С)[9,14]		FEW, эсхүл SCT, эсхүл BKN, эсхүл OVC	OBSC	NSC
	Үүлний төрөл (С)[9,14]		CB, эсхүл TCU	-	
	Үүлний суурийн өндөр, эсхүл босоо АБХ-ын хэмжээ (С)[9,14] 657		n[n][n][n]M (эсхүл	VER VIS n[n][n]M,	

БАЙГАЛЬ ОРЧИН ТУР АЖЛЫГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
Бүртгэлийн №
ХУУЛБАР УНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дүгээр сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн
дарын 26 А/14

Бүлэг 4-т тусгагдсан элемент	Агуулга	Загвар				Жишээ
			n[n][n][n]FT)	(эсхүл VER VIS [n][n][n]FT)]		

Тайлбар.

1. *Зохиомол байршил.*
2. *Нэг, эсхүл хэд хэдэн ХБЗ-д зориулсан нэмэлт утга.*
3. *ХБЗ-ын 1, эсхүл хэд хэдэн хэсэгт зориулсан нэмэлт утга.*
4. *4.1.5.2 c)-д заасны дагуу оруулна.*
5. *4.1.5.2 b) 1)-т заасны дагуу оруулна.*
6. *Хэрэв АБХ, эсхүл ХБЗ-ын дагуух АБХ 1500м-ээс бага бол оруулна.*
7. *4.3.6.4 d)-д заасны дагуу оруулна.*
8. *4.3.6.4 c)-д заасны дагуу оруулна.*
9. *Тохиромжтой үед оруулна.*
10. *Нэг, эсхүл хэд хэдэн бүлэг гэхдээ 4.4.2.9 a), 4.8.1.1 болон Хавсралт 5-ын 2.2.4.3-т заасны дагуу хамгийн ихдээ 3 хүртэл бүлэг.*
11. *4.4.2.3 a)-д дурдсан хур тунадасны төрлүүдийг 4.4.2. c) болон Хавсралт 5-ын 2.2.4.1-т заасны дагуу хамтад нь оруулж болно. Хавсралт 5-ын 2.2.4.1-т заасны дагуу зөвхөн дунд хүчтэй болон хүчтэй хур тунадсыг хандлагын бүлэгт өгнө.*
12. *Хүчтэй гэдгийг Торнадо, эсхүл усан догшин хуйд ашиглана. дунд хүчтэйг газарт хүрээгүй юүлүүр хэлбэрийн үүлэнд ашиглана.*
13. *4.5.4.3 e)-д заасны дагуу хамгийн ихдээ 4 хүртэл үүлний бүлгийг оруулна.*
14. *4.8.1.2-т заасны дагуу товчилсон бичвэрийг ашиглаж болно.*
15. *Бүлэг 6-ын 6.3.2-т заасны дагуу оруулна.*
16. *Хавсралт 5-ын 2.2.1-т заасны дагуу өөрчлөлтийн бүлгийг хамгийн бага (3 бүлгээс хэтрэхгүй) байх зарчмыг баримантална.*

Хүснэгт Х3-2 METAR, SPECI-ийн загвар

Түлхүүр: М - Заавал оруулах, мэдээ бүрийн нэг хэсэг;
О - Сонголттой оруулах;
С – шаардлагатай үед оруулах;

Тайлбар 1. METAR , SPECI-д орох тоон элементүүдийн хамрах хүрээ болон нарийвчлалыг Хүснэгт Х3-5-т тусгасан болно.

Тайлбар 2. Товчлолын тайлбарыг Агаарын навигацийн үйлчилгээний Procedures for Air Navigation Services - ICAO Abbreviations and Code (PANS-ABC (Doc 8400))-д үзүүлсэн болно.

Бүлэг 4-т тусгагдсан элемент	Агуулга	Загвар		Жишээ
Мэдээний төрлийг тодорхойлогч (М)	Мэдээний төрөл (М)	METAR, METAR COR, SPECI, эсхүл SPECI COR		METAR METAR COR SPECI
Байршил заагч (М)	ICAO-ийн байршил заагч (М)	Nnnn		YUDO[1]
Ажиглалтын хугацаа (М)	Ажиглалт хийж буй өдөр болон цаг UTC-аар (М)	nnnnnnZ		221630Z
Байхгүй, эсхүл автомат мэдээг мэдээг тодорхойлогч(С)[2]	Байхгүй, эсхүл автомат мэдээг тодорхойлогч (С)	AUTO, эсхүл NIL		AUTO NIL
ХЭРЭВ МЭДЭЭ БАЙХГҮЙ БОЛ METAR-ИЙН ТӨГСГӨЛ.				
Газар орчмын салхи (М)	Салхины чиглэл (М)	Nnn	VRB	24004MPS VRB01MPS ///10MPS (24008KT) (VRB02KT)
	Салхины хурд (М)	[P]nn[n]		240//KT

Бүлэг 4-т тусгагдсан элемент	Агуулга	Загвар		Жишээ
	Хурдны хазайлт (С)[3]	G[P]nn[n]		19006MPS /////KT (19012KT) 00000MPS (00000KT) 140P49MPS (140P99KT) 12003G09MPS (12006G18KT) 24008G14MPS (24016G28KT) 02005MPS 350V070 (02010KT 350V070)
	Хэмжилтийн нэгж (М)	MPS (эсхүл KT)		
	Чиглэлийн хазайлт (С)[4]	nnnVnnn	-	
АБХ (М)	Давамгайлах, эсхүл хамгийн бага АБХ (М)[5]	Nnnn, эсхүл ////[12]	C A V O K	0350 ///// CAVOK 7000 9999 0800 2000 1200NW 6000 2800E 6000 2800
	Хамгийн бага АБХ болон түүний чиглэл (С)[6]	nnnn[N], эсхүл nnnn[NE], эсхүл nnnn[E], эсхүл nnnn[SE], эсхүл nnnn[S], эсхүл nnnn[SW], эсхүл nnnn[W], эсхүл nnnn[NW]		
ХБЗ-ын дагуух АБХ (С)[7]	Элементийн нэр (М)	R		R30/0400 R12R/1700 R10/M0050 R14L/P2000
	ХБЗ (М)	nn[L]/, эсхүл nn[C]/, эсхүл nn[R]/		R16L/0650 RC16C/0500 R16L///// R10//// R16R/0450 R17L/0450
	ХБЗ-ын дагуух АБХ (М)	[P, эсхүл M]nnnn		
	ХБЗ-ын дагуух АБХ -ын хандлага (С)[8]	U, D, эсхүл N		R12/1100U R26/0550N R20/0800D R12/0700

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР УНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
Гарын үсэг
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дүгээр сарын 29

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Санд Тэмдэг
26 А/17

Бүлэг 4-т тусгагдсан элемент	Агуулга	Загвар			Жишээ
Цаг агаарын үзэгдэл (C) [2, 9]	Цаг агаарын үзэгдлийн эрчимшил, эсхүл эргэн тойрныг илтгэгч (C)[10]	-, эсхүл +	-	VC	
	Цаг агаарын үзэгдлийн төрөл болон шинж байдал (M)[11]	DZ, эсхүл RA, эсхүл SN, эсхүл SG, эсхүл PL, эсхүл DS, эсхүл SS, эсхүл FZDZ, эсхүл FZRA, эсхүл FZUP[12], эсхүл FC[13], эсхүл SHGR, эсхүл SHGS, эсхүл SHRA, эсхүл SHSN, эсхүл SHUP[12], эсхүл TSGR, эсхүл TSGS, эсхүл TSRA, эсхүл TSSN, эсхүл TSUP[12], эсхүл UP[12]	FG, эсхүл BR, эсхүл SA, эсхүл DU, эсхүл HZ, эсхүл FU, эсхүл VA, эсхүл SQ, эсхүл PO, эсхүл TS, эсхүл BCFG, эсхүл BLDU, эсхүл BLSA, эсхүл BLSN, эсхүл DRDU, эсхүл DRSA, эсхүл DRSN, эсхүл FZFG, эсхүл MIFG, эсхүл PRFG, эсхүл //[12]	FG, эсхүл PO, эсхүл FC, эсхүл DS, эсхүл SS, эсхүл TS, эсхүл SH, эсхүл BLSN, эсхүл BLSA, эсхүл BLDU, эсхүл VA	RA HZ VCFG +TSRA FG VCSH +DZ VA VCTS -SN MIFG VCBLSA +TSRASN -SNRA DZ FG +SHSN BLSN UP FZUP TSUP FZUP //
Үүлшил (M)[14]	Үүлний хэмжээ болон суурийн өндөр, эсхүл босоо АБХ (M)	FEWnnn, эсхүл SCTnnn, эсхүл BKNnnn, эсхүл OVCnnn, эсхүл FEW///[12], *эсхүл* SCT///[12], *эсхүл* BKN///[12], *эсхүл* OVC///[12], *эсхүл* ///nnn[12], *эсхүл* //////[12]	VVnnn, эсхүл VV///[12]	NSC, эсхүл NCD[12]	FEW015 VV005 NSC OVC030 VV/// NSC SCT010 OVC020 BKN/// ///015 BKN009TCU NCD SCT008 BKN025CB BKN025/// ///CB
	Үүлний төрөл (C)[2]	CB эсхүл TCU эсхүл ///[12]	-		
Агаарын болон шүүдэр цэгийн температур (M)	Агаарын болон шүүдэр цэгийн температур (M)	[M]nn/[M]nn эсхүл ///[M]nn[12] эсхүл [M]nn///[12] эсхүл /////[12]			17/10 ///10 17/// ///// 02/M08 M01/M10
Даралтын утга (M)	Элементийн нэр (M)	Q			Q0995 Q1009 Q1022 Q0987
	QNH (M)	Nnnn			

ХУУЛБАР ҮНЭН
Архив
(албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид Төрийн
Даргын 06 А/17

Бүлэг 4-т тусгагдсан элемент	Агуулга	Загвар				Жишээ
Нэмэлт мэдээлэл (C)	Өнгөрсөн хугацааны үзэгдэл (C) [2, 9]	RERASN, эсхүл REFZDZ, эсхүл REFZRA, эсхүл REDZ, эсхүл RE[SH]RA, эсхүл RE[SH]SN, эсхүл RESG, эсхүл RESHGR, эсхүл RESHGS, эсхүл REBLSN, эсхүл RESS, эсхүл REDS, эсхүл RETSRA, эсхүл RETSSN, эсхүл RETSGR, эсхүл RETSGS, эсхүл RETS, эсхүл REFC, эсхүл REVA, эсхүл REPL, эсхүл REUP[12], эсхүл REFZUP[12], эсхүл RETSUP[12], эсхүл RESHUP[12]				REFZRA RETSRA
	Салхины шилжлэг (C) [2]	WS Rnn[L], эсхүл WS Rnn[C], эсхүл WS Rnn[R], эсхүл WS ALL RWY				WS R03 WS ALL RWY WS R18C
	Далайн гадаргын температур болон түүний төлөв байдал, эсхүл долгионы өндөр (C)[15]	W[M]nn/Sn, эсхүл W///Sn ,эсхүл W[M]nn/S/, эсхүл W[M]nn/Hn[n][n], эсхүл W///Hn[n][n], эсхүл W[M]nn/H///				W15/S2 W12/H75 W///S3 WM01/S/ W///H104 W17/H/// W///H/// W///S/
Хандлагын урьдчилсан мэдээ (O)[17]	Өөрчлөлтийн заагч (M) [17]	N O S I G	BECMG, эсхүл TEMPO			NOSIG BECMG FEW020 TEMPO 25018G25MPS (TEMPO 25036G50KT)
	Өөрчлөлтийн хугацаа (C) [2]		FMnnnn, эсхүл TLnnnn, эсхүл ATnnnn			
	Салхи (C)[2]		nnn[P]nn[n][G[P]nn[n]]MPS, (эсхүл nnn[P]nn[n][G[P]nn[n]]KT)			
	Давамгайлах АБХ (C)[2]		nnnn		C A V O K	BECMG FM1030 TL1130 CAVOK
	Цаг агаарын үзэгдлийн эрчимшил (C)[10]		- эсхүл +	-	NSW	BECMG TL1700 0800 FG
	Цаг агаарын үзэгдлийн шинж байдал болон төрөл (C) [2, 9, 11]		DZ, эсхүл RA SN, эсхүл SG PL, эсхүл DS SS, эсхүл FZDZ, эсхүл FZRA, эсхүл SHGR, эсхүл SHGS, эсхүл SHRA, эсхүл SHSN, эсхүл TSGR, эсхүл TSGS, эсхүл TSRA, эсхүл TSSN	FG BR, эсхүл SA DU, эсхүл HZ FU, эсхүл VA SQ, эсхүл PO FC, эсхүл TS BCFG, эсхүл BLDU, эсхүл BLSA, эсхүл BLSN, эсхүл DRDU, эсхүл DRSA, эсхүл DRSN, эсхүл FZFG,эсхүл MIFG, эсхүл PRFG		BECMG FM1800 9000 NSW BECMG FM1900 0500 +SNRA BECMG FM1100 SN TEMPO FM1130 BLSN TEMPO FM0330 TL0430 FZRA TEMPO TL1200 0600 BECMG AT1200 8000 NSW NSC BECMG AT1130 OVC010 TEMPO TL1530 +SHRA BKN012CB
	Үүлний хэмжээ, суурийн өндөр, эсхүл босоо АБХ (C) [2, 14]		FEWnnn, эсхүл SCTnnn, эсхүл BKNnnn, эсхүл OVCnnn	VVnnn, эсхүл VV///	NSC	
	Үүлний төрөл (C) [2,14]		CB, эсхүл TCU	-		

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР УНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
26 оны 01 дүгээр сарын 29

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Гарын 26 А/14

Тайлбар.

1. *Зохиомол байршил.*
2. *Тохиромжтой үед оруулна.*
3. *4.1.5.2 c)-д заасны дагуу оруулна.*
4. *4.1.5.2 b) 1)-т заасны дагуу оруулна.*
5. *4.2.4.4. b)-д заасны дагуу оруулна.*
6. *4.2.4.4. a)-д заасны дагуу оруулна.*
7. *АБХ, эсхүл ХБЗ-ын дагуух АБХ 1500 м-ээс бага бол дээд тал нь дөрөв хүртэлх ХБЗ-ын хувьд 4.3.6.5. b)-д заасны дагуу оруулна.*
8. *4.3.6.6-д заасны дагуу оруулна.*
9. *Нэг, эсхүл хэд хэдэн бүлэг гэхдээ 4.4.2.9 a), 4.8.1.1 болон Хавсралт 5-ын 2.2.4.1-т заасны дагуу хамгийн ихдээ 3 хүртэл бүлэг.*
10. *Тохиромжтой үед оруулна. 4.4.2.8-д заасны дагуу дунд зэргийн хүчтэйг тэмдэггүй оруулна.*
11. *4.4.2.3 a)-д дурдсан хур тунадасны төрлүүдийг 4.4.2.9 c) болон Хавсралт 5-ын 2.2.4.1-т заасны дагуу хамтад нь оруулж болно.*
12. *Зөвхөн автомат мэдээнд.*
13. *Хүчтэй гэдгийг Торнадо, эсхүл усан догшин хүйд ашиглана. Дунд хүчтэйг газарт хүрээгүй юүлүүр хэлбэрийн үүлэнд ашиглана.*
14. *4.5.4.3 e)-д заасны дагуу хамгийн ихдээ 4 хүртэл үүлний бүлгийг оруулна.*
15. *4.8.1.5 a)-д заасны дагуу оруулна.*
16. *4.8.1.5 b)-д заасны дагуу оруулна.*
17. *Бүлэг 6-ын 6.3.2-т заасны дагуу оруулна.*
18. *Хавсралт 5-ын 2.2.1-т заасны дагуу өөрчлөлтийн бүлгийг хамгийн бага (3 бүлгээс хэтрэхгүй) байх зарчмыг баримантална.*

Хүснэгт Х3-3. Хандлагын урьдчилсан мэдээнд өөрчлөлт заагчийг ашиглах

Өөрчлөлт заагч	Хугацаа заагч	Утга	
NOSIG	-	Урьдчилсан мэдээнд өөрчлөлт байхгүй	
BECMG	FM $n_1n_1n_1n_1$TL$n_2n_2n_2n_2$	Урьдчилан мэдээлж буй өөрчлөлт нь	$n_1n_1n_1n_1$ (UTC) хугацаанд эхэлж, $n_2n_2n_2n_2$ (UTC) хугацаанд дуусна.
	TLnnnn		Хандлагын урьдчилсан мэдээний эхлэх хугацаанд эхэлж, nnnn (UTC) хугацаанд дуусна
	FMnnnn		nnnn хугацаанд эхэлж, хандлагын урьдчилсан мэдээний төгсөх хугацаанд дуусна.
	ATnnnn		Nnnn (UTC) хугацаанд ажиглагдана. (тусгай цаг)
	-		а) Хандлагын урьдчилсан мэдээний эхлэх хугацаанд эхэлж, төгсөх хугацаанд дуусна. б) Өөрчлөлт ажиглагдах хугацаа нь тодорхойгүй.
TEMPO	FM $n_1n_1n_1n_1$ TL$n_2n_2n_2n_2$	Урьдчилан мэдээлж буй өөрчлөлт нь хэлбэлзэлтэй өөрчлөлт нь	$n_1n_1n_1n_1$ (UTC) хугацаанд эхэлж, $n_2n_2n_2n_2$ (UTC) хугацаанд дуусна.
	TLnnnn		Хандлагын урьдчилсан мэдээний эхлэх хугацаанд эхэлж, nnnn (UTC) хугацаанд зогсоно.
	FMnnnn		Nnnn (UTC) хугацаанд эхэлж, хандлагын урьдчилсан мэдээний төгсөх хугацаанд зогсоно.
	-		Хандлагын урьдчилсан мэдээний эхлэх хугацаанд эхэлж, төгсөх хугацаанд зогсоно.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХҮЛЭЭЖ АВСАН
Архивч
(албан тушаалын нэр)
Канцер
(гарын үсэг/цахим үсгийн тайлбар)
2026 оны 01 дүгээр сарын 27

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид Төрийн ... албан ...
Дарын 26

Хүснэгт Х3-4. Тухайн газрын мэдээний тоон элементийн хамрах хүрээ болон нарийвчлал

Бүлэг 4-т тусгагдсан элемент		Хамрах хүрээ	Нарийвчлал
ХБЗ:		01-36	1
Салхины чиглэл:	°градус	010-360	10
Салхины хурд:	MPS KT	00-99* 00-199*	1 1
АБХ:	 M M M M	0000-0750 0800-4900 5000- 9000 10000-	50 100 1000 0(9999)
ХБЗ-ын дагуух АБХ:	M M M	0000-0375 0400-0750 0800-2000	25 50 100
Босоо чиглэлийн АБХ:	30's M (100's FT)	000-020	1
Үүлний суурийн өндөр:	30's M (100's FT)	000-100	1
Агаарын болон шүүдэр цэгийн температур:	°C	-80-+60	1
QNH:	hPa	0850-1100	1

Хүснэгт Х3-5. METAR, SPECI мэдээний тоон элементийн хамрах хүрээ болон нарийвчлал

Бүлэг 4-т тусгагдсан элемент		Хамрах хүрээ	Нарийвчлал
ХБЗ:		01-36	1
Салхины чиглэл:	°градус	010-360	10
Салхины хурд:	MPS KT	00-99* 00-199*	1 1
АБХ:	 M M M M	0000-0750 0800-4900 5000- 9000 10000-	50 100 1000 0(9999)
ХБЗ-ын дагуух АБХ:	M M M	0000-0375 0400-0750 0800-2000	25 50 100
Босоо чиглэлийн АБХ:	30's M (100's FT)	000-020	1
Үүлний суурийн өндөр:	30's M (100's FT)	000-100	1
Агаарын болон шүүдэр цэгийн температур:	°C	-80-+60	1
QNH:	hPa	0850-1100	1
Далайн гадаргын температур:	°C	-10-+40	
Далайн төлөв байдал:		0-9	
Далайн давлагааны өндөр:	M		

* 50 м/с (100kt), эсхүл түүнээс дээш газар орчмын салхины хурдыг мэдээлэх агаарын навигацийн шаардлага байхгүй, гэхдээ шаардлагатай бол агаарын навигацийн бүс зорилгоор 99 м/с (199 kt) хүртэлх салхины хурдыг мэдээлэх зохицуулалтыг хийсэн болно.

ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(албан тушаалын нэр)
Цагаан
(гарын үсэг)(гэрэн үсгийн тайлал)
26 01 оны 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид Төрийн
даргын 26 А/17

Жишээ Х3-1. Байнгын мэдээ

a) Тухайн газрын байнгын мэдээ (ижил байршил болон цаг агаарын нөхцөл METAR-тай адил):
MET REPORT YUDO 221630Z WIND 240/4MPS VIS 600M RVR RWY 12 TDZ 1000M MOD DZ FG CLD SCT 300M OVC 600M T17 DP16 QNH 1018HPA TREND BECMG TL1700 VIS 800M FG BECMG AT1800 VIS 10KM NSW

b) YUDO-ийн METAR (Donlon/International)*:
METAR YUDO 221630Z 24004MPS 0600 R12/1000U DZ FG SCT010 OVC020 17/16 Q1018 BECMG TL1700 0800 FG BECMG AT1800 9999 NSW

Дээрх хоёр мэдээний утга:
Donlon*/Олон улсын нисэх буудлын байнгын мэдээ тухайн сарын 22-ны өдөр 1630 (UTC-цагаар) цагт гаргасан. Газар орчмын салхины чиглэл 240°, салхины хурд 4м/с, АБХ (ХБЗ-ын дагуу тухайн газрын байнгын METAR мэдээнд давамгайлах АБХ) 600м, ХБЗ-ын дагуух АБХ-зурвас 12 талын газардах бүсэд 1000м, ХБЗ-ын дагуух АБХ өмнөх 10 минутын хугацаанд өсөх хандлагатай байна,(ХБЗ-ын дагуух АБХ-ын хандлага зөвхөн METAR-д), дунд хүчтэй болон шиврээ бороо болон манан, 300м-ийн өндөртэй SCT, 600м-ийн өндөртэй OVC хэмжээний үүл, агаарын температур 17°C, шүүдэр цэгийн температур 16°C, QNH 1018гПа. Дараагийн 2 цагийн хандлага: АБХ 1700 (UTC) цагт манангаас шалтгаалж 800м, 1800 (UTC) цагт 10км, эсхүл түүнээс их болох бөгөөд цаг агаарын үзэгдэлгүй болно.

*- Зохиомол байршил

Тайлбар. Энэ жишээнд хэмжих нэгж "м/с" болон "метр"-ийг салхины хурд болон үүлний суурийн өндрийг хэмжихэд ашигласан болно. Конвенцын Хавсралт 5-д заасны дагуу оронд нь "kt" болон "ft" гэсэн өөр нэгжүүдийг ашиглаж болно.

Жишээ Х3-2. Тусгай мэдээ

a) Тухайн газрын тусгай мэдээ (ижил байршил болон цаг агаарын нөхцөл SPECI-тай адил):
SPECIAL YUDO 151115Z WIND 050/25KT MAX37 MNM10 VIS 1200M RVR RWY 05 ABV 1800M HVY TSRA CLD BKN CB 500FT T25 DP22 QNH 1008HPA TREND TEMPO TL1200 VIS 600M BECMG AT1200 VIS 8KM NSW NSC

b) SPECI for YUDO (Donlon/ International)*:
SPECI YUDO 151115Z 05025G37KT 3000 1200NE+TSRA BKN005CB 25/22 Q1008 TEMPO TL1200 0600 BECMG AT1200 8000 NSW NSC

Дээрх хоёр мэдээний утга:
Donlon/Олон улсын нисэх буудлын* тусгай мэдээ тухайн сарын 15-ны өдрийн 1115 (UTC) цагт гаргасан. Газар орчмын салхины чиглэл 050°, салхины хурд 25kt, өрөвхийлөлт 10-аас 37kt-ийн хооронд, (SPECI-д хамгийн бага салхины хурд багтаагүй), АБХ 1200м (тухайн газрын тусгай мэдээнд зурвасын дагуу), хамгийн бага АБХ 1200м баруун хойноос (SPECI-д зөвхөн чиглэлийн хазайцыг өгнө) бүхий давамгайлах АБХ 3000м (SPECI-д), ХБЗ-ын дагуух АБХ 1800м-ээс дээш, зурвас 05-д (давамгайлах АБХ 3000м бүхий SPECI-д ХБЗ-ын АБХ шаардлагагүй), аадар борооТой дуу цахилгаан, 500ft өндөртэй BKN хэмжээтэй бороОны бөөн үүл, агаарын температур 25°C, шүүдэр цэгийн температур 22°C, QNH 1008гПа. Дараагийн хоёр цагийн хандлага: АБХ (SPECI-д давамгайлах АБХ, тухайн газрын тусгай мэдээнд зурвасын дагуу)1115-1200 (UTC) цагт түр зуур 600м, 1200 (UTC) цагт АБХ 8км, дуу цахилгаан, цаг агаарын үзэгдэл болон нөлөөлөхүйц үүлгүй болно.

*-Зохиомол байршил

Тайлбар. Энэ жишээнд хэмжих нэгж "kt" болон "ft"-ийг салхины хурд болон үүлний суурийн өндрийг хэмжихэд ашигласан болно. Конвенцын Хавсралт 5-д заасны дагуу оронд нь "м/с" болон "метр" гэсэн нэгжүүдийн ашиглаж болно.

Жишээ Х3-3. Галт уулын идэвхжилийн мэдээ

VOLCANIC ACTIVITY REPORT YUSB* 231500 MT TROJEEN* VOLCANO N5605 W12652 ERUPTED 231445 LARGE ASH CLOUD EXTENDING TO APPROX 30000 FEET MOVING SW

Утга - Галт уулын идэвхжилийн мэдээ Siby/Bistock цаг уурын өртөөн дээр тухайн сарын 23-нд 1500 (UTC) цагт гаргасан. Mt. Trojeen галт уул 56°5′N зүгт 126°52′W зүгт ойролцоогоор 30000ft хүртэл үргэлжилсэн үнсэн үүл баруун өмнө зүгт хөдөлж байгааг ажиглав.

*- Зохиомол байршил.

ЦЕРЧИЛ, УУР АМЬСГАЛЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архив
(Албан тушаалын нэр)
Чанцал
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Дарын 26 А/17

Хавсралт 4. Агаарын хөлгийн ажиглалт болон мэдээтэй холбоотой техникийн үзүүлэлт (Technical specifications related to aircraft observations and reports)

(Бүлэг 5-ыг үзнэ үү)

1. АГААРЫН ХӨЛГИЙН МЭДЭЭНИЙ АГУУЛГА (CONTENTS OF AIR-REPORTS)

1.1 Агаар-газрын өгөгдлийн холбоогоор дамжуулах агаарын хөлгийн байнгын мэдээ (Routine air-reports by air-ground data link)

1.1.1 Автомат хамааралтай ажиглалт-гэрээгээр (ADS-C), эсхүл SSR Mode S ашиглан агаар-газрын өгөгдлийн холбоогоор дамжуулах агаарын хөлгийн байнгын мэдээ нь дараах агуулгатай байна. Үүнд:

Мэдээний төрлийг заагч
Агаарын хөлгийн ялгах тэмдэг

Data block 1
- өргөрөг
- уртраг
- түвшин
- хугацаа

Data block 2
- салхины чиглэл
- салхины хурд
- салхины дарцаг
- агаарын температур
- сэгсрэлт (хэрэв боломжтой бол)
- чийгшил (хэрэв боломжтой бол)

Тайлбар. ADS-C, эсхүл SSR Mode S-ийг ашиглах үед агаарын хөлгийн байнгын мэдээний шаардлагыг үндсэн ADS-C/SSR Mode S data block (data block 1) болон цаг уурын data block (data block 2) хослуулан хангаж болно. ADS-C мэдээний форматыг PANS-ATM (Doc 4444)-ийн 4.11.4, Chapter 13 болоне SSR Mode S message format is specified in Конвенцын Хавсралт 10-ын Volume III-ын Part I-ийн Chapter 5-д тус тус заасан болно.

1.1.2 ADS-C болон SSR Mode S-ийг ашиглаагүй үед агаар-газрын өгөгдлийн холбоог ашиглаж байнгын мэдээнд дараах элементүүд агуулагдана. Үүнд:

Мэдээний төрлийг заагч

1-р хэсэг (байршлын мэдээлэл)
- агаарын хөлгийн ялгах тэмдэг
- байршил, эсхүл өргөрөг, уртраг, хугацаа
- нислэгийн түвшин, эсхүл өндөр
- дараагийн байршил болон хугацаа дуусах
- дараагийн нөлөөлөх цэг

2-р хэсэг (үйл ажиллагааны мэдээлэл)
- нисэн ирэх тооцоот цаг

ЗӨВЛӨВ ҮНЭН
607
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сэнд Төрийн ... сийлгийн
дарын 26 оны А/17 ...

нислэгийн хугацаа

3-р хэсэг (цаг уурын мэдээлэл)
агаарын температур
салхины чиглэл
салхины хурд
сэгсрэлт
агаарын хөлгийн мөстөлт
чийгшил (хэрэв боломжтой бол)

Тайлбар. ADS-C болон SSR Mode S-ийг ашиглаагүй үед агаар-газрын data link-ийг ашиглаж байгаа бол агаарын хөлгийн байнгын мэдээний шаардлагыг "Байршлын мэдээ" нэртэй controller-pilot өгөгдлийн холболтын хэрэглүүр (CPDLC) хангаж болно. Энэхүү өгөгдлийн холбооны хэрэглээний дэлгэрэнгүй мэдээллийг Manual of Air Traffic Services Data Link Applications (Doc 9694) болон Конвенцын Хавсралт 10-ын Volume III-ын Part I-д заасан болно.

1.2 Агаар-газрын өгөгдлийн холбоогоор дамжуулах агаарын хөлгийн тусгай мэдээ (Special air-reports by air-ground data link)

Агаар-газрын холбоогоор дамжуулах тусгай мэдээ дараах агуулгатай байна. Үүнд:

Мэдээний төрлийг заагч
Агаарын хөлгийн ялгах тэмдэг

Data block 1
өргөрөг
уртраг
түвшин
хугацаа

Data block 2
салхины чиглэл
салхины хурд
салхины дарцаг
агаарын температур
сэгсрэлт (хэрэв боломжтой бол)
чийгшил (хэрэв боломжтой бол)

Data block 3
нөхцөл бүрдсэн үед агаарын хөлгийн тусгай мэдээ (Конвенцын Хавсралт 3-ын Appendix 4-т заасны дагуу Хүснэгт Х4-1-т үзүүлснээс нэг нөхцөл сонгогдсон).

Тайлбар 1. Агаарын хөлгийн тусгай мэдээний шаардлагуудын "Агаарын хөлгийн тусгай мэдээний үйлчилгээ"-г data link flight information service (D-FIS) программ хангаж болно. Энэхүү data link application-г (Doc 9694)-д заасан болно.

Тайлбар 2. Галт уулын дэлбэрэлтийн өмнөх идэвхжил, галт уулын дэлбэрэлт, эсхүл галт уулын үнсэн үүлний тухай агаарын хөлгийн тусгай мэдээний нэмэлт шаардлагуудыг 4.2-т тусгасан болно.

1.3 Дуут холбоогоор дамжуулах агаарын хөлгийн тусгай мэдээ (Special air-reports by voice communications)

Дуут холбоог ашиглаж байгаа үед агаарын хөлгийн тусгай мэдээ дараах элементүүдийг агуулна. Үүнд:

Мэдээний төрлийг заагч
1-р хэсэг (байршлын мэдээлэл)
агаарын хөлгийн ялгах тэмдэг
байршил, эсхүл өргөрөг, уртраг
хугацаа
нислэгийн түвшин, эсхүл өндөр

3-р хэсэг (цаг уурын мэдээлэл)
нөхцөл бүрдсэн үед агаарын хөлгийн тусгай мэдээг Хүснэгт X4-1-ийн дагуу мэдээлнэ.

Тайлбар 1. Агаарын хөлгийн байнгын мэдээг тогтмол гэж үзнэ. Тусгай мэдээний төрлийг тодорхойлогчийг PANS-ATM (Doc 4444)-ийн Appendix 1-д тусгасан болно.

Тайлбар 2. Галт уулын дэлбэрэлтийн өмнөх идэвхжил, галт уулын дэлбэрэлт, эсхүл галт уулын үнсэн үүлний тухай тусгай мэдээний нэмэлт шаардлагуудыг 4.2-т тусгасан болно.

2. МЭДЭЭЛЭХ ШАЛГУУР (CRITERIA FOR REPORTING)

2.1 Нийтлэг үндэслэл (General)

Агаар-газрын өгөгдлийн холбоог ашиглаж байгаа тохиолдолд салхины чиглэл, хурд, салхины дарцаг, агаарын температур, сэгсрэлт болон чийгшлийн тухай мэдээллүүдийг багтаасан агаарын хөлгийн мэдээг дараах шалгуурын дагуу дамжуулна.

2.2 Салхины чиглэл (Wind direction)

Салхины чиглэлийг ойролцоох бүхэл аравтын оронд шилжүүлж, градусаар илэрхийлнэ.

2.3 Салхины хурд (Wind speed)

Салхины хурдыг секундэд метрээр, эсхүл knots (kt)-р илэрхийлнэ. Ашигласан хэмжилтийн нэгжийг мэдээнд зааж өгнө.

2.4 Салхины дарцаг (Wind quality flag)

Салхины дарцгийн өнцөг 5°-аас бага бол 0, эсхүл 5° ба түүнээс их бол 1 гэж мэдээлнэ.

2.5 Агаарын температур (Air temperature)

Температурыг Цельсийн градусаар, аравны нарийвчлалтай өгнө.

2.6 Сэгсрэлт (Turbulence)

Сэгсрэлтийн тухай мэдээллийг сэгсрэлт замхрах үеийн хурд (EDR)-ээс куб язгуур гаргасан нэгжээр мэдээлнэ.

Тайлбар. EDR нь агаарын хөлгийн бие даасан сэгсрэлтийн хэмжилт юм. Гэсэн хэдий ч EDR утга ба сэгсрэлт хоорондын хамаарал нь агаарын хөлгийн төрөл, масс, өндөр, агаарын урсгалын хурд, тохиргоо зэргээс хамаарна. EDR утга нь байнгын нислэгийн чиглэлийн нөхцөлд (өвөрөөр хэлбэл: өндөр, агаарын хурд, жин) дунд оврын агаарын хөлгийн хүндийн түвшнийг тодорхойлсон болно.

ХУУЛБАР ҮНЭН
Архив2
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
20 26 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Хуудас 110
26 А/17

2.6.1 Агаарын хөлгийн байнгын мэдээ (Routine air-reports)

Агаарын сэгсрэлтийн тухай мэдээллийг нислэгийн явцад өгөх ба ажиглалтын өмнөх 15 минутад хамаарна. Сэгсрэлтийн дундаж ба их утгыг хянаж, хамгийн их утгадаа хүрсэн хугацааг минутын нарийвчлалтай тодорхойлно. Дундаж болон их утгыг EDR-ээс куб язгуур гаргасан нэгжээр мэдээлнэ. Өндөр авах үед сэгсрэлтийн тухай мэдээллийг нислэгийн эхний 10 минутад өгөх ба ажиглалтын өмнөх 30 секундийн хугацаанд хамаарна. Сэгсрэлтийн хамгийн их утгыг тасралтгүй хянана.

2.6.2 Сэгсрэлтийн мэдээний тайлбар (Interpretation of the turbulence report)

Сэгсрэлтийг дараах байдлаар тооцно. Үүнд:

a) хүчтэй гэж EDR-ээс куб язгуур гаргасан хамгийн их утга нь 0.45-тай тэнцүү, эсхүл давж байвал;
b) дунд хүчтэй гэж EDR-ээс куб язгуур гаргасан хамгийн их утга нь 0.20-оос их, 0.45-аас бага, эсхүл тэнцүү бол;
c) сул хүчтэй гэж EDR-ээс куб язгуур гаргасан хамгийн их утга нь 0.10-аас их, 0.20-оос бага, эсхүл тэнцүү бол;
d) тэг утгатай гэж EDR-ээс куб язгуур гаргасан хамгийн их утга нь 0.10-ээс бага, эсхүл тэнцүү байвал.

2.6.3 Агаарын хөлгийн тусгай мэдээ (Special air-reports)

Сэгсрэлтийн тухай агаарын хөлгийн тусгай мэдээг нислэгийн аль ч үед EDR-ээс куб язгуур гаргасан хамгийн их утга нь 0.20-той тэнцүү, эсхүл давахад дамжуулна. Сэгсрэлтийн тухай агаарын хөлгийн тусгай мэдээ нь өмнөх ажиглалтын 1 минутад шууд хамаарна. Сэгсрэлтийн дундаж, хамгийн их утгыг тасралтгүй хянана. Дундаж, хамгийн их утгуудыг EDR-ээс куб язгуур гаргасан нэгжээр илэрхийлж, дамжуулна.Агаарын хөлгийн тусгай мэдээг EDR-ээс куб язгуур гаргасан хамгийн их утга 0.20-ээс доош орох хүртэл минут тутамд өгнө.

2.7 Чийгшил (Humidity)

Чийгшлийг харьцангуй чийгшил гэж мэдээлэх ба бүхэл хувиар өгнө.

Тайлбар. Цаг уурын элементүүдийн хамрах хүрээ, нарийвчлалыг Конвенцын Хавсралт 3-ын, Appendix 4-д заасны дагуу Хүснэгт Х4-3-д үзүүлсэн болно.

3. АГААРЫН ХӨЛГИЙН МЭДЭЭГ СОЛИЛЦОХ (EXCHANGE OF AIR-REPORTS)

3.1 Цаг уурын байгууллагын үүрэг (Responsibilities of the meteorological watch offices)

3.1.1 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь дуут холбоогоор хүлээн авсан агаарын хөлгийн тусгай мэдээг цаг алдалгүй нисэхийн суурин холбооны интернэтэд суурилсан үйлчилгээгээр WAFCs-д болон бусад томилогдсон төвүүдэд дамжуулна.

3.1.2 Энэ заалт хамааралгүй тул орхилт хийгдсэн

3.1.3 Агаарын хөлгийн тусгай мэдээ нь нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагад ирэхэд урьдчилан мэдээлж буй инженер тухайн үзэгдлийг ажиглагдахгүй гэж үзвэл SIGMET-д

ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
Хаяа уе
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дүгээр сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВИЛ
Сайд
дарын 26 А/17

оруулахгүй байж болох ба агаарын хөлгийн тусгай мэдээг Конвенцын Хавсралт 3-ын Appendix 6-ын 1.2.1-ийн дагуу дамжуулдгийн адилаар цаг уурын ажиглалтын алба, WAFCs-д болон бусад цаг уурын холбогдох албадад түгээнэ.

Тайлбар. Нислэгийн явцад агаарын хөлгөөс өгөх агаарын хөлгийн тусгай мэдээнд ашиглагдах загваруудыг Конвенцын Хавсралт 3-ын Appendix 6-д заасны дагуу гаргах бөгөөд Хүснэгт Х6-1В-д үзүүлсэн болно.

3.2 Дэлхийн бүсийн урьдчилан мэдээлэх төвийн (WAFCs) үүрэг (Responsibilities of world area forecast centers)

Тайлбар. Цаг уурын үндсэн тоон өгөгдлийн дамжуулалтыг Дэлхийн Цаг Уурын Байгууллагын (WMO) Дэлхийн харилцаа холбооны систем (Global Telecommunication system)-ээр гүйцэтгэнэ.

3.3 Агаарын хөлгийн мэдээний нэмэлт түгээлт (Supplementary dissemination of air-reports)

Зөвлөмж - *Нисэхийн болон цаг уурын тусгай шаардлагуудыг хангахын тулд агаарын хөлгийн мэдээг нэмэлт байдлаар дамжуулахдаа холбогдох цаг уурын байгууллагуудын хооронд зохион байгуулж харилцан тохиролцсон байна.*

3.4 Агаарын хөлгийн мэдээний формат (Format of air-reports)

Агаарын хөлгийн мэдээг хүлээн авсан хэлбэрээр нь солилцоно.

4. САЛХИНЫ ШИЛЖЛЭГ БОЛОН ГАЛТ УУЛЫН ҮНСИЙГ МЭДЭЭЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ТУСГАЙ ЗОХИЦУУЛАЛТ (SPECIFIC PROVISIONS RELATED TO REPORTING WIND SHEAR AND VOLCANIC ASH)

4.1 Салхины шилжлэгийг мэдээлэх (Reporting of wind shear)

4.1.1 **Зөвлөмж** – *Агаарын хөлөг өндөр авах, аэродром руу ойртолт хийх үед салхины шилжлэг ажиглагдаж, агаарын хөлгийн мэдээгээр мэдээлж буй тохиолдолд уг агаарын хөлгийн төрлийг заах шаардлагатай.*

4.1.2 **Зөвлөмж** – *Агаарын хөлгийн мэдээнд, эсхүл урьдчилсан мэдээнд агаарын хөлөг өндөр авах, ойртолтын үед салхины шилжлэгийн нөхцөлийн тухай мэдээлэгдсэн бол агаарын хөлгийн дарга НХУ-ний нэгжид даруй мэдээлнэ.*

4.2 Галт уулын идэвхжилийн мэдээллийг нислэгийн дараа мэдээлэх (Post-flight reporting of volcanic activity)

Тайлбар. Галт уулын идэвхжилийн мэдээний нарийвчилсан зааврыг PANS-ATM (Doc 4444)-ийн Appendix 1-д үзүүлсэн болно.

4.2.1 Агаарын хөлөг аэродромд нисэн ирэхэд агаарын хөлгийн багийн гишүүд, эсхүл агаарын тээвэрлэгчид галт уулын идэвхжилийн тухай мэдээллийг нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагад шууд дамжуулна. Хэрэв нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагад нисэх багийн гишүүд хүрч очих боломжгүй бол бөглөсөн маягтыг нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон агаарын тээвэрлэгчдийн хооронд байгуулсан гэрээний дагуу мэдээлнэ.

ХУУЛБАР ЗӨВ
Архивч
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дүгээр сарын 29

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Хуудас 112
Даргын 26 А/17

4.2.2 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага хүлээн авсан галт уулын идэвхжилийн тухай бөглөсөн маягтыг цаг алдалгүй галт уулын идэвхжил ажиглагдсан FIR хариуцсан цаг уурын албанд дамжуулна.

...ЦАГ УЗЛЭГ, УУР АЛЬСГАЛЫН
ДҮЙЦЛЭЛТИЙН ЯАМ
бүртгэлийн дугаар 607
ХҮЛЭГЭР ҮНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
Чагуул
(гарын үсэг)(сарын үсгийн тайлал)
20 26 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид Төрийн ...
дарын 26 ... А/17

Хүснэгт Х4-1. Агаарын хөлгийн тусгай мэдээний загвар (downlink)

Түлхүүр: М - Заавал оруулах, мэдээ бүрийн нэг хэсэг;
С – шаардлагатай үед оруулах;

Тайлбар. Нисэх багийн ахлагчаас асуух мэдээ. Одоогоор зөвхөн "SEV TURB" нөхцөлийг автоматжуулсан. (2.6.3-ыг үзнэ үү).

Бүлэг 4-т тусгагдсан элемент	Агуулга	Загвар	Жишээ
Мэдээний төрлийг тодорхойлогч (М)	Агаарын хөлгийн мэдээний төрөл	ARS	ARS
Агаарын хөлгийг тодорхойлогч (М)	Агаарын хөлгийн радио холбооны утасны дуудлагын тэмдэглэгээ (М)	nnnnnn	VA812
DATA BLOCK 1			
Өргөрөг (М)	Өргөрөг - градус, минутаар (М)	Nnnnn, эсхүл Snnnn	S4506
Уртраг (М)	Уртраг - градус, минутаар (М)	Wnnnnn, эсхүл Ennnnn	E01056
Түвшин (М)	Нислэгийн түвшин (М)	FLnnn эсхүл FLnnn-ээс FLnnn	FL330 FL280-аас FL310
Хугацаа (М)	Ажиглагдсан хугацаа - цаг, минутаар (М)	OBS AT nnnnZ	OBS AT 1216Z
DATA BLOCK 2			
Салхины чиглэл (М)	Салхины чиглэл - градусаар (М)	nnn/	262/
Салхины хурд (М)	Салхины хурд - м/с, (эсхүл kt) (М)	nnnMPS, (эсхүл nnnKT)	040MPS (080KT)
Салхины дарцаг (М)	Салхины дарцаг (М)	n	1
Агаарын температур (М)	Агаарын температур - аравны градусаар (М)	T[M]nnn	T127 TM455
Сэгсрэлт (С)	Сэгсрэлт зууны $м^{2/3}$ $с^{-1}$ болон хамгийн их утгад хүрсэн хугацаа (С)[1]	EDRnnn/nn	EDR064/08
Чийгшил (С)	Харьцангуй чийгшил - хувиар (С)	RHnnn	RH054
DATA BLOCK 3			
Агаарын хөлгийн тусгай мэдээ гаргахад хүргэж буй нөхцөл (М)		SEV TURB [EDRnnn]2, эсхүл SEV ICE, эсхүл SEV MTW, эсхүл TS GR3, эсхүл TS3, эсхүл HVY DS4, эсхүл HVY SS4, эсхүл VA CLD [FLnnn/nnn] ,эсхүл VA5 [MT nnnnnnnnnnnnnnnnnnn], эсхүл MOD TURB [EDRnnn]2, эсхүл MOD ICE	SEV TURB EDR076 VA CLD FL050/100

Тайлбар.

1. *Тохиолдсон цагийг Конвенцын Хавсралт 3-ын Appendix 4-т заасны дагуу Хүснэгт Х4-2-т тусгасны дагуу мэдээлнэ.*
2. *Сэгсрэлтийг 2.6.3-т заасны дагуу мэдээлнэ.*
3. *Халхлагдсан, далдлагдсан, эсхүл өргөн тархсан дуу цахилгаан, эсхүл нөөлөг салхины бүс дэх дуу цахилгаан.*
4. *Шороон шуурга, эсхүл элсэн шуурга.*
5. *Галт уулын дэлбэрэлтийн өмнөх үе, эсхүл галт уулын дэлбэрэлт.*

Хүснэгт Х4-2. Хамгийн их утгад хүрсэн тохиолдлын хугацааг мэдээлэх

Нэг минутын хугацаанд үүссэн сэгсрэлтийн хамгийн их утга ажиглалт хийхээс ..... минутын өмнө	Мэдээлэгдсэн утга
0-1	0
1-2	1
2-3	2
...	...
13-14	13
14-15	14
Цагийн мэдээлэл байхгүй	15

Хүснэгт Х4-3. Агаарын хөлгийн мэдээнд агуулагдах цаг уурын элементийн хамрах хүрээ болон нарийвчлал

Бүлэг 5-д тусгагдсан элементүүд		Хамрах хүрээ	Нарийвчлал
Салхины чиглэл:	^{0}градус	000 - 360	1
Салхины хурд:	MPS KT	00 - 125 00 - 250	1 1
Салхины дарцаг:	(индекс)	0-1	1
Агаарын температур:	^{0}C	-80-+60	0.1
Сэгсрэлт: агаарын хөлгийн байнгын мэдээ:	$m^{2/3}\ s^{-1}$ (ажиглагдсан хугацаа)*	0 - 2 0 - 15	0.01 1
Сэгсрэлт: агаарын хөлгийн тусгай мэдээ:	$m^{2/3}$ 7/50+ s^{-1}	0 - 2	0.01
Чийгшил:	%	0 – 100	1
* Нэгжгүй хэмжигдэхүүн			

ЦАГ УУРЫН ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Хүртээлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
Санцаг
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Санд Төрийн нарийн бичгийн дарга 26 А/17

Хавсралт 5. Урьдчилсан мэдээтэй холбоотой техникийн үзүүлэлт (Technical specifications related to forecasts)

(Бүлэг 6-г үзнэ үү)

1. TAF-ТАЙ ХОЛБООТОЙ ШАЛГУУР (CRITERIA RELATED TO TAF)

1.1 TAF-ийн формат (Format of TAF)

1.1.1 TAF мэдээг Конвенцын Хавсралт 3-ын Appendix 5-д заасны дагуу гаргах бөгөөд Хүснэгт Х5-1-д үзүүлсэн загварт тусгасны дагуу зохиох ба WMO-аас гаргасан кодын хэлбэрээр дамжуулна.

Тайлбар. TAF кодын хэлбэрийг Manual on Codes (WMO-No. 306), Volume I.1, Part A - Alphanumeric Codes-д өгсөн болно.

1.1.2 TAF мэдээг 1.1.1-ийн дагуу түгээхээс гадна 2028 оноос IWXXM GML хэлбэрээр түгээнэ.

Тайлбар 1. IWXXM-ийн техникийн үзүүлэлтүүдийг Manual on Codes (WMO-No. 306), Volume I.3, Part D - Representation Derived from Data Models, IWXXM-ийн хэрэгжүүлэх зааврыг Manual on the ICAO Meteorological Information Exchange Model (IWXXM) ICAO-ын баримт бичиг (Doc 10003)-д тус тус тусгасан болно.

Тайлбар 2. Geography markup language (GML) нь Open Geospatial Consortium (OGC)-ийн кодлох стандарт юм.

1.2 TAF-д өгөх цаг уурын элемент (Inclusion of meteorological elements in TAF)

Тайлбар. Урьдчилсан мэдээний үнэн зөв байх талаарх зааврыг Конвенцын Хавсралт 3-ын Attachment B-д заасны дагуу Нэмэлт B-д үзүүлсэн болно.

1.2.1 Газар орчмын салхи (Surface wind)

Салхины урьдчилсан мэдээнд салхины зонхилох чиглэлийг өгнө. Салхины чиглэл нь тогтворгүй, эсхүл зонхилох чиглэлийг урьдчилан мэдээлэх боломжгүй үед тухайлбал: зөөлөн салхитай (1.5м/с-ээс бага (3kt)), эсхүл дуу цахилгаантай үед урьдчилан мэдээлж буй салхины чиглэлийг тогтворгүй гэж "VRB"-р тэмдэглэнэ. Салхи хурд 0.5м/с (1kt) -ээс бага байхаар бол урьдчилан мэдээлж буй салхины хурдыг намуун гэж тэмдэглэнэ. Урьдчилан мэдээлж буй салхины хамгийн их хурд (өрөвхийлөлт) нь урьдчилан мэдээлж буй салхины дундаж утгаас 5м/с (10kt), эсхүл түүнээс их байхаар бол хамгийн их хурдыг урьдчилсан мэдээнд өгнө. Салхины хурд 50м/с (100kt), эсхүл түүнээс их байхаар урьдчилан мэдээлэх бол 49м/с (99kt) гэж зааж өгнө.

1.2.2 Алсын барааны харагдац (Visibility)

Зөвлөмж – *Урьдчилан мэдээлж буй АБХ нь 800м-ээс бага байхаар бол 50м, 800м, эсхүл түүнээс их гэхдээ 5км-ээс бага байхаар бол 100м, 5км, эсхүл түүнээс их гэхдээ 10км-ээс бага байхаар бол 1км-ийн зайцтайгаар тус тус мэдээлэх бөгөөд 10км, эсхүл түүнээс их байхаар бол кодын CAVOK нөхцөлийг хангах урьдчилсан мэдээнээс бусад мэдээнд 10км гэж тус тус тэмдэглэнэ. Урьдчилсан мэдээнд давамгайлах АБХ-ыг мэдээлнэ. АБХ чиглэл бүрд өөр байх, эсхүл зонхилох АБХ-ын хэмжээг мэдээлэх боломжгүй тохиолдолд урьдчилсан мэдээнд хамгийн бага АБХ-ыг мэдээлнэ.*

1.2.3 Цаг агаарын үзэгдэл (Weather phenomena)

Дараах цаг агаарын үзэгдлүүдээс нэг, эсхүл түүнээс их, хамгийн ихдээ гурван үзэгдэл, эсхүл тэдгээрийн хослол аэродром дээр ажиглагдахаар байвал тэдгээрийн шинж байдал болон эрч хүч (боломжтой тохиолдолд)-ний байдалтай хамт урьдчилсан мэдээнд өгнө. Үүнд:

- зайрмагтсан хур тунадас
- хэт хөрсөн манан
- дунд хүчтэй, эсхүл хүчтэй хур тунадас (аадар ороод)
- намын шороон, элсэн, эсхүл цасан шуурга
- явган шороон, элсэн, эсхүл цасан шуурга
- шороон шуурга
- элсэн шуурга
- дуу цахилгаан (хур тунадастай, эсхүл хур тунадасгүй)
- нөөлөг салхи
- цаг уурын болон НХҮБ-ууд болон хэрэглэгчид хоорондбайгуулсан гэрээний дагуу Хавсралт 3-ын 4.4.2.3-д заасан бусад цаг агаарын үзэгдлүүд.

Цаг агаарын үзэгдэл зогсоно гэж үзвэл "NSW" товчлолоор тэмдэглэнэ.

1.2.4 Үүлшил (Cloud)

Зөвлөмж – *Үүлний тоо хэмжээ, үүлний хэлбэрийг "FEW" "SCT" "BKN", эсхүл "OVC" товчлолоор мэдээлнэ. Тэнгэр халхлагдах, эсхүл харанхуйлах мөн үүлшлийг урьдчилан мэдээлэх боломжгүй үед аэродром дээрх босоо чиглэлийн АБХ-ыг мэдээлэх боломжтой бол "VV" бүлгээр мэдээлнэ. Хэд хэдэн үүлний давхарга болон массыг урьдчилан мэдээлэх бол тэдгээрийн хэмжээ болон суурийн өндрийг дараах дарааллын дагуу мэдээлнэ. Үүнд:*

a) хэмжээг нь харгалзан үүлний хамгийн доод давхарга, эсхүл массыг "FEW", "SCT", "BKN", эсхүл "OVC" гэсэн товчлолуудын аль тохирохыг ашиглан мэдээлнэ.

b) 2/8 октантаас их хэмжээтэй үүлний дараагийн дээд давхарга, эсхүл массыг "SCT", "BKN", эсхүл "OVC" гэсэн товчлолуудын аль тохирохыг ашиглан мэдээлнэ.

c) 4/8 октантаас их хэмжээтэй үүлний дараагийн дээд давхарга, эсхүл массыг "BKN", эсхүл "OVC" гэсэн товчлолуудын аль тохирохыг ашиглан мэдээлнэ.

d) бороонь бөөн үүл, эсхүл цамхаг хэлбэрийн үүлийг a,b болон c-ийн дагуу тус тусад нь ямар ч тохиолдолд мэдээлнэ.

Үүлний мэдээлэл нь үйл ажиллагаанд нөлөөлөх үүлээр хязгаарлагдана; Үйл ажиллагаанд нөлөөлөх үүлгүй гэж урьдчилан мэдээлэгдэхээр боловч "CAVOK" тэмдэглэгээг хэрэглэхэд тохиромжгүй бол "NSC" товчлолыг хэрэглэнэ.

1.2.5 Температур (Temperature)

Зөвлөмж - *Хэрэв температурыг урьдчилсан мэдээнд тусгах бол TAF-ийн үйлчлэх хүчинтэй хугацаанд хамаарах агаарын хамгийн их, эсхүл бага температурыг тэдгээрийн ажиглагдах хугацаатай хамт мэдээлнэ.*

УЛСЫН АРХИВЫН
дугаар 607
УНШИВ УНЭН
Архивч
(албаны нэр)
(гарын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 25

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид
дар 26 А/17

1.3 Өөрчлөлтийн бүлгийн ашиглалт (Use of change groups)

Тайлбар. TAF-д өөрчлөлтийн болон хугацааны бүлгийг ашиглах зааврыг Конвенцын Хавсралт 3-ийн Appendix 5-т заасны дагуу гаргах бөгөөд Хүснэгт Х5-2-д үзүүлэв.

1.3.1 TAF-д өөрчлөлтийн бүлгүүдийг өгөх, эсхүл TAF-д залруулга оруулахдаа дараах үзүүлэлтүүдийг баримтална. Дараах цаг агаарын үзэгдэл эхлэх, дуусах, эрч хүч нь өөрчлөгдөх, дангаараа, эсхүл хамт ажиглагдана. Үүнд:

- хэт хөрсөн манан
- зайрмагтсан хур тунадас
- дунд хүчтэй, эсхүл хүчтэй хур тунадас (аадар ороод)
- дуу цахилгаан
- шороон шуурга
- элсэн шуурга.

1.3.2 **Зөвлөмж** – *TAF-д өөрчлөлтийн бүлгүүдийг өгөх, эсхүл TAF-д залруулга оруулахдаа дараах үзүүлэлтүүдийг баримтална. Үүнд:*

a) газар орчмын салхины чиглэлийн дундаж утга нь 60,° эсхүл түүнээс ихээр өөрчлөгдөхөөр урьдчилан мэдээлэх үед уг өөрчлөлтөөс өмнө, эсхүл хойно нь салхины дундаж хурд 5м/с (10kt), эсхүл түүнээс их болох;
b) газар орчмын салхины хурдны дундаж утга нь 5м/с (10kt), эсхүл түүнээс ихээр өөрчлөгдөхөөр бол;
c) газар орчмын салхины хурдны дундаж утгаас хазайх хазайлт (өрөвхийлөлт) нь 5м/с (10kt), эсхүл түүнээс ихээр өөрчлөгдөх уг өөрчлөлтийн өмнө, эсхүл хойно салхины дундаж хурд нь 7.5м/с (15kt), эсхүл түүнээс их болох;
d) газар орчмын салхи үйл ажиллагаанд нөлөөлөх утгад хүрч өөрчлөгдөхөөр бол, уг босго утгыг цаг уурын, НХҮБ болон агаарын тээвэрлэгчид хооронд байгуулсан гэрээний дагуу дараах салхины нөлөөллийг тооцож үзсэний үндсэн дээр тодорхойлно. Үүнд:
    1) ашиглаж буй ХБЗ-ын шаардлага;
    2) аэродром дээрх агаарын хөлгийн хэвийн үйл ажиллагааны голлох хязгаарлалтуудыг илэрхийлэх утгад нөлөөлөх ХБЗ-ын арын болон хөндлөнгийн салхи;
e) АБХ-ын хэмжээ дараах утгуудын аль нэгэнд хүрч өөрчлөгдөх, сайжрах, эсхүл муудахад өгнө. Үүнд:
    1) 150м, 350м, 600м, 800м, 1500м, эсхүл 3000м;
    2) 5000м - ил харагны нислэгийн дүрмийн дагуу явагдах нислэгтэй тохиолдолд
f) дараах цаг агаарын үзэгдлүүдийн аль нэг, эсхүл тэдгээрийн хослол ажиглагдаж эхлэх, эсхүл дуусах төлөвтэй үед:
    - *явган шороон, элсэн, эсхүл цасан шуурга- намын шороон, элсэн, эсхүл цасан шуурга*
    - *нөөлөг салхи*
    - *юүлүүр хэлбэрийн үүл (Торнадо, эсхүл усан догшин хуй)*
g) "BKN", эсхүл "OVC" хэмжээтэй хамгийн доод үүлний суурийн өндөр дараах утгуудыг дайран өнгөрөх бол; Үүнд:
"BKN", эсхүл "OVC" хэмжээтэй хамгийн доод үүлний суурийн өндөр нэмэгдэж, дараах аль нэг, эсхүл хэд хэдэн өндөрт хүрэх, эсвэл даван гарах төлөвтэй үед, эсхүл "BKN", эсхүл OVC хэмжээтэй хамгийн доод

ХУЛГАЛАН УНШИХ
Архив г
Хонгор
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дүгээр сарын 29
ЭХ ХУУЛЬ
Саид
26 А/17

үүлний өндөр багасаж, дараах аль нэг эсвэл хэд хэдэн өндөр даван буурахаар төлөвтэй бол
1) 30м, 60м, 150м, эсхүл 300м (100ft, 200ft, 500ft, эсхүл 1000ft);
2) 450м (1500ft) - ил харагны нислэгтэй тохиолдолд;

h) 450м (1500ft)-ээс нам өндөртэй үүлний хэмжээг дараах байдлаар өгнө. Үүнд:
1) NSC, FEW, эсхүл SCT хэмжээнээс BKN, эсхүл OVC болох;
2) BKN, эсхүл OVC хэмжээнээс NSC, FEW, эсхүл SCT болох;

i) босоо чиглэлийн АБХ-ын хэмжээ сайжрах болон дараах утгуудыг дайран өнгөрөх бол: 30м, 60м, 150м, эсхүл 300м (100ft, 200ft, 500ft, эсхүл 1000ft);

j) нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон агаарын тээвэрлэгчид хооронд байгуулсан гэрээний дагуу тухайн газрын аэродромын хязгаарлалтад үндэслэн тогтоосон бусад шалгуур.

Тайлбар. Тухайн газрын аэродромын үйл ажиллагааны минимумд үндэслэсэн бусад шалгууруудыг Хавсралт 3-ын 2.3.3 h)-ийн дагуу SPECI гаргах шалгууруудтай адилаар авч үзнэ.

1.3.3 **Зөвлөмж** – *Бүлэг 6-ийн 6.2.3-д заасан аль нэг элементийн өөрчлөлтийг дээрх 1.3.2-д заасан шалгуурын дагуу мэдээлэх шаардлагатай тохиолдолд "BECMG", эсхүл "TEMPO" өөрчлөлт заагчийг ашиглан өөрчлөлт болох цаг хугацааны хамт мэдээлнэ. Өөрчлөлтийн эхлэх болон дуусах хугацааг бүхэл UTC-р мэдээлнэ. Өөрчлөлт заагчийн ард зөвхөн өөрчлөлт болно гэж үзэж буй тухайн элементийг л мэдээлнэ. Хэдий тийм боловч үүлний өөрчлөлтийг мэдээлэх шаардлагатай тохиолдолд үүлний бүлэгт өөрчлөлт орох, орохгүй бүх үүлийг мэдээлнэ.*

1.3.4 **Зөвлөмж** – *"BECMG" өөрчлөлт заагч болон холбогдох хугацааны бүлгийг ашиглан аажим, эсхүл аажим бус хурдацтайгаар тодорхой хугацаанд цаг агаарын нөхцөл байдал тусгай босго утгыг давах, эсхүл тусгайн босго утгад хүрч өөрчлөгдөх өөрчлөлтийг мэдээлнэ. Өөрчлөлтийн хугацаа нь 2 цагаас хэтрэхээргүй байх боловч хамгийн ихдээ 4 цагаас хэтрэхгүй.*

1.3.5 **Зөвлөмж** – *"TEMPO" өөрчлөлтийн үзүүлэлт ба холбогдох цаг хугацааны бүлэгт заасан босго утгад хүрсэн, эсхүл давсан цаг агаарын нөхцөлийн хүлээгдэж буй байнгын, эсхүл түр зуурын хэлбэлзлийг тодорхойлоход, мөн тохиолдол бүрийг нэгтгэн өөрчлөлт гарах төлөвтэй байгаа урьдчилсан хугацааны хагасаас бага хувийг хамарна. Тохиолдол бүрийн үргэлжлэх хугацаа нь нэг цагаас бага байх цаг уурын түр зуурын өөрчлөлтийг "TEMPO" бүлгээр мэдээлнэ. Мөн тохиолдол бүрийг нэгтгэхэд урьдчилсан хугацааны хагасаас бага хувийг хамарна. Хэрэв түр зуурын өөрчлөлт нь нэг цаг ба түүнээс удаан үргэлжлэх төлөвтэй бол 1.3.4-т заасны дагуу "BECMG" бүлгийг ашиглах, эсхүл хүчинтэй байх хугацааг 1.3.6-д заасны дагуу хуваана.*

1.3.6 **Зөвлөмж** – *Цаг агаарын давамгайлах нөхцөл байдлыг өөрчлөх нэг, эсхүл хэд хэдэн өөр нөхцөл байдал үүсэхээр бол урьдчилсан мэдээний хүчинтэй хугацааг "FM" товчлолын араас шууд (зай авалгүйгээр) өөрчлөлт ажиглагдах хугацааг 6 тэмдэгтээр өдөр, цаг (UTC) болон минутыг илэрхийлсэн хугацааны бүлгийг ашиглан бие даасан хэсгүүдэд хуваан мэдээлнэ. "FM" товчлолоор зааглан хуваасан хугацааг бие даасан*

Архив 2
Хамуулах
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дүгээр сарын 29
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн
дарын 26 А/17

хэсэг гэж үзэх бөгөөд урьдчилсан мэдээнд өгсөн өмнөх нөхцөлийг дараагийн нөхцөлөөр солигдоно гэж үзнэ.

1.4 Магадлалын бүлгийн ашиглалт (Use of probability groups)

Зөвлөмж – *Урьдчилан мэдээлж буй элементүүдийн альтернатив утгын ажиглагдах магадлалыг мэдээлэх шаардлагатай бол "PROB" товчлолын араас бүхэл аравтын хувиар илэрхийлсэн магадлалын утгыг түүний ажиглагдах хугацааны хамт мэдээлнэ. Магадлалын мэдээллийг урьдчилан мэдээлж буй элементүүдийн ард өгөх бөгөөд түүний араас залгуулан элементүүдийн альтернатив утгыг өгнө. Цаг агаарын түр зуурын хэлбэлзэх өөрчлөлтийн урьдчилсан мэдээний магадлалыг "TEMPO" өөрчлөлт заагч болон түүнд харгалзах хугацааны бүлгийн өмнө "PROB" товчлолыг бүхэл аравтын хувиар илэрхийлсэн магадлалтай хамт мэдээлнэ. Сонгосон утга, эсхүл өөрчлөлтийн магадлал нь 30 хувиас бага бол үүнийг мэдээлэх шаардлагагүй. Сонгосон утга, эсхүл өөрчлөлтийн магадлал нь 50 хувь, эсхүл түүнээс их бол үүнийг нислэгийн мэдээнд магадлалын бүлгээр мэдээлэхгүй бөгөөд үүний оронд шаардлагатай тохиолдолд "BECMG", эсхүл "TEMPO" өөрчлөлт заагчаар, эсхүл "FM" товчлолыг ашиглан хугацаа хуваагчаар тус тус мэдээлнэ. Магадлалын бүлэгт "BECMG" өөрчлөлт заагч болон "FM" хугацаа заагчийг ашиглаж болохгүй.*

1.5 Өөрчлөлтийн болон магадлалын бүлгийн тоо (Numbers of change and probability groups)

Зөвлөмж – *Өөрчлөлтийн болон магадлалын бүлгүүдийн тоо хамгийн бага байх бөгөөд хамгийн ихдээ 5-аас хэтрүүлж болохгүй.*

1.6 TAF дамжуулалт (Dissemination of TAF)

TAF болон түүнд хийсэн залруулгыг Олон улсын ОРМЕТ өгөгдлийн сан болон интернэтэд суурилсан нисэхийн суурин холбооны үйлчилгээний төвүүдэд дамжуулна.

2. ХАНДЛАГЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШАЛГУУР (CRITERIA RELATED TO TREND FORECASTS)

2.1 Хандлагын урьдчилсан мэдээний формат (Format of trend forecasts)

Хандлагын урьдчилсан мэдээг Хавсралт 3-ын Хүснэгт Х3-1 болон Х3-2-д үзүүлсэн загварын дагуу гаргана. Хандлагын урьдчилсан мэдээнд ашиглах нэгж болон хэмжээ нь дээрх нэмэлтэд оруулсан мэдээтэй ижил байна.

Тайлбар. Хандлагын урьдчилсан мэдээний жишээнүүдийг Хавсралт 3-д үзүүлсэн болно.

2.2 Хандлагын урьдчилсан мэдээнд өгөх цаг уурын элемент (Inclusion of meteorological elements in trend forecasts)

2.2.1 Ерөнхий зүйл (General provisions)

Хандлагын урьдчилсан мэдээнд газар орчмын салхи, АБХ, цаг агаарын үзэгдлүүд болон үүл зэрэг нэг, эсхүл хэд хэдэн элементүүдийн нөлөөлөх өөрчлөлтийг мэдээлнэ. Зөвхөн өөрчлөлт ажиглагдах элементүүдийг урьдчилсан мэдээнд өгнө. Хэдий тийм боловч үүлний нөлөөлөхүйц өөрчлөлтийг мэдээлэх шаардлагатай тохиолдолд үүлний бүлэгт өөрчлөлт орох, орохгүй бүх үүлийг мэдээлнэ. АБХ-д өөрчлөлт орох тохиолдолд АБХ-ыг муутгаж буй цаг агаарын үзэгдлийг мөн

ЗАГАЛЬ ОРЧИН УЛС ДАМЖУУЛАЛТЫН
Архив 2
(Албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дугаар сарын 29
МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн дарын 26 А/17

мэдээлнэ. Ямар нэг өөрчлөлт ажиглагдахгүй бол үүнийг "NOSIG" таних үгээр мэдээлнэ.

2.2.2 Газар орчмын салхи (Surface wind)

Хандлагын урьдчилсан мэдээнд дараах тохиолдлуудад салхины өөрчлөлтийг мэдээлнэ. Үүнд:

a) газар орчмын салхины чиглэлийн дундаж утга нь 60°, эсхүл түүнээс ихээр өөрчлөгдөх үед уг өөрчлөлтийн өмнө, эсхүл хойно нь салхины дундаж хурд 5м/с (10kt), эсхүл түүнээс их болох;

b) салхины хурдны дундаж утга нь 5м/с (10kt), эсхүл түүнээс ихээр өөрчлөгдөхөөр бол;

c) газар орчмын салхи эрс өөрчлөгдөхөөр бол, уг босго утгыг цаг уурын, НХҮБ болон агаарын тээвэрлэгчидтэй зөвшилцсөний дагуу салхины дараах нөлөөллийг тооцож үзсэний үндсэн дээр тодорхойлно. Үүнд:

1) ашиглаж буй ХБЗ-ын шаардлага;
2) аэродром дээрх агаарын хөлгийн хэвийн үйл ажиллагааны голлох хязгаарлалтуудыг илэрхийлэх утгад нөлөөлөх ХБЗ-ын арын болон хөндлөнгийн салхи.

2.2.3 Алсын барааны харагдац (Visibility)

АБХ-ын хэмжээ дараах утгуудын аль нэгэнд хүрч өөрчлөгдөх, сайжрах, эсхүл муудах бол хандлагын урьдчилсан мэдээнд уг өөрчлөлтийг мэдээлнэ. Үүнд: 150м, 350м, 600м, 800м, 1500м болон 3000м. Урьдчилсан мэдээнд ил харааны нислэгийн дүрмийн дагуу явагдах нислэгтэй тохиолдолд АБХ 5000м-т хүрч өөрчлөгдөх өөрчлөлтийг нэмэлтээр мэдээлнэ.

Тайлбар. Тухайн газрын байнгын болон тусгай мэдээний хандлагын урьдчилсан мэдээнд ХБЗ-ын дагуух АБХ-ыг мэдээлнэ. Харин METAR, SPECI-д оруулсан хандлагын урьдчилсан мэдээнд зонхилох АБХ-ын хэмжээг мэдээлнэ.

2.2.4 Цаг агаарын үзэгдэл (Weather phenomena)

2.2.4.1 Дараах цаг агаарын нэг, эсхүл хэд хэдэн үзэгдлүүд, тэдгээрийн хослол ажиглагдаж эхлэх, зогсох, эсхүл эрч хүч нь өөрчлөгдөх бол хандлагын урьдчилсан мэдээнд мэдээлнэ. Үүнд:

- зайрмагтсан хур тунадас
- дунд хүчтэй, эсхүл хүчтэй хур тунадас (аадар ороод)
- дуу цахилгаан (хур тунадастай)
- шороон шуурга
- элсэн шуурга
- цаг уур, НХҮБ болон агаарын тээвэрлэгчид хооронд байгуулсан гэрээний дагуу Нэмэлт 3-ын 4.4.2.3-д заасан бусад цаг агаарын үзэгдлүүд.

2.2.4.2 Дараах цаг агаарын нэг, эсхүл хэд хэдэн үзэгдлүүд, эсхүл хамт ажиглагдаж эхлэх, эсхүл зогсохоор бол хандлагын урьдчилсан мэдээнд мэдээлнэ. Үүнд:

- хэт хөрсөн манан
- явган шороон, элсэн, эсхүл цасан шуурга
- намын шороон, элсэн, эсхүл цасан шуурга
- дуу цахилгаан (хур тунадасгүй)
- нөөлөг салхи
- юүлүүр хэлбэрийн үүл (Торнадо, эсхүл усан доргошин хүй).

ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЭХ ХУУЛЬ
Саид Төрийн
дарын 26 А/17

2.2.4.3 Дээрх 2.2.4.1 болон 2.2.4.2-ын дагуу мэдээлсэн нийт үзэгдлүүдийн тоо 3-аас ихгүй байна.

2.2.4.4 Цаг агаарын үзэгдэл зогсох бол үүнийг мэдээлэхдээ "NSW" товчлолыг ашиглана.

2.2.5 Үүлшил (Clouds)

"BKN", эсхүл "OVC" хэмжээтэй хамгийн доод давхарга (масс)-ын үүлний суурийн өндөр дараах утгуудын аль нэгэнд хүрч өөрчлөгдөх, дээшлэх, эсхүл доошлох бол хандлагын урьдчилсан мэдээнд мэдээлнэ: 30м, 60м, 150м, 300м болон 450м (100ft, 200ft, 500ft, 1000ft болон 1500ft). 450м (1500ft)-ээс нам өндөртэй давхаргын эсхүл массын үүлний хэмжээ FEW, эсхүл SCT байснаа BKN, эсхүл OVC болж ихсэх, эсхүл BKN, эсхүл OVC хэмжээнээс FEW, эсхүл SCT болж буурахаар бол үүнийг хандлагын урьдчилсан мэдээнд мэдээлнэ. Нислэгт нөлөөлөх үүлгүй бөгөөд "CAVOK"-ийг хэрэглэхэд тохиромжгүй бол "NSC" товчлолыг ашиглана.

2.2.6 Босоо чиглэлийн АБХ (Vertical visibility)

Тэнгэр халхлагдах, эсхүл харанхуйлна гэж урьдчилан таамаглаж байгаа үед аэродром дээрх босоо чиглэлийн АБХ-ыг мэдээлэх боломжтой бол дараах утгуудын аль нэгэнд хүрч өөрчлөгдөх, сайжрах, эсхүл муудахаар бол өөрчлөлтийг хандлагын урьдчилсан мэдээнд мэдээлнэ: 30м, 60м, 150м болон 300м (100ft, 200ft, 500ft болон 1000ft).

2.2.7 Нэмэлт шалгуур (Additional criteria)

2.2.2-оос 2.2.6-д тусгасан шалгуурууд дээр нэмэлтээр нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон агаарын тээвэрлэгчидтэй зөвшилцсөний дагуу тухайн газрын аэродромын үйл ажиллагааны минимумд үндэслэн тогтоосон өөрчлөлтийг мэдээлэх шалгуурыг ашиглаж болно.

2.3 Өөрчлөлтийн бүлгийн ашиглалт (Use of change groups)

Тайлбар. Хандлагын урьдчилсан мэдээнд өөрчлөлт заагчийг ашиглах зааврыг Хавсралт 3-ын Хүснэгт Х3-3-д үзүүлсэн болно.

2.3.1 Хэрэв өөрчлөлт ажиглагдахаар бол "BECMG", эсхүл "TEMPO" өөрчлөлт заагчийн аль нэгийг ашиглан хандлагын урьдчилсан мэдээг эхлүүлнэ.

2.3.2 "BECMG" өөрчлөлт заагчийг ашиглан аажим, эсхүл аажим бус хурдацтайгаар цаг агаарын нөхцөл байдал тусгай утгыг давах, эсхүл тусгай утгад хүрч өөрчлөгдөх өөрчлөлтийг мэдээлнэ. Цаг болон минутаар өгсөн хугацааны бүлэгтэй хамт "FM" "TL", эсхүл "AT" товчлолын аль тохирохыг ашиглан хэдэн цагт, эсхүл хэдий хугацаанд өөрчлөлт ажиглагдахыг урьдчилан мэдээлнэ. Хэрэв цаг агаарын өөрчлөлтийн эхлэл ба төгсгөл нь хандлагын урьдчилсан мэдээний хугацаанд бүрэн багтаж байвал уг өөрчлөлтийн эхлэх болон дуусах хугацааг "FM" болон "TL" товчлолыг ашиглан харгалзах хугацааны бүлгийн хамт мэдээлнэ. Хэрэв хандлагын урьдчилсан мэдээний эхлэх хугацаанд өөрчлөлт эхлэхээр урьдчилан мэдээлсэн бөгөөд ХУМ дуусахаас өмнө өөрчлөлт дуусаж байвал "FM" товчлолыг өгөхгүйгээр зөвхөн "TL" товчлолыг ашиглан харгалзах хугацааны бүлгийн хамт мэдээлнэ. Харин хандлагын урьдчилсан мэдээний хугацааны дундаас өөрчлөлт эхлэхээр урьдчилан мэдээлсэн бөгөөд уг өөрчлөлт ХУМ

ХЯНАГДСАН ЗӨВШӨӨРӨВ
ХЯНАГЧ ДАРГА
Архивч
(Албан тушаалын нэр)
Хамуах
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дугаар сарын 29

ЗӨВШӨӨРӨВ
ЭХ ХУВЬ
Саид
Дарын 26 А/17

дуусах хугацаатай давхцаж төгсөж байвал "TL" товчлолыг өгөхгүйгээр зөвхөн "FM" товчлолыг ашиглан харгалзах хугацааны бүлгийн хамт мэдээлнэ. Хандлагын урьдчилсан мэдээний үйлчлэх хугацаанд өөрчлөлт болох цагийг онцлон заах боломжтой бол "AT" товчлолыг ашиглан харгалзах хугацааны бүлгийн хамт мэдээлнэ. Хэрэв өөрчлөлт нь хандлагын урьдчилсан мэдээний эхлэх хугацаанд эхэлж, дуусах хугацаанд төгсөж байвал, эсхүл хандлагын урьдчилсан мэдээний хугацаанд өөрчлөлт болно гэдгийг мэдээлэх боловч ажиглагдах хугацаа нь тодорхойгүй тохиолдолд "FM" "TL" болон "AT" товчлол, тэдгээрт харгалзах хугацааны бүлгийг өгөхгүйгээр зөвхөн "BECMG" өөрчлөлт заагчийг дангаар нь хэрэглэнэ.

2.3.3 Тохиолдол бүрийн үргэлжлэх хугацаа нь нэг цагаас бага байх цаг уурын түр зуурын өөрчлөлтийг TEMPO хэлбэрээр мэдээлнэ. Цаг, минутаар өгсөн хугацааны бүлэгтэй хамт "FM" болон "TL" товчлолын аль тохирохыг ашиглан хэдий хугацаанд хэлбэлзэлтэй өөрчлөлт ажиглагдахыг урьдчилан мэдээлнэ. Хэрэв цаг агаарын нөхцөл байдалд орох түр зуурын "хэлбэлзэл"-ийн эхлэл ба төгсгөл нь хандлагын урьдчилсан мэдээний хугацаанд бүрэн багтаж байвал уг өөрчлөлтийн эхлэх болон дуусах хугацааг "FM" болон "TL" товчлолыг ашиглан харгалзах хугацааны бүлгийн хамт мэдээлнэ. Хэрэв хандлагын урьдчилсан мэдээний эхлэх хугацаанд цаг агаарын нөхцөл байдалд орох түр зуурын "хэлбэлзэл" эхлэхээр урьдчилан мэдээлсэн бөгөөд ХУМ дуусахаас өмнө уг "хэлбэлзэл" дуусаж байвал "FM" товчлолыг өгөхгүйгээр зөвхөн "TL" товчлолыг ашиглан харгалзах хугацааны бүлгийн хамт мэдээлнэ. Харин хандлагын урьдчилсан мэдээний хугацааны дундаас цаг агаарын нөхцөл байдалд орох түр зуурын "хэлбэлзэл" эхлэхээр урьдчилан мэдээлсэн бөгөөд уг "хэлбэлзэл" ХУМ дуусах хугацаатай давхцаж төгсөж байвал "TL" товчлолыг өгөхгүйгээр зөвхөн "FM" товчлолыг ашиглан харгалзах хугацааны бүлгийн хамт мэдээлнэ. Хэрэв цаг агаарын нөхцөл байдалд орох түр зуурын "хэлбэлзэл" нь хандлагын урьдчилсан мэдээний эхлэх хугацаанд эхэлж, дуусах хугацаанд төгсөж байвал "FM" болон "TL" товчлол, тэдгээрт харгалзах хугацааны бүлгийг өгөхгүйгээр зөвхөн "TEMPO" өөрчлөлт заагчийг дангаар нь хэрэглэнэ.

2.4 Магадлалын бүлгийн ашиглалт (Use of probability indicator)

"PROB" магадлал заагчийг хандлагын урьдчилсан мэдээнд ашиглахгүй.

3. ХӨӨРӨЛТИЙН УРЬДЧИЛСАН МЭДЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШАЛГУУР (CRITERIA RELATED TO FORECASTS FOR TAKE-OFF)

3.1 Хөөрөлтийн урьдчилсан мэдээний формат (Format of forecasts for take-off)

Зөвлөмж – *Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага хөөрөлтийн урьдчилсан мэдээг Конвенцын Хавсралт 3-ын Appendix 3-т заасны дагуу гаргана. Хөөрөлтийн урьдчилсан мэдээнд өгөх цаг агаарын элементүүдийн дараалал, түүний нэр томьёо, нэгж болон хэмжээ нь тухайн аэродромын мэдээлэлд ашиглагддаг хэлбэртэй адил байна.*

3.2 Хөөрөлтийн урьдчилсан мэдээний залруулга (Amendments to forecasts for take-off)

Зөвлөмж – *Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон агаарын тээвэрлэгчид хооронд байгуулсан гэрээний дагуу хөөрөлтийн урьдчилсан*

ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Архивт
Хаягдсан
26 01 29
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид
26 А/17

мэдээний газар орчмын салхины чиглэл, түүний хурд, температур, даралт болон бусад элементүүдэд залруулга хийх шалгуурыг тохиролцсон байна. Уг шалгуур нь Конвенцын Хавсралт 3-ын Appendix 3-т заасны дагуу гаргах бөгөөд Нэмэлт 3-ын 2.3.1-ийн тусгасан аэродромын тусгай мэдээ бэлтгэх шалгуурт нийцсэн байна.

4. НАМ ӨНДРИЙН НИСЛЭГТ ЗОРИУЛСАН РАЙОНЫ УРЬДЧИЛСАН МЭДЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШАЛГУУР (CRITERIA RELATED TO AREA FORECASTS FOR LOW-LEVEL FLIGHTS)

4.1 Районы урьдчилсан мэдээний агуулга болон формат (Format and content of GAMET area forecasts)

4.1.1 *Районы урьдчилсан мэдээ нь нам өндрийн нислэгийн чиглэлийн дагуух цаг агаарын аюултай үзэгдлийн тухай мэдээлэл бөгөөд бичвэр, эсхүл AIRMET мэдээ хэлбэрээр бэлтгэн гаргана.

4.1.2 *Районы урьдчилсан мэдээг бичвэр хэлбэрээр гаргах бөгөөд AIRMET мэдээ хэлбэрээр бэлтгэж байгаа тохиолдолд Хавсралт 6-д заасны дагуу тус тус бэлтгэн гаргана.

4.1.3 *Районы урьдчилсан мэдээнд багтсан нислэгт аюултай цаг агаарын үзэгдэл ажиглагдаагүй, эсхүл цаашид ажиглагдахааргүй болсон үед зөвхөн залруулж байгаа үзэгдлийн тухай мэдээг нарийвчилна.

4.1.4 *Хариуцсан FIR-д үйлдэх нам өндрийн нислэгүүдэд зориулсан нислэгийн баримт бичгийг гаргах үүрэг бүхий цаг уурын байгууллагууд хоорондоо нам өндрийн нислэгт зориулсан районы урьдчилсан мэдээллүүдийг солилцоно.

4.1.5 *Районы урьдчилсан мэдээ нь нисэх буудал орчмын (50км) цаг агаарын тухай урьдчилсан мэдээ юм.

4.1.6 *Районы урьдчилсан мэдээг 3 цаг хүртэлх хугацаатайгаар, 1 цагийн урьдчилалтай зохиож НИ-2 хуудсанд бичнэ.

4.1.7 *Районы урьдчилсан мэдээг нам өндрийн нислэг эхлэхээс 2 цагийн өмнөөс нислэг дуусах хүртэл хугацаанд буудал орчмын урьдчилсан мэдээний хугацаатай давхцуулан бичнэ.

4.1.8 *Районы урьдчилсан мэдээг бичвэр хэлбэрээр, дараах дарааллын дагуу зохиож хэрэглэгч (нислэгийн удирдагч) нарт шуурхай дамжуулна. Үүнд:

а) үүлшил:
- доод мандлын үүлний тоо хэмжээг 3 баллын зайцтайгаар;
- доод мандлын үүлний хэлбэрийг монгол нэрээр;
- доод мандлын үүлний доод суурийн өндрийг 200 метрийн зайцтайгаар;
Зөвлөмж – *Нислэг үйлдэж буй агаарын хөлөг нь цаг уурын мэдээлэл авах хүсэлт гаргасан бол хүсэлтийг хүлээн авсан нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна.*

6.2 Нислэгийн үеийн төлөвлөлтөд агаарын тээвэрлэгчийн ашигладаг мэдээлэл (Information for in-flight planning by the operator)

Зөвлөмж – *Нислэг үйлдэж буй агаарын хөлөгт мэдээлэл дамжуулахад доорх мэдээллийг багтаана. Үүнд:*

a) *METAR, SPECI (хандлагын урьдчилсан мэдээг багтаагаад);*
b) *TAF, залруулга оруулсан TAF;*
c) *SIGMET, AIRMET мэдээлэл, агаарын хөлгийн тусгай мэдээ;*
d) *өндрийн салхи, өндрийн агаарын температурын мэдээлэл;*
e) *нислэгт холбогдолтой галт уулын үнс болон тропикийн циклоноос сэрэмжлүүлэх мэдээлэл;*
f) *Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага агаарын тээвэрлэгч хооронд байгуулсан гэрээний дагуу бусад цаг уурын үсэг, тоон болон зурган мэдээллүүд.*

Тайлбар. Зурган мэдээллийг дэлгэцээр үзүүлэх зааврыг Manual of Aeronautical Meteorological Practice (Doc 8896)-д үзүүлсэн болно.

ИЛ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ЗӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
Чанцаа
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн ... дарын 26 А/17

Зураг X8-1. Зураг хэлбэрээр WAFS урьдчилсан мэдээний хамрах хүрээний тогтмол хэсэг - Тэгш өнцөгт хэлбэр (Mercator projection)



CHART	LATITUDE	LONGITUDE	CHART	LATITUDE	LONGITUDE
A	N6700	W13724	D	N6300	W01500
A	N6700	W01236	D	N6300	E13200
A	S5400	W01236	D	S2700	E13200
A	S5400	W13724	D	S2700	W01500
ASIA	N3600	E05300	E	N4455	E02446
ASIA	N3600	E10800	E	N4455	E18000
ASIA	0000	E10800	E	S5355	E18000
ASIA	0000	E05300	E	S5355	E02446
B	N0304	W13557	F	N5000	E10000
B	N7644	W01545	F	N5000	W11000
B	N3707	E06732	F	S5242	W11000
B	S6217	W05240	F	S5242	E10000
B1	N6242	W12500	M	N7000	E10000
B1	N6242	E04000	M	N7000	W11000
B1	S4530	E04000	M	S1000	W11000
B1	S4530	W12500	M	S1000	E10000
C	N7500	W03500	MID	N4400	E01700
C	N7500	E07000	MID	N4400	E07000
C	S4500	E07000	MID	N1000	E07000
C	S4500	W03500	MID	N1000	E01700

ХЭ ОГЧИЙН, УУР АМЬСГАЛЫН
ҮЙЛЧЛЭЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд
Дарын 26 А/17

Зураг X8-2. Зураг хэлбэрээр WAFS урьдчилсан мэдээний хамрах хүрээний тогтмол хэсэг - Туйлын хэлбэр (бөмбөрцгийн хойд хагас)



CHART	LATITUDE	LONGITUDE	CHART	LATITUDE	LONGITUDE
EUR	N4633	W05634	I	N1912	E11130
EUR	N5842	E06824	I	N3330	W06012
EUR	N2621	E03325	I	N0126	W12327
EUR	N2123	W02136	I	S0647	E16601
G	N3552	W02822	L	N1205	E11449
G	N1341	E15711	L	N1518	E04500
G	S0916	E10651	L	N2020	W06900
G	S0048	E03447	L	N1413	W14338
H	N3127	W14836	NAT	N4439	W10143
H	N2411	E05645	NAT	N5042	E06017
H	S0127	W00651	NAT	N1938	E00957
H	N0133	W07902	NAT	N1711	W05406

ИГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(албан тушаалын нэр)
(гарын үсгийн тайлал)
20 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВИ
Сайд Төрийн дансын 26 А/17

Зураг X8-2. Зураг хэлбэрээр WAFS урьдчилсан мэдээний хамрах хүрээний тогтмол хэсэг - Туйлын хэлбэр (бөмбөрцгийн өмнөд хагас)



CHART	LATITUDE	LONGITUDE
J	S0318	W17812
J	N0037	W10032
J	S2000	W03400
J	S2806	E10717
K	N1255	E05549
K	N0642	E12905
K	S2744	W16841
K	S1105	E00317

ИГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 637
ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(Албан тушаалын нэр)
Цагаан
(Гарын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Тэрбиш
Дарын 26 А/17

Хавсралт 9. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, эрэн хайх, авран туслах үйлчилгээ болон нисэхийн мэдээллийн үйлчилгээнд зориулсан мэдээлэлтэй холбоотой техникийн үзүүлэлт (Technical specifications related to information for air traffic services, search and rescue services and aeronautical information services)

(Бүлэг 10-ыг үзнэ үү)

1. НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГЖИД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ (INFORMATION TO BE PROVIDED FOR AIR TRAFFIC SERVICES UNITS)

1.1 Аэродромын удирдлагын цамхагт зориулсан мэдээллийн жагсаалт (List of information for the aerodrome control tower)

Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагаас шаардлагатай тохиолдолд аэродромын удирдлагын цамхгийг цаг уурын дараах мэдээллээр хангана. Үүнд:

a) тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI, TAF хандлагын урьдчилсан мэдээ болон тэдгээрт хийсэн залруулга;
b) SIGMET, AIRMET мэдээлэл, салхины шилжлэгийн болон аэродромын сэрэмжлүүлэг;
c) тухайн газрын хэмжээнд тохиролцсоны дагуу ХБЗ-ын боломжит өөрчлөлтийг тодорхойлоход зориулсан газар орчмын салхины урьдчилсан мэдээ зэрэг бусад цаг уурын нэмэлт мэдээлэл;
d) цаг уурын болон НХҮБ хооронд байгуулсан гэрээний дагуу SIGMET зохиогдоогүй үед галт уулын үнсэн үүлний тухай хүлээн авсан мэдээлэл;
e) дагуу галт уулын дэлбэрэлтийн өмнөх идэвхжил, галт уулын дэлбэрэлтийн тухай хүлээн авсан мэдээлэл.

1.2 Ойртолтын удирдлагын нэгжид зориулсан мэдээллийн жагсаалт (List of information for the approach control unit)

Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагаас ойртолтын удирдлагын нэгжийг дараах мэдээллээр хангана. Үүнд:

a) тухайн аэродромын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI, TAF, хандлагын урьдчилсан мэдээ болон тэдгээрт оруулсан залруулга;
b) ойртолтын удирдлагын нэгжийн үйлчилж буй агаарын орон зайд хамаарагдах SIGMET, AIRMET мэдээлэл, салхины шилжлэгийн сэрэмжлүүлэг мэдээ мөн агаарын хөлгийн тусгай мэдээ;
c) тухайн газрын хэмжээнд тохиролцсоны дагуу цаг уурын нэмэлт мэдээлэл;
d) цаг уурын болон НХҮБ хооронд байгуулсан гэрээний дагуу SIGMET зохиогдоогүй үед галт уулын үнсэн үүлний тухай хүлээн авсан мэдээлэл;
e) цаг уурын болон, НХҮБ хооронд байгуулсан гэрээний дагуу галт уулын дэлбэрэлтийн өмнөх идэвхжил, галт уулын дэлбэрэлтийн тухай хүлээн авсан мэдээлэл.

1.3 Нислэгийн мэдээллийн төв болон бүсийн удирдлагын төвд зориулсан мэдээллийн жагсаалт (List of information for the area control centre and flight information centre)

Шаардлагатай тохиолдолд холбогдох Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагаас FIC, эсхүл ACC-ийг цаг уурын дараах мэдээллээр хангана. Үүнд:

а) Гэрээний дагуу тухайн аэродромын болон бусад байршлын даралтын утгыг агуулсан METAR, SPECI, тухайн нислэгийн мэдээллийн, эсхүл CTA-

д хамаарах TAF, хандлагын урьдчилсан мэдээ болон түүний залруулга, хэрэв шаардлагатай тохиолдолд зэргэлдээх FIR дэх аэродромууд, нислэгийн мэдээллийн болон ACCs-д зориулсан дээрх мэдээллүүд;

b) Гэрээний дагуу өндрийн салхи, өндрийн агаарын температур болон нислэгийн чиглэл дэх цаг агаарын үзэгдлийн урьдчилсан мэдээ тэдгээрт оруулсан залруулга, тухайн нислэгийн мэдээллийн, CTA-д зориулсан SIGMET, AIRMET мэдээлэл болон холбогдох агаарын хөлгийн тусгай мэдээ мөн FIC, эсхүл ACC-аас шаардсан тохиолдолд зэргэлдээх FIR-д зориулсан дээрх мэдээллүүд;
c) нислэг үйлдэж буй агаарын хөлөгт үйлчлэх зорилгоор FIC болон нислэгийн удирдлагын төвөөс хүссэн цаг уурын бусад мэдээлэл. Уг мэдээллийг тухайн цаг уурын алба өгөх боломжгүй бол тухайн цаг уурын алба нь бусад цаг уурын албанд хандаж уг мэдээллээр хангана;
d) цаг уурын болон НХҮБ хооронд байгуулсан гэрээний дагуу SIGMET зохиогдоогүй үед галт уулын үнсэн үүлний тухай хүлээн авсан мэдээлэл;
e) цаг уурын болон НХҮБ хооронд байгуулсан гэрээний дагуу агаар мандалд тархсан цацраг идэвхт бодисын тухай хүлээн авсан мэдээлэл;
f) тухайн хариуцсан нутаг дэвсгэр дэх TCAC-аас гаргасан тропикийн циклоноос сэрэмжлүүлэх мэдээлэл;
g) тухайн хариуцсан нутаг дэвсгэр дэх VAAC-аас гаргасан галт уулын үнснээс сэрэмжлүүлэх мэдээлэл;
h) цаг уурын болон НХҮБ хооронд байгуулсан гэрээний дагуу галт уулын дэлбэрэлтийн өмнөх идэвхжил болон галт уулын дэлбэрэлтийн тухай хүлээн авсан мэдээлэл.

1.4 Нисэхийн цахилгаан холбооны станцыг мэдээллээр хангах (Supply of information to aeronautical telecommunications stations)

Нисэхийн цахилгаан холбооны станцуудыг шаардлагатай тохиолдолд цаг уурын бодит болон урьдчилсан мэдээ, мэдээллээр хангана. Шаардлагатай гэж үзвэл тухайн мэдээ мэдээллийн хуулбарыг FIC болон нислэгийн удирдлагын төвд илгээнэ.

1.5 Мэдээллийн формат (Format of information)

1.5.1 **Зөвлөмж** – *Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ, METAR, SPECI, TAF, хандлагын урьдчилсан мэдээ, SIGMET, AIRMET мэдээлэл, өндрийн салхи, өндрийн агаарын температурын урьдчилсан мэдээ, тэдгээрийн залруулсан мэдээллээр НХҮ-ний нэгжүүдийг хангах бөгөөд орон нутагт өөрөөр тохиролцоогүй бол бусад нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагад түгээх, эсхүл тэдгээрээс хүлээн авна.*

1.5.2 ***Зөвлөмж*** – *Цаг уурын болон НХҮБ хооронд байгуулсан гэрээний дагуу компьютероор бэлтгэсэн торлосон цэгэн (grid point) дээрх өндрийн агаарын тоон мэдээллүүдийг НХҮ-ний нэгжид тоон дижитал хэлбэрээр хүлээн авах боломжтой компьютертой бол гаргаж өгнө. Тоон мэдээллийг урьдчилсан мэдээллийн боловсруулалт дууссаны дараагаар даруй дамжуулагдах ёстой.*

ГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архив 2
(Албан тушаалын нэр)
Гарын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУЛЬ
Саид
дарын 26 А/17

2. ЭРЭН ХАЙХ, АВРАН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГЖИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ (INFORMATION TO BE PROVIDED FOR SEARCH AND RESCUE SERVICES UNITS)

2.1 Мэдээллийн жагсаалт (List of information)

ЭХАТ төвд өгч буй мэдээлэлд алга болсон агаарын хөлгийн сүүлчийн байршлын болон очих чиглэлийн дагуух цаг агаарын нөхцөл байдалтай холбоотой доорх мэдээллүүдийг багтаана. Үүнд:

a) нислэгийн замын дагуух цаг агаарын онцгой үзэгдлүүд;
b) үүлний хэмжээ, төрөл, ялангуяа бороony бөөн үүл; үүлний суурийн өндөр, дээд хилийн өндөр заагч;
c) АБХ, түүнийг муутгагч үзэгдлүүд;
d) газар орчмын болон өндрийн салхи;
e) газрын гадаргын байдал, тухайлбал: цасан бүрхэц, эсхүл үер;
f) хэрэв эрэн хайх бүс нь далайн түрлэг, урсгалтай бол мөсөн бүрхэц, далайн гадаргын температур, далайн гадаргын байдал;
g) MSL дэх даралт.

2.2 Хүсэлтийн дагуу өгөх мэдээлэл (Information to be provided on request)

2.2.1 **Зөвлөмж** – *Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь алга болсон агаарын хөлгийн багт нислэгийн өмнө өгсөн баримт бичиг, дамжуулсан цаг агаарын урьдчилсан мэдээ, түүнд хийсэн залруулгын тухай аль болох дэлгэрэнгүй мэдээллээр эрэн хайх авран туслах төвийг хангана.*

2.2.2 **Зөвлөмж** – *ЭХАТ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь хүсэлтийн дагуу дараах мэдээллээр байнга хангаж ажиллана. Үүнд:*

a) эрэл хийж буй бүсийн цаг агаарын нөхцөл байдлын талаар аль болох бүрэн хэмжээний дэлгэрэнгүй мэдээлэл;
b) эрлийн нислэг гүйцэтгэж буй агаарын хөлгийн аэродромд ирэх, очих замын, нисэх чиглэлийн, эрэл явагдах газрын цаг агаарын урьдчилсан мэдээлэл.

2.2.3 **Зөвлөмж** – *Эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг зохицуулах төвийн хүсэлтээр Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага нь эрэн хайх, авран туслах ажиллагаа явуулж буй газрын шаардлагатай цаг уурын мэдээллээр хангана.*

3. НИСЭХИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГЖИД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ (INFORMATION TO BE PROVIDED FOR AERONAUTICAL INFORMATION SERVICES UNITS)

3.1 Мэдээллийн жагсаалт (List of information)

НМҮ-ний нэгжийг дараах мэдээллээр хангана. Үүнд:

a) нислэгийн мэдээллийн эмхэтгэлд оруулахад зориулж агаарын навигацид шаардлагатай цаг уурын үйлчилгээний тухай мэдээлэл;

Тайлбар. Мэдээллийн нарийвчлалыг Procedures for Air Navigation Services - Aeronautical Information Management (PANS-AIM (Doc 10066)-ийн Appendix 3-ын Part 1-ийн GEN 3.5 болон Part 3-ын AD 2.2, 2.11, 3.2 болон 3.11- д үзүүлсэн болно.

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВ
Сайд Төрийн
даргын 26 А/17
ХУУЛБАР ҮНЭН
тайлбар түшаалын нэр)
(газрын үсгийн тайлал)
26 01 дугаар сарын 29

b) NOTAM, эсхүл ASHTAM мэдээ бэлтгэхэд шаардлагатай мэдээлэл:
   1) нисэхийн цаг уурын үйлчилгээ үзүүлэхэд нэвтрүүлэх, цуцлах, өөрчлөлт оруулах. Конвенцын Хавсралт 15-ын 6.3.2.2 ба 6.3.2.3-т заасны дагуу NOTAM гаргах боломжтой байхын тулд энэхүү мэдээллийг хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө НМҮ-ний нэгжид өгөх шаардлагатай;
   2) галт уулын идэвхжилийн тохиолдол;

Тайлбар. Шаардлагатай тусгай мэдээллийг Бүлэг 3, 3.3.2 болон Бүлэг 4, 4.8-д үзүүлсэн болно.

   3) цаг уурын болон иргэний нисэхийн байгууллага хооронд байгуулсан гэрээний дагуу цацраг идэвхт бодисын агаар мандалд тархсан тархац;

Тайлбар. Шаардлагатай тусгай мэдээллийг Бүлэг 3, 3.4.2 g)-д үзүүлсэн болно.

c) нисэхийн мэдээллийн цуврал боловсруулахад шаардлагатай дараах мэдээллүүд:
   1) нисэхийн цаг уурын үйлчилгээ, үйл ажиллагаа болон тоног төхөөрөмжид орсон, эсхүл орохоор төлөвлөгдөж буй өөрчлөлтийн тухай;
   2) агаарын хөлгийн үйл ажиллагаанд нөлөөлөх цаг уурын тодорхой үзэгдлүүдийн нөлөө.

ЗЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
бүртгэлийн дугаар 607
ҮҮЛБАР ҮНЭН
Архив 2
(хэрэгжүүлэгч түшаалын нэр)
(гарын үсгийн тайлал)
26 03 21 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУЛЬ
Сайд Төрийн
дарын 26 А/17

Хавсралт 10. Холбооны тоног төхөөрөмжид тавигдах шаардлага болон тэдгээрийн ашиглалттай холбоотой техникийн үзүүлэлт (Technical specifications related to requirements for and use of communications)

(Бүлэг 11-ийг үзнэ үү)

1. ХОЛБООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА (SPECIFIC REQUIREMENTS FOR COMMUNICATIONS)

1.1 Цаг уурын мэдээллийг дамжуулах шаардлагатай хугацаа (Required transit times of operational meteorological information)

Гэрээнд өөрөөр заагаагүй бол цаг уурын мэдээллийг агуулсан мэдээ, товхимлын дамжин өнгөрөх хугацаа 5 минутаас хэтрэхгүй байх ёстой.

1.2 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ болон агаарын тээвэрлэгчид зориулсан торлосон цэгэн (grid point) өгөгдөл (Grid point data for ATS and operators)

1.2.1 **Зөвлөмж** - *Цаг уурын болон НХҮБ хооронд байгуулсан гэрээний дагуу тоон хэлбэрийн торлосон цэгэн (grid point) өндрийн өгөгдлийг НХУ-ний компьютерт ашиглах боломжтойгоор гаргаж дамжуулна.*

1.2.2 **Зөвлөмж** - *Өндрийн торлосон цэгэн (grid point) өгөгдлийг нислэгийн төлөвлөлтөд зориулж агаарын тээвэрлэгчдэд өгөхдөө WAFC, Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага болон холбогдох агаарын тээвэрлэгчидтэй тохиролцсоны дагуу дамжуулах үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ.*

2. НИСЭХИЙН СУУРИН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНЫ ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТ БОЛОН ИНТЕРНЭТ (USE OF AERONAUTICAL FIXED SERVICE COMMUNICATIONS AND THE PUBLIC INTERNET)

2.1 Цаг уурын үсэг, тоон форматтай бюллетен (Meteorological bulletins in alphanumeric format)

2.1.1 Товхимлын агуулга (Composition of bulletins)

Зөвлөмж - *Цаг уурын мэдээллийг боломжтой бол цаг уурын ижил төрлийн мэдээллийн нэгтгэсэн багц хэлбэрээр солилцож болно.*

2.1.2 Товхимлыг гаргах хугацаа (Filing times of bulletins)

Зөвлөмж - *Цаг уурын товхимлыг хуваарийн дагуу заасан хугацаанд тогтмол гаргана. METAR-ийг бодит ажиглалтын хугацаанаас хойш 5 минутаас хожимдуулалгүй дамжуулна. TAF-ийг түүний үйлчилж эхлэх хугацаанаас хамгийн багадаа нэг цагийн өмнө дамжуулна.*

2.1.3 Бюллетений толгой (Heading of bulletins)

Нисэхийн суурин үйлчилгээний холбооны хэрэгсэл, эсхүл интернэт сүлжээний тусламжтай дамжуулж буй цаг уурын товхимлын толгой нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

а) дөрвөн үсэг, хоёр тооны тэмдэглэгээ;

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВИЛ
Архивт
26 01 дугаар 29

b) цаг уурын бюллетен гаргаж буй цаг уурын албаны газар зүйн байршил заагчаар ICAO-д хэрэглэдэг дөрвөн үсгийн код;
c) өдөр - цагийн бүлэг;
d) шаардлагатай тохиолдолд гурван үсгийн код.

Тайлбар 1. Мэдээний толгойн агуулга, хэлбэрийн нарийвчилсан тодорхойлолтуудыг Manual on the Global Telecommunication System (WMO-No. 386) болон Manual of Aeronautical Meteorological Practice (Doc 8896)-д тус тус өгсөн болно.

Тайлбар 2. ICAO-ийн байршил заагчийг Location Indicators (Doc 7910)-д тусгасан болно.

2.1.4 Цаг уурын мэдээлэл агуулсан товхимлын дамжуулалт (Transmission of bulletins containing operational meteorological information)

Цаг уурын мэдээлэл агуулсан товхимлыг нисэхийн суурин холбооны үйлчилгээгээр (AFS) дамжуулна.

2.2 Дэлхийн бүсийн урьдчилан мэдээлэх системийн бүтээгдэхүүн (World area forecast system (WAFS) products)

2.2.1 WAFS-ийн бүтээгдэхүүний хангалтад ашиглагдах цахилгаан холбоо (Telecommunications for the supply of WAFS products)

Зөвлөмж - *WAFS-ийн бүтээгдэхүүнүүдийг гаргахад ашигладаг цахилгаан холбооны хэрэгсэл нь нисэхийн суурин холбооны үйлчилгээ, эсхүл интернэт байх ёстой.*

2.2.2 Зургийн чанарын шаардлага (Quality requirements for charts)

Зөвлөмж - *WAFS-ийн бүтээгдэхүүнүүдийг график хэлбэрээр дамжуулж байгаа тохиолдолд хүлээн авсан зургийн чанар нь нислэгийн төлөвлөлт, баримт бичигт хангалттай гаргацтай хэлбэрээр хуулбарлах боломжтой байх ёстой. Хүлээн авсан зургууд нь талбайнхаа 95-аас дээш хувийг унших боломжтой байх ёстой.*

2.2.3 Дамжуулалтын чанарын шаардлага (Quality requirements for transmissions)

Зөвлөмж - *Дамжуулалтын хувьд 6 цагийн хугацаанд тасалдал 10 минутаас хэтрэхгүй байх ёстой.*

2.2.4 WAFS-ийн бүтээгдэхүүнийг агуулсан товхимлын толгой (Heading of bulletins containing WAFS products)

Нисэхийн суурин холбооны үйлчилгээ, эсхүл интернэтээр дамжуулах тоон хэлбэртэй WAFS-ийн бүтээгдэхүүнүүд агуулсан цаг уурын бюллетен 2.1.3-т заасан толгойтой байна.

3. НИСЭХИЙН ХӨДӨЛГӨӨНТ ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТ (USE OF AERONAUTICAL MOBILE SERVICE COMMUNICATIONS)

3.1 Цаг уурын мэдээний агуулга болон формат (Content and format of meteorological messages)

3.1.1 Агаарын хөлөгт дамжуулж буй бодит ажиглалтын болон урьдчилсан мэдээ, SIGMET-ийн агуулга ба формат нь энэ баримт бичгийн Бүлэг 4, 6 болон 7-д заасны дагуу тохирч байх ёстой.

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Архивч Чанцэг
26 01 29
26 А/17

3.1.2 Агаарын хөлгөөс дамжуулж буй мэдээний агуулга, форматыг энэ баримт бичгийн Бүлэг 5 болон Procedures for Air Navigation Services - Air Traffic Management (PANS-ATM (Doc 4444)-ийн Appendix 1-д тусгасан болно.

3.2 Цаг уурын товхимлын агуулга ба формат (Content and format of meteorological bulletins)

Нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээгээр дамжуулж буй цаг уурын товхимлын агуулга нь мэдээллийн эх хувилбартайгаа ижил байна.

4. НИСЭХИЙН РАДИО НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АШИГЛАЛТ - VOLMET РАДИО НЭВТРҮҮЛЭГ (USE OF AERONAUTICAL BROADCASTS SERVICE - VOLMET BROADCASTS)

4.1 VOLMET радио нэвтрүүлэгт агуулагдах цаг уурын мэдээллийн нарийвчлал (Detailed content of meteorological information to be included in VOLMET broadcasts)

4.1.1 VOLMET радио нэвтрүүлэгт METAR, SPECI, TAF-ийг оруулах аэродромууд, тэдгээрийг дамжуулах дараалал, нэвтрүүлэх цагийг бүсийн агаарын навигацийн гэрээгээр тогтооно.

4.1.2 SIGMET мэдээг хуваарьт VOLMET радио нэвтрүүлэгт оруулах FIR-үүдыг бүсийн агаарын навигацийн гэрээгээр тодорхойлно. Хэрэв гэрээнд тэдгээрийг оруулах талаар заасан бол SIGMET мэдээ нь дамжуулалтын эхэнд, эсхүл 5 минутын хугацаанд дамжина.

4.2 VOLMET радио нэвтрүүлэгт багтах мэдээллийн шалгуур (Criteria related to information to be included in VOLMET broadcasts)

4.2.1 **Зөвлөмж** - *Аэродромоос мэдээлэл хугацаандаа ирээгүй тохиолдолд хамгийн сүүлийн мэдээг ажиглалтын цагтай хамт нэвтрүүлэгт оруулна.*

4.2.2 **Зөвлөмж** - *Хуваарьт VOLMET өргөн нэвтрүүлэгт өгч буй TAF мэдээг шаардлагатай тохиолдолд залруулга хийж байна. Мэдээ дамжсан тохиолдолд тухайн цаг уурын байгууллагын хамгийн сүүлчийн мэдээ гэж ойлгоно.*

4.2.3 **Зөвлөмж** - *SIGMET мэдээг хуваарьт VOLMET радио нэвтрүүлэгт оруулсан тохиолдолд холбогдох FIRs-д SIGMET мэдээ хүчинтэй биш бол "NIL SIGMET" гэсэн заалтыг дамжуулна.*

4.3 VOLMET радио нэвтрүүлэгт агуулагдах мэдээллийн формат (Format of information to be included in VOLMET broadcasts)

4.3.1 VOLMET радио нэвтрүүлэгт агуулагдах бодит болон урьдчилсан мэдээний агуулга ба формат нь энэ баримт бичгийн Бүлэг 4,6 болон 7-д заасан журамтай тохирч байна.

4.3.2 **Зөвлөмж** – *VOLMET радио нэвтрүүлэг нь радио холбооны хэвшмэл стандарт хэллэгийг ашиглана.*

Тайлбар - VOLMET радио нэвтрүүлэгт ашиглагдах радио холбооны стандарт хэллэгийн заавырыг Manual on Coordination between Air Traffic Services, Aeronautical Information Services and Aeronautical Meteorological Services (Doc 9377)-ийн Appendix 1-д үзүүлсэн болно.

ХУУЛБАР ҮНЭН
Архив
(Албан тушаалын нэр)
Чагуи
(гарын үсэг)(гарын үсгийн тайлбар)
2026 оны 01 дугаар сарын 29

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭЖ ХУУЛ
Саид Тарни
Дэлгэ 26 А/17

Нэмэлт А. Хэмжилт, эсхүл ажиглалтын хүлцэж болох хязгаарлал (Operationally desirable accuracy of measurement or observation)

Тайлбар. Энэ хүснэгтэд байгаа заавар нь Бүлэг 2-ын 2.2, ялангуяа 2.2.7 болон Бүлэг 4-т хамаарна.

Бодит ажиглалтын элемент	Ажиглалтын нарийвчлал
Газар орчмын салхины дундаж чиглэл	Чиглэл: ±10° Хурд: ±0,5м/с (1kt)-ээс 5м/с (10kt) 5м/с (10kt)-аас дээш ±10%
Газар орчмын салхины дундаж хурдны хазайлт	1м/с (2kt), зурвасын дагуух болон хажуугийн салхины хувьд
АБХ	600м хүртэл ±50м 600м-ээс 1500м хооронд ±10% 1500м-ээс дээш ±20%
ХБЗ-ын дагуух АБХ	400м хүртэл ±10м 400м-ээс 800м хооронд ±25м 800м-ээс дээш ±10%
Үүлний хэмжээ	± 1октант
Үүлний өндөр	100м (330ft) хүртэл ±10м (33ft) 100м (330ft)-ээс дээш ±10%
Агаарын температур болон шүүдэр цэгийн температур	±1°C
Даралтын утга (QNH, QFE)	±0.5гПа

Тайлбар. Ажиглалт, эсхүл хэмжилтийн тодорхой бус байдлын талаарх зааврыг Guide to Meteorological Instruments and Methods of Observation (WMO-No. 8)-аас үзнэ үү.

...ЛЫН ГАЗРЫН, УУР АМЬСГАЛЫН ҮЙЛЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архивч
(албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлбар)
2026 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Дугаар 26 А/17

Нэмэлт В. Урьдчилсан мэдээний хүлцэж болох хязгаарлал (Operationally desirable accuracy of forecasts)

Тайлбар 1. Энэ хүснэгтэд байгаа заавар нь Бүлэг 2-ын 2.2, ялангуяа 2.2.8 болон Бүлэг 6-д хамаарна.

Тайлбар 2. Хэрэв урьдчилсан мэдээний хүлцэж болох хязгаарлал нь 2 дахь баганад үзүүлсэн хязгаарт хэвээр байвал 3 дахь баганад заасан тохиолдлын хувьд алдааны нөлөөг харьцуулахдаа ноцтой гэж үзэхгүй.

Урьдчилан мэдээлж буй элемент	Урьдчилсан мэдээний онч	Хангамж
	TAF	
Салхины чиглэл	±20°	тохиолдлын 80%
Салхины хурд	±2.5м/с (5kt)	тохиолдлын 80%
АБХ	800м хүртэл ±200м 800м-ээс 10км хүртэл ±30%	тохиолдлын 80%
Хур тунадас	Ажиглагдсан, эсхүл ажиглагдаагүй	тохиолдлын 80%
Үүлний хэмжээ	450м (1500ft)-ээс доош нэг ангиллаар; 450м (1500ft)-ээс 3000м (10000ft) хооронд BKN, эсхүл OVC хэмжээтэй үүл ажиглагдсан, эсхүл ажиглагдаагүй	тохиолдлын 70%
Үүлний өндөр	300м (1000ft) хүртэл ±30м (100ft) 300м (1000ft)-ээс 3000м (10000ft)-ын хооронд ±30%	тохиолдлын 70%
Агаарын температур	±1°C	тохиолдлын 70%
	ХАНДЛАГЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ (TREND FORECAST)	
Салхины чиглэл	±20°	тохиолдлын 90%
Салхины хурд	±2.5м/с (5kt)	тохиолдлын 90%
АБХ	800м хүртэл ±200м 800м-ээс 10км хүртэл ±30%	тохиолдлын 90%
Хур тунадас	ажиглагдсан, эсхүл ажиглагдаагүй	тохиолдлын 90%
Үүлний хэмжээ	450м (1500ft)-ээс доош нэг ангиллаар; 450м (1500ft)-ээс 3000м (10000ft) хооронд BKN, эсхүл OVC хэмжээтэй үүл ажиглагдсан, эсхүл ажиглагдаагүй	тохиолдлын 90%
Үүлний өндөр	300м (1000ft) хүртэл ±30м (100ft) 300м (1000ft)-ээс 3000м (10000ft) хүртэл ±30%	тохиолдлын 90%
	ХӨӨРӨЛТИЙН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ (FORECAST FOR TAKE OFF)	
Салхины чиглэл	±20°	тохиолдлын 90%
Салхины хурд	12.5м/с (25kt) хүртэл ±2.5м/с (5kt)	тохиолдлын 90%
Агаарын температур	±1°C	тохиолдлын 90%
Даралтын утга (QNH)	±1гПа	тохиолдлын 90%

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЗӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
бүртгэлийн дугаар 67
ХУУЛБАР ҮНЭН
Архив г
(албан тушаалын нэр)
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
25 06 оны 01 дүгээр сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭЖ ХУУЛ
Сайд Тэмүүлэн
Дарга 26 А/17

БҮСИЙН БОЛОН ЧИГЛЭЛИЙН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ (AREA, FLIGHT AND ROUTE FORECASTS)

Өндрийн агаарын температур	±2°C *(900км(500NM)-ын дундаж)*	тохиолдлын 90%
Харьцангуй чийгшил	±20%	тохиолдлын 90%
Өндрийн салхины хурд	±5м/с (10kt) *(900км(500NM)-ийн векторын зөрүүний модуль*	тохиолдлын 90%
Чиглэлийн онцгой үзэгдэл болон үүл	Ажиглагдсан, эсхүл ажиглагдаагүй	тохиолдлын 80%
	Байршил: ±100км (60NM)	тохиолдлын 70%
	Босоо хэмжээ: ±300м (1000ft)	тохиолдлын 70%
	Тропопаузын нислэгийн түвшин: ±300м (1000ft)	тохиолдлын 80%
	Хамгийн их салхины түвшин: ±300м (1000ft)	тохиолдлын 80%

1. *Ерөнхий зүйл (General Provisions)

1.1 *Энэхүү зааврыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан нислэгийн цаг агаарын урьдчилсан мэдээ (хүлцэж болох хязгаарлал)-д тавих шаардлагыг үндэслэн боловсруулав.

1.2 *Нислэгийн цаг уурын үйлчилгээг үзүүлж буй байгууллагууд аэродром орчмын, нутаг дэвсгэрийн болон нислэгийн чиглэлийн цаг агаарын бүх төрлийн урьдчилсан мэдээг энэхүү зааврыг баримтлан дүгнэнэ.

1.3 *Цаг агаарын урьдчилсан мэдээг уул мэдээнд өгсөн цаг агаарын нөхцөл байдал, түүний өөрчлөлтийн бүлгийн нөхцөлийг харгалзан бодит байдалтай харьцуулан үзэх зарчмаар дүгнэнэ.

1.4 *Аэродром орчмын урьдчилсан мэдээг дүгнэхдээ үйлчлэх хугацаанд нь хамруулан, үндсэн хэсэг болон өөрчлөлтийн бүлгийн хугацааг давхцуулахгүй байх зарчмыг баримтална.

1.5 *Урьдчилан мэдээлж буй элементийн хангамжийг гаргахдаа таарсан тохиолдлын тоог нийт ажиглалтын мэдээний тоонд харьцуулан хувиар бодож гаргах бөгөөд урьдчилсан мэдээний таарцыг нийт урьдчилсан мэдээнд өгсөн цаг уурын элементүүдийн хангамжийг дундажлан хувиар бодож гаргана.

1.6 *Цаг агаарын бодит мэдээний хангалт хийх боломжгүй газруудад нислэг үйлдэх үед "Тойм" мэдээгээр үйлчилнэ. "Тойм" мэдээгээр үйлчилсэн тохиолдолд мэдээг дүгнэхгүй.

2. *Урьдчилсан мэдээг дүгнэх (verifying forecasts)

2.1 *Нислэгийн чиглэлийн болон районы урьдчилсан мэдээг нислэгийн замын дагуух болон аэродромын ойролцоох (50 км доторх) цаг уурын өртөө, харуулын мэдээ, нисэх багаас авсан агаарын хөлгийн мэдээг үндэслэн дүгнэнэ.

2.2 *Аэродром орчмын урьдчилсан мэдээг тухайн аэродромын эргэн тойронд 10 км-ийн доторх цаг уурын өртөө, харуулын мэдээг үндэслэн

дүгнэх бөгөөд цаг агаарын үзэгдэл ажиглагдсан тохиолдолд тухайн аэродромын эргэн тойронд 50км-ийн доторх цаг уурын өртөө, харуулын мэдээ, нисэх багаас авсан агаарын хөлгийн мэдээ, цаг уурын радарын болон хиймэл дагуулын үүлний зураг болон бусад мэдээллийг үндэслэн дүгнэнэ.

2.3 *Урьдчилсан мэдээнд өгсөн тухайн үзэгдэл, элементийн утга нь аэродромын хязгаарлалаас даваагүй бөгөөд уг мэдээний үйлчлэх хугацааны турш бодит байдалд тухайн үзэгдэл, элементийн утга нь мөн аэродромын хязгаарлалаас даваагүй бол тухайн үзэгдлийн урьдчилсан мэдээг "Урьдчилсан мэдээний хүлцэж болох хязгаарлалын хүснэгт"-ийг харгалзан үзэхгүйгээр "таарсан" гэж дүгнэнэ.

2.4 *Хэрэв хоёр, эсхүл түүнээс дээш цаг агаарын үзэгдлийг хамт мэдээлсэн тохиолдолд аль нэг нь ажиглагдвал "таарсан" гэж дүгнэнэ.

2.5 *Үүлшил, цаг агаарын үзэгдэл түүний байршил болон эрчимшлийг дүгнэхдээ хиймэл дагуулын болон цаг уурын радарын үүлшлийн мэдээ, тухайн нисэх буудлын бүсэд багтаж байгаа "Аюулгүйн бүс"-ийн цаг уурын өртөө, харуулын мэдээг ашиглана.

2.6 *Аэродром орчмын урьдчилсан мэдээг доор заасан "Урьдчилсан мэдээний хүлцэж болох хязгаарлалын хүснэгт"-ийг баримтлан цаг агаарын бодит мэдээтэй харьцуулан дүгнэнэ.

2.7 *Урьдчилсан мэдээнд өгсөн уулсын харагдцыг дүгнэхдээ:
- "Уулс хаалттай", эсхүл "Зарим уул хаалттай" гэж өгсөн тохиолдолд бүх уулс, эсхүл тухайн аэродромын суулт, хөөрөлтийн чиглэлийн уулс ил бол "тараагүй" бусад тохиолдолд "таарсан";
- "Уулс ил" гэж өгсөн бол бүх уулс, эсхүл тухайн нисэх буудлын суулт, хөөрөлтийн чиглэлийн уулс хаалттай тохиолдолд "тараагүй" бусад тохиолдолд "таарсан" гэж дүгнэнэ.

2.8 *Аэродром орчмын урьдчилсан мэдээний өөрчлөлтийн бүлгийг тусад нь "Урьдчилсан мэдээний хүлцэж болох хязгаарлалын хүснэгт"-ийн дагуу дүгнэх бөгөөд дараах зарчмыг баримтална.

a) FMYYGGgg бүлэгт өгсөн цаг агаарын үзэгдэл, элементийн өөрчлөлтийг YYGGgg хугацаанаас эхлэн тооцож дүгнэнэ.

b) BECMG YYGG/YeYeGeGe бүлэгт өгсөн цаг агаарын үзэгдэл, элементийн аажим өөрчлөлтийг YYGG-ээс YeYeCeCe хугацааны хооронд эхэлнэ гэж үзэх бөгөөд энэ хугацаанд уг үзэгдэл ажиглагдаж эхэлсэн бол тухайн хугацаанаас эхлэн тооцож дүгнэнэ.

c) TEMPO YYGG/YeYeGeGe бүлэгт өгсөн цаг агаарын үзэгдэл, элементийн тогтворгүй өөрчлөлтийг YYGG-ээс YeYeCeCe хугацааны хооронд болно гэж үзэх бөгөөд тухайн үзэгдэл, элементийн утга нь өөрчлөлтийн бүлэгт заасан хугацаанд дор хаяж нэг удаа "Урьдчилсан мэдээний хүлцэж болох хязгаарлалын хүснэгт"-ийн хүлцэж болох утгад хүрч байвал таарсан гэж дүгнэнэ.

d) PROBCeCe YYGG/YeYeGeGe ба PROBCeCe TEMPO YYGG/YeYeGeGe бүлэгт өгсөн цаг агаарын үзэгдэл, элементийн өөрчлөлт нь бодит байдалд ажиглагдсан тохиолдолд уг өөрчлөлтийн бүлэгт өгсөн үзэгдлийг таарсан гэж дүгнэнэ. Бусад тохиолдолд дүгнэхгүй.

ХУУЛБАР ҮНЭН
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУУЛ
Сайд
Дарга

2.9 *"Нарийвчилсан" урьдчилсан мэдээг үйлчлэх хугацаанд нь хамруулж дүгнэх бөгөөд өмнөх хүчингүй болгосон урьдчилсан мэдээг дүгнэхгүй.

2.10 *Урьдчилсан мэдээнд өгсөн үзэгдэл элементийн таарц (хангамж)-ыг хүлцэх хязгаарт багтсан болон багтаагүй үзэгдэл, элементийн тоог үндэслэн хувиар бодож гаргана.

2.11 *Хэрэв буудал орчмын урьдчилсан мэдээнд дуу цахилгаан ба мөндөр мэдээлсэн бол түүнийг дүгнэхдээ нисэх буудлын бүсэд дуу цахилгаан, мөндрийн голомт байсан эсэх тухай агаарын хөлгийн мэдээ, цаг уурын радарын мэдээлэл, нисэх буудлын бүсэд багтаж байгаа аюулгүйн бүсийн цаг уурын өртөө, харуулын мэдээллийг ашиглах бөгөөд нисэх буудал орчимд 3-4 октант, эсхүл түүнээс их хэмжээтэй бороонь бөөн үүл (CB), гялбаа ажиглагдсан байвал "таарсан", бусад тохиолдолд "тааараагүй" гэж дүгнэнэ.

...Ы ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ҮЙЛЧЛЭЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архив 2
(Хуулбар тушаалын нэр)
Чанууа
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2016 оны 01 дүгээр сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУЛБ
Сайд Төрийн ...
Дансын 26 ... А/17

Нэмэлт С. Аэродромын мэдээнд хэрэглэх сонгогдсон шалгуур (Selected criteria applicable to aerodrome reports)

(Энэ хүснэгтийн заавар нь Бүлэг 4 болон Хавсралт 3-тай холбоотой.)

Газар орчмын салхи				АБХ			ХБЗ-ын дагуух АБХ[1] A −10 B −5 C (цаг, мин)		Цаг агаарын үзэгдэл	Үүлшил					Температур	Даралт (QNH,QFE)		Нэмэлт мэдээлэл
Чиглэлийн хазайц[3]			Хурдны хазайц[3]	Чиглэлийн хазайц[4]			Өнгөрсөн хугацааны хандлага[5]			Хэмжээ				Төрөл[2]				
					Онцгой тохиолдолд Хамгийн бага АБХ≠ давамгайлах АБХ		$R_{(AB)}$ -$R_{(BC)}$			Давхаргууд								
Тодорхойлолт	Дундаж хурд	≥180°	5м/с (10kt)-ээс давсан дундаж хурд	Ерөнхий дүрэм	Хамгийн бага АБХ <1500м эсхүл <0.5×давамгайлах АБХ	АБХ хэлбэлзэлтэй болон давамгайлсан АБХ тодорхойлох боломжгүй	<100м	≥100м	Бүх үзэгдэлд хамаарах ерөнхий шалгуур байхгүй (тодорхой шалгуурыудыг Appendix 3, 4.4.2-ийг үзнэ үү)	Хамгийн нам давхарга	Дараагийн давхарга >	Дараагийн өндөр давхарга >	CB[6] эсхүл TCU	Заагч	Шалгуургүй	Параметрүүд мэдээлэгдсэн	Хэрэв өөрчлөгдсөн бол шинэчлэх >зөвшөөрөгдсөн хэмжээ	Параметрүүд багтсан
1.5 м/с 3kt)	1.5 м/с 3 kt)																	
Тухайн газрын байнгын болон тусгай мэдээ	2/10 мин [7] VRB + 2 (Чиглэлийн эрс өөрчлөлт)	2/10 мин [7] VRB + 2 (Чиглэлийн эрс өөрчлөлт)	2 мин VRB (эрс өөрчлөлтгүй)	10 мин [8] Хамгийн их болон хамгийн бага хурд	1 мин Зурвасын дагуух АБХ	N/A	N/A	1мин N/A[9]		Байнга	2/8	4/8	Байнга	CB TCU		QNH, QFE [10]	Тийм	Бүгд[11]
METAR/SPECI	10 мин VRB (эрс өөрчлөлттүй)	10 мин дундаж + 2 (Чиглэлийн эрс өөрчлөлт)	10 мин VRB(эрс өөрчлөлтгүй)	10 мин[8] Хамгийн их хурд	10 мин Давамгайлах АБХ	Давамгайлах АБХ болон хамгийн бага АБХ+чиглэл	Хамгийн бага АБХ	10мин Хандлага ажиглагдаагүй ("N")	Дээш ("U") эсхүл доош ("D")	Байнга	2/8	4/8	Байнга	CB TCU		QNH	Үгүй	Үйл ажиллагаанд онцгой үзэгдэл болон салхины шилжлэг[12]
Бүх мэдээнд холбогдох хэмжээнүүд	Чиглэлийг 10°-ын нарийвчлалтай (1-4 градус доош, 5-9 градус дээш)			хурд 1м/с (1kt) хурд<8.5м/с (1kt) заасан боп намуун	АБХ<800м :50м 800м≤АБХ<5000м :100м 5000м≤АБХ<10км :1км АБХ≥ 10км :10км эсхүл CAVOK			RVR <400м :25м 400м≤ RVR <800м :50м 800м≤ RVR <2000м :100м[13]	-	Суурийн өндөр≤3000м (10000ft) :30м (100ft) (Хянах түвшин: аэродромын өндөр эсхүл далайн байгуулламжийн дайлын дундаж түвшин)					Бүхэл градус болгох: 0,5-аас дээш бол	1-9 хүртэлх аравтын гПа-ын утыг доод утгад шилжүүлж авна		-

Тайлбар.

1. *Сүүлийн 10 минутын турш тооцсон (үл хамаарах зүйл: хэрэв 10 минутын хугацаанд тасалдсан бол (тухайлбал: ХБЗ-ын дагуух АБХ өөрчлөгддөг, эсхүл 175м, 300м, 550м, эсхүл 800м-ийг хүрэх, ≥ 2 минут үргэлжилдэг)), зөвхөн тасалдсаны дараах өгөгдлийг ашиглана. ХБЗ-ын дагуух АБХ-ын шалгуур үзүүлэлтүүд, тухайлбал, АВ, ВС, АС зэрэгт хамаарах ажиглалтын өмнөх 10 минутын хугацааны эдгээр хэсгүүдийг дүрслэхийн тулд энгийн бүдүүвчийг ашигладаг.*
2. *Энгийн суурьтай CB, эсхүл TCU-аас бүрдэх давхаргыг "CB" гэж мэдээлнэ.*
3. *Сүүлийн 10 минутын турш тооцсон (үл хамаарах зүйл: хэрэв 10 минутын хугацаанд тодорхой тасалдалтай (тухайлбал: чиглэл нь ≥ 30 °, ≥ 5 м/с хүрдтай, эсхүл хурд нь ≥ 5 м/с, ≥ 2 минут үргэлжилдэг) өөрчлөгдвөл), зөвхөн тасалдсаны дараах өгөгдлийг ашиглах).*
4. *Хэрэв хэд хэдэн чиглэл байвал үйл ажиллагаанд хамгийн чухал чиглэлийг ашиглана.*

5. *R5(AB)= AB үеийн ХБЗ-ын дагуух АБХ-ын 5 минутын дундаж утга ба R5(BC) = BC үеийн 5 минутын ХБЗ-ын дагуух АБХ-ын дундаж утгыг авна.*
6. *CB (cumulonimbus) болон TCU (towering cumulus = хөгжингүй бөөн үүлний босоо тархац) хэрэв бусад давхаргын аль нэг гэж заагаагүй бол.*
7. *Зүүн дээд буланд дундаж утгыг, хэрэв боломжтой бол хэт их утгын лавлах хугацааг заана.*
8. *Кодын гарын авлагын Manual on Codes (WMO-No. 306), Volume I.1, Part A - Alphanumeric Codes, paragraph 15.5.5-д заасны дагуу “салхины хэмжилтийн систем нь салхины оргил үеийг гурван удаа илэрхийлж байхаар байхыг зөвлөж байна.*
9. *N/A-хамаарахгүй.*
10. *Шаардлагатай бол QFE-ийг оруулна. QFE-ийн жишиг өндөр нь нарийвчлалтай ойртох ХБЗ-аас бусад нь аэродромын өндөр байх ёстой бөгөөд ≥ 2м (7ft)-аас доош босго, эсхүл түүнээс дээш босго бүхий нарийвчлалгүй ойртох ХБЗ байх ба энд жишиг түвшин нь холбогдох босго өндөр байх ёстой.*
11. *Хавсралт 3-ын 4.8-д заасны дагуу.*
12. *Далайн гадаргын температур, далайн төлөв байдал, эсхүл бүсийн агаарын навигацийн гэрээний дагуу далайн байгууламжаас үүссэн мэдэгдэхүйц долгионы өндөр.*
13. *RVR, эсхүл VIS < 1500м, үнэлгээний хязгаар 50м болон 2000м бол мэдээлэх.*
14. *Нарийвчлалтай ойртолтын хөөрөх зурвас бүхий аэродромуудад буухад босго өндрөөс ≥ 15м-ээс доош байх үед босго өндрийг жишиг болгон ашиглана.*
15. *0.1гПа-аар хэмжсэн.*

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ ЭХ ХУВЬ

Нэмэлт D. Багажийн заалтыг ХБЗ-ын дагуух АБХ болон АБХ руу хөрвүүлэх (Conversion of instrumented readings into runway visual range and visibility)

(Хавсралт 3-ын 4.3.5-ыг үзнэ үү)

1. Багажийн заалтыг ХБЗ-ын дагуух АБХ болон АБХ руу хөрвүүлэлт нь Кошмейдэрийн хууль, эсхүл нисгэгч ХБЗ болон түүний тэмдэглэгээ, эсхүл ХБЗ-ын гэрлээс үндсэн харааны чиг авах боломжтой эсэхээс хамааран Аллардын хуульд үндэслэдэг.

2. Кошмейдэрийн хуульд анхаарах ёстой хүчин зүйлүүдийн нэг нь туршилтын тодосгогч босго юм. Тогтмол утгыг 0.05 (хэмжих боломжгүй) гэж авна.

3. Аллардын хуульд тохирох хүчин зүйл нь гэрэлтүүлгийн босго юм.Энэ нь тогтмол биш ч үргэлжлэх функц нь дэвсгэр гэрэлтүүлгээс хамаарна. Дэвсгэр гэрэлтүүлгийн мэдрүүрээр гэрэлтүүлгийн босгын үргэлжилсэн тохируулгатай багажаар тоноглогдсон системд ашиглаж болох тохируулгыг Зураг D-1 дээрх муруйгаар үзүүлэв. Зураг D-1-д үзүүлсэн шиг алхмын функцийг ойролцоолсон тасралтгүй функцийг ашиглах нь илүү нарийвчлалтай тул 4-р зүйлд тодорхойлсон шаталсан хамаарлаас илүүд үзнэ.

4. Дөрвөн утгыг алхмын функц хэлбэрээр D-1 зурагт үзүүлэв; илүү тодорхой болгох үүднээс тэдгээрийг Хүснэгт D-1-д үзүүлсэн болно.

Тайлбар 1. ХБЗ-ын дагуух АБХ-ыг үнэлэхэд ашиглах ХБЗ-ын гэрэлтүүлгийн мэдээлэл болон зааврыг Manual of Runway Visual Range Observing болон Reporting Practices (Doc 9328)-д үзүүлсэн болно.

Тайлбар 2. Агаарын навигацийн зориулалтаар ашиглах АБХ-ын тодорхойлолтын дагуу гэрэлтүүлгийн хүчний үзэгдэх орчны үнэлгээ нь 1000cd орчимд байна.

Хүснэгт D-1. Гэрэлтүүлгийн босго алхмууд

Нөхцөл	Гэрэлтүүлгийн босго алхмууд (lx)	Гэрэлтүүлгийн босго алхмууд (cd/m^2)
Шөнө	8×10^{-7}	≤50
Үүрээр	10^{-5}	51-999
Энгийн өдөр	10^{-4}	1000-12000
Нартай өдөр	10^{-3}	>12000

УУР АМЬСГАЛЫН ТЭЙН ЯАМ 607 Р УНЭН Архивч (үйлчилгээний нэр) Мануал (гарын үсэг)(гарын үсгийн тайлал) 2026 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ ЭХ ХУВЬ Саид Тэрийн ... Даргын 26 ...



Зураг D-1. Гэрэлтүүлгийн босго Er(lx) ба дэвсгэр гэрэлтэлт B-ийн хоорондын хамаарал

ЗАМ, УУР АМЬСГАЛЫН ЕРӨНХИЙН ЯАМ
Архивт дугаар 607
ХЭЛТЭГДЭР УНЭН
Архивт
(хүчингүй болсон нэр)
Чанзуг
(гарын үсэг)(сарын үсгийн тайлал)
2026 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Санд Тариин
дарын 26 А/17

Нэмэлт Е: Холбогдох баримт бичгүүд

Нисэхийн цаг уурын үйлчилгээнд дор дурдсан баримт бичгүүдийг мөрдөнө.

Хүснэгт F-1. ОУИНБ болон ДЦУБ-ын баримт бичгүүд

№	Баримт бичиг	Нэр (Англи)	Нэр (Монгол)
1	Иргэний нисэхийн тухай хууль		
2	Цаг уур орчны хяналт шинжилгээний тухай хууль		
3	ИНД-174	CAR 174	Иргэний нисэхийн дүрэм 174-Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт
4	АС-174-01	Aviation Meteorological Service Organisations – Certification	Зөвлөмжийн цуврал -Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт
5	Конвенцын Хавсралт 3	Meteorological Service for International Air Navigation	Олон улсын агаарын навигацийн цаг уурын үйлчилгээ Конвенцын Хавсралт 3
6	Конвенцын Хавсралт 11	Air Traffic Services (MET related issues only);	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ Конвенцын Хавсралт 11
7	Конвенцын Хавсралт 15	Aeronautical Information Services (MET related issues only);	Нисэхийн мэдээллийн үйлчилгээ Конвенцын Хавсралт 15
8	Конвенцын Хавсралт 19	Safety Management System;	Аюулгүй байдлын удирдлага Конвенцын Хавсралт 19
9	Doc 8896	Manual of Aeronautical Meteorological Practice	Нисэхийн цаг уурын үйлчилгээний гарын авлага
10	Doc 9377	Manual on Coordination between Air Traffic Services, Aeronautical Information Services and Aeronautical Meteorological Services	Агаарын тээврийн үйлчилгээ, Нисэхийн мэдээллийн үйлчилгээ, Нисэхийн цаг уурын үйлчилгээ хоорондын хамтын ажиллагааны гарын авлага
11	Doc 9328	Manual of Runway Visual Range Observing and Reporting Practices	RVR-ын ажиглалт болон мэдээлэх зарчмын гарын авлага
12	Doc 9817	Manual on Low-level Wind Shear	Нам өндөр дэх салхины шилжлэгийн гарын авлага
13	Doc 9837	Manual on Automatic Meteorological Observing Systems at Aerodromes	Аэродром дахь цаг уурын автомат ажиглалтын системийн гарын авлага

№	Баримт бичиг	Нэр (Англи)	Нэр (Монгол)
14	Doc 4444	Procedures for Air Navigation Services – Air Traffic Management	Агаарын навигацид үйлчлэх журам (Нислэгийн хөдөлгөөний менежмент)
15	PANS-MET (Doc 10157)	Procedures for air navigation services (Meteorology)	Агаарын навигацийн үйлчилгээний журам (Цаг уур)
16	Asia pacific robex handbook	Robex handbook	Ази Номхон далайн бүсийн мэдээлэл солилцооны гарын авлага
17		Asia/pacific regional sigmet guide	Ази номхон далайн бүсийн SIGMET мэдээний гарын авлага
18	WMO-No.49, Volume I	Technical Regulations Basic Documents No. 2 Volume II – Meteorological Service for International Air Navigation	ДЦУБ- Техникийн зохицуулалт, стандарт, Боть II, Олон улсын агаарын навигацийн үйлчилгээ дэх цаг уурын үйлчилгээ
19	WMO-No.1083, Volume I	WMO Guide to Implementation of Education and Training Standards in Meteorology and Hydrology	Ус, цаг уурын боловсрол, сургалтын стандартыг хэрэгжүүлэх заавар
20	WMO-No.306	Manual on Codes International Codes Volume I.1 Конвенцын Хавсралт II to the WMO Technical Regulations	ДЦУБ-ын цуврал №306 "Кодын гарын авлага", I боть
21	WMO-No.114	Qualifications and training of meteorological personnel employed in the provision of meteorological services for international air navigation	Олон улсын агаарын навигацийн цаг уурын үйлчилгээ үзүүлэх цаг уурын ажилтны мэргэшил, сургалт
22	WMO-No.8	Guide to Instruments and Methods of Observation (Volume I Measurement of Meteorological Variables)	Ажиглалт хийх арга зүй ба тоног төхөөрөмжийн заавар (Боть I Цаг уурын үзүүлэлтүүдийн хэмжилт)
23	WMO-No.731	Guide to Meteorological Observing and Information Distribution Systems for Aviation Weather Services	Нисэхийн цаг уурын үйлчилгээ дэх цаг уурын ажиглалтын болон мэдээлэл дамжуулах системийн заавар
24	WMO-No.732	Guide to Services for Aviation	Нисэхийн цаг уурын үйлчилгээний заавар
25	WMO-No.1205	Guide to Competency	Ур чадварын гарын авлага
26	WMO-No.904	Guide to Aeronautical Meteorological Services Cost Recovery	Агаарын навигацийн цаг уурын үйлчилгээний төлбөрийн гарын авлага

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
Бүртгэлийн дугаар 607
ХУУЛБАР ҮНЭН
Архив г
(Албан тушаалын нэр)
Цэцүүл
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)
2026 оны 01 дугаар сарын 29

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВ
Сайд Төрийн
Дарын 26 А/17